Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

**"АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

| Дугаар | ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/ | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | 2023 оны Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **НЭГ.“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | | | | |
| **1.1** | **“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлнэ** | | | | | | | | | | |
| 1.1.1.1 | “Ковид-19” халдварт цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ | Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, | 2021-2023 | АЗДТГ, ХХҮГ | ОНТ | 120 | 0 | 14 | 50 | Коронавируст халдвар /ковид-19/ цар тахал, өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эрүүл ахуйн халдвар хамгаалал, хүнсний чанар аюулгүй байдлын чиглэлээр телевизэд 2, радиод 1, байгууллагын вэб сайтад 45 удаа 212 зөвлөмж, сэрэмжлүүлэг, Facebook хуудсаар 4 төрлийн сэрэмжлүүлэг, 19 ном хэвлэмэл хуудас , 11 контент, 24 төрлийн постер, шторк, 216 удаа фото болон видео бусад мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулсан. Салбарын сургалтыг 5 сэдвээр 5 удаа зохион байгуулж, 110 аж ахуйн нэгж байгууллагын 626 иргэн хамрагдсан байна. | 100 |
| 1.1.1.2 | | Аж ахуйн нэгж, байгууллагуудын ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмолжуулж, хяналт тавьж ажиллана. | 2021-2023 | АЗДТГ, ХХҮГ | ОНТ | 60 | 45 | 200 | 20 | Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийг нийт 1330 объектын 237124 м.кв, нийтийн эзэмшлийн 370142 м.кв талбайд тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдээр, голомтын халдваргүйтгэлийг коронавируст халдварын батлагдсан 11712 тохиолдлын зам мөрийн зураглалын дагуу 1053 байгууллага, аж ахуйн нэгж, 2249 айл өрхийн 566800 м.кв талбайд ЗӨСТ, сумын Эрүүл мэндийн төвүүд шүрших, мананцаржуулах, арчих аргаар, хатуу хучилттай зам талбай, нийтийн эзэмшил орон сууцны хонгил, тоглоомын талбайд 925142 м.кв талбайд МЭГ, ЗӨСТ, "Ариусгал Завхан" ХХК, "Монклин" ХХК-аар Жавелионы 0,06% уусмал, суперкиллын уусмалаар шүрших, мананцаржуулах аргаар эцсийн халдваргүйтгэл хийлгэн хамтран ажилласан байна. | 100 |
| **1.1 дүгээр зорилтын дүн** | | | | | | | | | | | **100** |
| **1.2** | **"Ковид-19" халдварт цар тахлын эрсдлээс урьдчидлан сэргийлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 1.2.1.2 | “Ковид-19” халдварт цар тахлын эрсдлээс урьдчилан сэргийлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ | Гамшгийн үеийн нөхцөл байдалтай уялдуулан стратегийн хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлнэ | 2021-2023 | АЗДТГ, ЭМГ | ОНТ | 180 | 7 | 15 | 80 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 58 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд 343.3 сая төгрөг, - Аймгийн 2023 онд хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан 2 ажил үйлчилгээг гүйцэтгэхэд 80.0 сая төгрөг тус тус батлуулсан байна. Тус аймгийн 24 сумд 2023 онд гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтын хэрэгжилтийг хангуулахаар тусгагдсан санхүүжилт Засаг даргын нөөц санд 120.0 сая төгрөг төсөвлөн батлуулсан байна. Гамшгийн үеийн нөхцөл байдалтай уялдуулан Завхан хүнс групп, Амь-Ус ХХК, Бүрдийн баян бүрд ХХК, Очир-Илч ХХК-тай болзошгүй гамшгийн үед хоол хүнсээр хангах 7 хоногийн нөөц бүрдүүлж бэлэн байлгах 3 жилийн гэрээ хийж хамтран ажиллаж байна. | 100 |
| 1.2.1.3 | | Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна | 2021-2023 | АЗДТГ, ЭМГ | ОНТ | 15 | 200 | 200 | 5 | Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 2 удаагийн татан авалтаар 9400 хүн/тун вакцин татан авч, дархлаажуулалтын хамралт 62 хувьтай байна. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж 24 сумын 43 эмч, эрүүл мэндийн багш нарт цахим сургалт зохион байгуулснаар өсвөр үеийнхний дунд сургалтыг зохион байгуулах шинэ мэдээлэл, боломжоор хангагдсан байна. ЕБС-ын 12400 суралцагчдад зөв ханайж, найтаах, гар угаах дараалал, цэгэн иллэгийн талаар сургалт зохион байгуулж, дадал хэвшил болгох аргад сургалаа. Цахимаар 28 зурагт хуудас, 3 дүрс бичлэгийг түгээж, 18443 видео зөвлөмжийг байршуулсан. Тарваган тахлын халдвар бүртгэгдсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн газар, Нийгмийн Эрүүл мэндийн төвийн фэйж хуудсанд 7 төрлийн зурагт хуудас байршуулан 240 фэйс бүүк групп, хувь хүний фэйс бүүк хуудсанд шэйрлэгдэж, 28375 хандалт авсан, 12000 үзэлттэй байна. Видео зөвлөмжийг орон нутгийн AIR 1 телевизээр дамжуулсан. Тарваган тахал өвчнөөс сэргийлэх Reels хийж байршуулан 36 удаа хуваалцаж 2100 удаагийн үзэлттэй байна. Тарваган тахал өвчний дэгдэлтийн үед хяналтын постод хамтарсан эргүүл хяналтын хүрээнд 1014 автомашинд үзлэг хийж 3887 иргэнд тарваган тахал өвчний талаар сурталчилгаа хийсэн байна. Хамтын үзлэг шалгалтаар 8 удаагийн зөрчил илрүүлэн 33 тарвага хураагдсаныг тус төвийн нян судлалын лабораторид шинжилгээ хийж, устгалд оруулсан. Мэрэгчийн 8 дуудлагаас тарваган тахлын өсгөвөр 5 илэрсэн байна. | 100 |
| 1.2.1.4 | | шинэ коронавирусний халдварыг тодорхойлох оношлуур, эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц | 2021-2023 | АЗДТГ, ЭМГ | ОНТ | 60 | 2 | 10 | 10 | Гамшгийн үеийн бэлэн байдлын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 38 нэр төрлийн 106,0 сая төгрөгийн нөөцтэй. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэг "Амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэл"-ийн 50 нэр төрөл, сумдын эрүүл мэндийн төвүүд амин чухал шаардлагатай эмийн 33 нэр төрлийн 2 сарын нөөцтэй байна. Эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийг ерөнхий гэрээгээр захиалан авч нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагууд 8 нэр төрлийн 8.1 сая төгрөгийн ариутгал, халдваргүйтгэлийн бодисын 1 сарын нөөцтэй байна. | 100 |
| 1.2.1.5 | | Аймгийн нэгдсэн эмнэлэг, зарим “А” зэрэглэлийн эмнэлэг, оношилгоо эмчилгээний төвүүдийг РТ-ПСР төхөөрөмжөөр | 2021-2023 | АЗДТГ,ЭМГ | УТ | 180 | 0 | 1 | 6 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийг 2021 онд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар PCR шинжилгээний аппаратаар хангасан. 2023 оны эхний 11 сарын байдлаар ПГУ шинжилгээ хийгдээгүй байна. 325 тохиолдлын түргэвчилсэн оношилгоог хийснээс flu A-128, flu B-14, adenovirus-41, RSV-87, SARS cov-1, N.pnemoni-1 оношлогдсон байна. ХӨСҮТ-ийн молекул биологийн лабораторид томуугийн 30 сорьц илгээсэн байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.1.6 | | Цар тахлын голомтод ажиллаж буй алба хаагчдыг эрүүл мэндийн эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулна | 2021-2023 | АЗДТГ,ЭМГ | УТ | 95 | 0 | 6 | 50 | 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр тарваган тахал өвчний батлагдсан тохиолдолд Зоонозын өвчин судлалын төв, Эрүүл мэндийн газрын халдвар судлаач нар ойрын хавьтлын 41 иргэдийг илрүүлэн, 308.0 мянган төгрөгийн эм, тариа асуумж, халуун үзэх, ерөнхий биеийн үзлэг хийх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. Хавьтлын асуумж, ерөнхий биеийн үзлэг шинжилгээг өдөрт 2 удаа утсаар болон эмч нар халдвар хамгаалалтын хувцастай очиж халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан. Халдварын голомтод 27 эмч, сувилагч эмнэлгийн мэргэжилтнүүд ажилласан бөгөөд голомтод ажилласан ажилчдын цалин хөлс, илүү цагийн мөнгө 19.8 сая төгрөгийг шийдвэрлүүлэхээр аймгийн Онцгой Комисст хүргүүлсэн. | 100 |
| **1.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **100** |
| **НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮН** | | | | | | | | | | | **100** |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| **2.1** | **Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна** | | | | | | | | | | |
| 2.1.1.1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ | Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, нялхсын эндэгдлийг бууруулна. | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ, ОНТ, БӨХ | 162.0 | эх/э-0, нялхас-16.1 | эх/э-0, нялхас 14.5 | 36.0 | 2023 оны эхний 11 сарын байдлаар 779 эх жирэмсний хяналтад хамрагдаж, эрт үеийн хяналт 92.8 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувиар, улсын дундаж үзүүлэлтээс 0.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд 947 эх төрсөн нь өмнөх оны мөн үеэс 44 тохиолдлоор өссөн байна. Эхийн эндэгдэлгүй, эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдол бүртгэгдэж, хурлыг зохион байгуулсан бөгөөд хурлын шийдвэр, холбогдох материалыг ЭХЭМҮТ-ийн Тандалт, судалгааны албанд хүргүүлсэн.<br>Аймгийн хэмжээнд 952 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй. Амьд төрсөн хүүхдийн 47.9 хувь нь эрэгтэй хүүхэд, 52,1 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 98.6 байгаа нь улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад 1.9 хувиар өндөр  байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 18.9 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 тохиолдлоор өссөн байна.<br>Нялхсын эндэгдлийн 14 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 11,4 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2,7 промилоор өссөн үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 50.0 хувийг 0-6 хоногтой нярайн эндэгдэл, 28.5 хувийг 7-28 хоногтой нярайн эндэгдэл эзэлж байгаа ба нярайн эндэгдлийн түвшин 11.6 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.9 промилаар өссөн үзүүлэлттэй байна. Перинаталь эндэгдлийн түвшин 10.5 байгаа нь улсын дунджаас 0.2, аймгуудын дунджаас 1.8 промилоор өндөр байна.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэг амьсгалын дистресс хам шинжтэй 3 нярайд сурфактант эмчилгээг хийж, эмчилгээ үр дүнгээ өгсөн байна. | 50 |
| 2.1.1.2 | | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд цахим үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ, ОНТ | 220.0 | 2 | 8 | 60.0 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт мэдээллийн алба бие даан ажиллаж, мэдээллийн технологийн техник хэрэгслийн бэлэн байдал, үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа e-health, Hinfo, MnCardio, Acolus, Payroll,Hr.hdc.mn, хүний нөөц, Health.gov.mn, ЭМД, Uptodate зэрэг системүүдийн хэвийн тасралтгүй байдлыг хангаж ажлын байран дээрх сургалтыг тасралгүй зохион байгуулж байна. ЭМГ-аас анхан шатны байгууллагуудын цахим жор нээх эрхийг Health.gov.mn систем дээр илгээсэн хүсэлтийн дагуу бүртгэж хэвшсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг шинжилгээний хариуг холбогдох эмч нарт цахимаар хүргэж, e-Mongolia системээр дамжуулан онлайнаар эмнэлэгт үзүүлэх дугаар, цаг авах боломж бүрдсэн. E-mongolia цахим платформд эрүүл мэндийн чиглэлийн 14 үйлчилгээ нэвтэрснийг иргэдэд сурталчлах ажлыг фейсбүүк, youtube ашиглан тогтмол сурталчилж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 18000119 дугаар ажиллаж 1583 иргэн, e-Mongolia системээр дамжуулан 924 иргэн цахимаар цаг авч үйлчлүүлсэн байна. Анхан шатны байгууллагууд health.gov.mn, аймгийн болон Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг e-health систем ашиглаж хэвшсэн. Мэдээллийн аюулгүй байдал болон хувь хүний нууцыг хамгаалах чиглэлээр Нэгдсэн эмнэлгийн эмч мэргэжилтнүүд үйл ажиллагаандаа цахим гарын үсгийг 100 хувь нэвтрүүлсэн. | 100 |
| 2.1.1.3 | | Сумдад явуулын амбулаторийн цогц үйлчилгээг  хүргэнэ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ, ОНТ | 100.0 | 16827 | 21000 | 25.0 | ДЭМБ-ын "Зудтай болон зудын байдалтай байгаа сумын отор нүүдлээр явж байгаа малчин иргэдэд тусламж үйлчилгээ" хүргэх төслийн хүрээнд 23 сумын отор нүүдэл хийж байгаа 433 малчин өрхийн 782 иргэнд дотор, эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, зөөврийн ЭХО болон мобайл технологийн тоног төхөөрөмжийг ашиглан тусламж, үйлчилгээг хүргэсэн. Үзлэгт жирэмсэн эх 67, 0-5 хүртэлх насны хүүхэд 68, ахмад настан 128, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 16, архаг суурь өвчтэй 177 иргэн хамрагдсан. “Чадварлаг эмч” арга хэмжээний хүрээнд алслагдсан сумын 4 бүсийн 9 суманд явуулын тусламж үйлчилгээг эх барих, эмэгтэйчүүд, дотор, халдварт/сүрьеэ,бэлгийн замаар дамжих халдвар, хүүхэд, дүрс оношилгооны чиглэлээр хүргэж ажиллалаа. Давхардсан тоогоор нийт 3736 иргэнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө, 2000 гаруй иргэнд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулсан байна. Үзлэгээр хавдрын сэжигтэй тохиолдол 2, сүрьеэгийн сэжигтэй тохиолдол 29 (сорьц), бэлгийн замаар дамжих халдварын 8 тохиолдлыг илрүүлж, лавлагаа шатлалын эмнэлэгт 31 тохиолдлыг илгээсэн байна. Сумын Эрүүл мэндийн төвүүд нь хөдөөгийн багийн 8157 иргэдэд явуулын эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэн, дархлаажуулалтыг хийж, давхардсан тоогоор 12675 иргэнд хүрч үйлчилсэн байна. | 100 |
| 2.1.1.4 | | Уламжлалт анагаах ухааны үйлчилгээг өргөжүүлнэ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ, ОНТ | 535.0 | 4700 | 6500 | 80.0 | Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг аймгийн Нэгдсэн эмнэлгийн уламжлалтын тасаг, Уламжлалт анагаах ухааны төв, Отгонтэнгэр рашаан сувилал, Улаан хаалга рашаан сувилал, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг, Одчимнаран эмнэлэг, Үе залгамжлал элит сувилал нь амбулатори, өдрийн болон хэвтэн эмчлүүлэх чиглэлээр үзүүлж байна. Аймгийн хэмжээнд уламжлалт анагаах ухааны 23 их эмч, 32 бага эмч ажиллаж 4235 иргэнд уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг үзүүлсэн. Уламжлалт анагаах ухааны төв нь ашигласан ор хоног 8695, дундаж ор хоног 62.4, орны фонд ашиглалт 248.4, орны эргэлт 35.9 байна. Шинээр уламжлалт эмчилгээний 14 нэр төрлийн эмчилгээ нэвтрүүлсэн. Уламжлалт анагаах ухааны эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 116 эмч мэргэжилтэн хамрагдсан . ‘’Уламжлалт анагаах ухааны аргаар өвчнөөс урьдчилан сэргийлье” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж үйл ажиллагаанд 182 иргэн хамрагдаж, 97 үйлчлүүлэгчид үзлэг, оношилгоо хийж, 140 орчим гарын авлагыг боловсруулан түгээж үйл ажиллагаагаа сурталчлан, иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ хүргэсэн байна. | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1.5 | | Зүрх судасны тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ, ОНТ | 570.0 | 20.1 | 18.5 | 115.0 | Зүрх судасны шалтгаант нас баралтын түвшин 10000 хүн амд 7.1, зүрхний шигдээсний шалтгаант нас баралт 0.67 байна. Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих 47548 иргэнээс 11510 иргэн хамрагдаж, хамрагдалтын хувь 24,2% байгаа нь өмнөх оны энэ үетэй харьцуулахад 6,3%-иар буурсан. Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих 29193 иргэнээс 8848 иргэн хамрагдаж, 30,3%-тай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 12,6%-иар буурсан байна. Зүрх судасны кабинет нь зүрхний ачааллалтай сорилыг шинээр нэвтрүүлж 20 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс 5 тохиолдлыг ангиографийн шинжилгээнд явуулж стент тавиулсан. Зүрхний төрөлхийн гажиг 21 тохиолдол илрүүлснээс 10 хүн хагалгаанд орж эмчлэгдсэн. Олдмол гажиг 2 оношлогдож хавхалга солиулах хагалгаанд орсон. Улиастай, Их-Уул сумдын 9-р ангийн 750 хүүхдэд зүрх, чих хамар хоолой, амны хөндийн эрүүл ахуйн үзлэг шинжилгээ хийгдсэн. Үүнээс 14 хүүхэд зүрхний төрөлхийн гажиг оношлогдож 100 хувь хагалгаанд орсон. 0-1 насны хүүхдийн зүрхний гажиг илрүүлэх үзлэгт 8 хүүхэд оношлогдсон. АШУҮИСургуультай хамтран 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай зүрхний архаг дутагдлыг илрүүлэх судалгааг хийсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт зүрх судасны чиглэлээр 1 их эмчийг мэргэшүүлэн сургаж 2 эмч ажиллаж байна. | 100 |
| 2.1.1.6 | | Эмийн зохистой хэрэглээ, аюулгүй байдлыг хангаж, эмийн сангийн үйл ажиллагааг тогтворжуулна | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ, ОНТ | 0.0 | 9 | 40 | 0.0 | Аймгийн хэмжээнд 53 эмийн сан, эм ханган нийлүүлэх 4 байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна. Хяналт үнэлгээг 2 удаа хийж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд: Аймгийн Засаг даргын 30 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Улиастай суманд үйл ажиллагаа эрхэлж буй 9 эмийн сан, 4 эм ханган нийлүүлэх байгууллагад эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, эмийн үнийн өсөлт, эмийн чанар аюулгүй байдал, иргэдэд хөнгөлөлтэй олгож байгаа эмийн үнэ, Новартис төслийн эмийн татан авалт, хангалтад хяналт үнэлгээ хийж зөвлөмжийг хүргүүлсэн. Эрүүл мэндийн газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 14 сумын эмийн сан болон нийтийн үйлчилгээтэй эмийн сангуудад "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого зарлага, хадгалалт, эмийн чанар аюулгүй байдал, тендерийн эмийн зарцуулалт хадгалалтад хяналт үнэлгээ хийж, хяналтаар дунд эрсдэлтэй гарсан эрүүл мэндийн байгууллага, эмийн санд хугацаатай зөвлөмжийг хүргүүлсэн байна. Цагдаагийн газартай хамтран "Туншил" арга хэмжээний дагуу мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх эрх бүхий эм хангамжийн эмийн сан, эм ханган нийлүүлэх төв, Нэгдсэн эмнэлгийн эмийн сангуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын орлого, зарлага, жор бичилтэд хяналт шалгалтыг хийж, газар дээр нь зөвлөмж өгч ажилласан. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 33 эмийн сан гэрээ байгуулан 620 нэр төрлийн эмийг хөнгөлөлттэй жороор олгож, 10 сарын байдлаар давхардсан тоогоор 37366 иргэнд 1,3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй эмээр үйлчилсэн байна. Монгол улсын Засгийн газар, Швейцарын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй "Новартис" хөтөлбөрийн хүрээнд 26 эмийн сантай гэрээ байгуулан худалдааны 24 нэр төрлийн эмнээс 100 хувь үнэ төлбөргүй олгож байна. | 90 |
| 2.1.1.7 | | Эрүүл мэндийн байгууллагуудад парк шинэчлэлт хийж, зарим сумыг яаралтай тусламжийн бүрэн тоноглогдсон автомашинаар хангана | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ, ОНТ | 847.0 | 56 | 60 | 250.0 | Баянтэс сумын эрүүл мэндийн төвд Хантер,Тэлмэн, Түдэвтэй сумдын эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдаж байсан пургон маркийн автомашинуудыг блансаас блансын хооронд шилжүүлж, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 118,0 сая төгрөгийн өртөг бүхий иж бүрэн тоноглогдсон автомашин нийлүүлэгдсэн. | 100 |
| 2.1.1.8 | | Улиастай, Тосонцэнгэлийн нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тасаг, нэгжийг байгуулна | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 300.0 | 14 | 16 | 100.0 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийг тусгаарлан яаралтай тусламжийн тасгийг байгуулсан. 2023 оны 3 сард урологийн кабинетыг байгуулж үйл ажиллагаагаа явуулж байна. | 100 |
| 2.1.1.9 | | Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ, ОНТ, БӨХ | 2300.0 | 10 | 30 | 650.0 | ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэлийн Нэгдсэн эмнэлгүүдэд 18 нэр төрлийн 288,5 сая төг, сумдын эрүүл мэндийн төвүүдэд 23 нэр төрлийн 632,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Орон нутгийг хөгжүүлэх сангаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт 20 нэр төрлийн 195,5 сая төгрөг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 15 нэр төрлийн 81,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж олгосон. Хандив тусламжаар Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт 2 нэр төрлийн 10,5 сая төгрөгийн , Нөмрөг сумын Эрүүл мэндийн төвд 12 нэр төрлийн 47,7 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Тосонцэнгэлийн Нэгдсэн эмнэлэг өөрийн хөрөнгөөр 4 нэр төрлийн 20,3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүүлж 2023 онд нийт 1,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | 100 |
| 2.1.1.10 | | Эрүүл мэндийн бодлого хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох бодлогын зөвлөлийг байгуулж ажиллуулна. | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 8.0 | 0 | 1 | 2.0 | Аймгийн Засаг даргын 2023 оны 72 дугаар захирамжаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийг 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 5 зорилтын хүрээнд 12 ажил төлөвлөн хэрэгжүүлж байна. Зөвлөлийн 2 дугаар улирлын хурлаар эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд зориулан орон нутгийн хөгжлийн сангаас 43.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Хэрэгжилтийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн хагалгааны өрөөний гэрэлтүүлгийг 15.2 сая төгрөгөөр шинэчилж, хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх 18.0 сая төгрөгийн технологийг нэвтрүүлэн үйлчилгээг хүргэж байна. | 100 |
| 2.1.1.11 | | Рашаан сувиллын үйлчилгээний чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНХС | 16.0 | 20.0 | 10.0 | 5.0 | Отгонтэнгэр рашаан сувилал нь 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 5 жилийн хугацаатай, Чигэстэй ундраа ХХК-ны Улаан хаалганы рашаан сувилал нь 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 5 жилийн хугацаатай, ХХҮГ-ын дэргэдэх ахмадын сувилал нь 2023 оны 07 дугаар 04-ний өдрөөс 3 жилийн хугацаатайгаар эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулан, үйл ажиллагаа эрхэлж байна. Отгонтэнгэр рашаан сувилал нь зуны 3 сар үйл ажиллагаа эрхэлж 925 иргэнд үйлчилгээг хүргэн ЭМД-ын сангаас 270,0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2.1 | | Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний гаралтыг бууруулна. | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 0.0 | 7269.2 | 7160 | 0.0 | “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг 8 зорилт 52 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжилтийг ханган ажиллалаа. 3 дугаар улиралын байдлаар халдварт өвчний 429 тохиолдол бүртгэгдсэнээс Ковид-19 тохиолдол 26 буюу 6.1%-ийг бусад халдварт өвчин 93.1%-ийг эзэлж байна. Үүнээс: Салхинцэцэг 186 (41.9), заг хүйтэн 71 (16.1), тэмбүү 45 (10.5), трихамониаз 7 (1,6 хувь), сүрьеэ 6 (1,4 хувь) байна. 2022 оны мөн үетэй харьцуулахад нийт халдварт өвчин дотор заг хүйтэн 18%-иар буурч, салхинцэцэг, тэмбүү, трихамониаз өссөн үзүүлэлттэй байна. Зорилтот насны 47311 иргэнээс цээжний рентген шинжилгээнд 6989 иргэн хамрагдаж, хамралт 14.8%-тай, үүнээс сүрьеэ өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт 1486 иргэн хамрагдсан. Монголын сумын эмнэлгийн холбооны дэмжлэгээр сүрьеэтэй өвчтөний хавьтлын эрт илрүүлэг үзлэг, БЗДХ илрүүлэх үзлэг оношилгоонд Их-Уул, Ургамал, Цэцэн-Уул, Идэр, Отгон, Цагаанчулуут, Сонгино, Баянтэс, Асгат сумын 982 иргэнийг хамруулсан. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний гаралтыг бууруулах чиглэлээр Хавдар болон харшлын эсрэг арга хэмжээ, Мон-Пен санаачилга, хүн амын эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээ, осол гэмтлээс сэргийлэх зорилтод ажлуудыг хийж байна. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг 10000 хүн амд 676.4, амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг 395.8, зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг 508.4, шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны эмгэг 339.6 байна. Гэмтэл, хордлого, гадны шалтгаант бусад эмгэг 176.1 буюу 15%-иар өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 2.1.2.2 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | Эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудын тоог нэмэгдүүлнэ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 43.0 | 83 | 100 | 12.0 | Эрүүл мэндийн сайдын 2017 оны 472 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих байгууллагуудыг журмын дагуу сонгон шалгаруулж, байгууллагад эрүүл зан үйлийг хэвшүүлэх, төлөвшүүлэх ажил тасралтгүй явагдаж байна. 2023 онд ОНХС-аас 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” 93 байна. Үүнээс 2-р зэргийн болзол хангасан 25, 1 дүгээр зэргийн болзол хангасан 18, 3-р зэргийн болзол хангасан 50 байгууллага байна. 2023 онд 32 байгууллага Эрүүл мэндийг дэмжигч байгууллагад шалгуулахаар хүсэлтээ ирүүлж нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтыг хийж байна. Эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг 3 үе шатаар шалгаруулж, урамшуулна. 2023 оны зорилтод түвшингээр авч үзэхэд 105-д хүрсэн үзүүлэлт байна. | 100 |
| 2.1.2.3 | | Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 26.0 | 70% | 80% | 6.0 | Нийгмийн эрүүл мэндийн 20 тэмдэглэлт өдөр 5 нэгдсэн арга хэмжээний хүрээнд AIR 1 телевизээр 19 удаагийн ярилцлага, мэдээ дамжуулснаас 4 мэдээллийг МҮОНРТ-ээр дамжуулсан. Нийт 31 төрлийн зөвлөмж , дүрс бичлэг, 12 зурагт хуудас зөвлөмж, 5 удаагийн үгэн зарыг дамжуулж нийт 48052 удаагийн цацалт хийгдсэн. Завхан сониноор 2 удаагийн зөвлөмж, ярилцлага, мэдээ нийтлүүлсэн. ЭМЯ, НЭМҮТ, СЭМҮТ, ХӨСҮТ, НҮБ болон өөрсдийн боловсруулан гаргасан сурталчилгааны материалуудыг эрүүл мэндийн байгууллагуудын фэйж хуудас, группд байршуулж байна. Сурталчилгааны 23 материалуудыг Онлайн дизайны “Canva” платформ ашиглаж боловсруулсан. Нийт цахим хуудсаар 598 төрлийн зурагт хуудас түгээж 342838 хандалт, 17 төрлийн инфонграфик байрлуулж 62812 хандалт, 39 удаагийн зөвлөмжид 121934 хандалт авсан байна. | 100 |
| 2.1.2.4 | | Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсэд тандалт судалгаа хийнэ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 7.0 | 1 | 2 | 2.0 | Лабораторийн шинжилгээтэй хяналтаар 24 сумын Эрүүл мэндийн төв, хүнсний худалдаа, үйлдвэрлэл, хүүхдийн байгууллага, Амь-Ус ХХК-ний 2-р өргөлт, Тосон-Очирт хайрхан ОНӨААТҮГазрын ус түгээх шугам, ус түгээх байр зэрэг нийт 89 цэг нэгжээс 173 цэвэр усны сорьц, 11 байгууллагын бохир усны 25 сорьц, 25 эрүүл мэндийн байгууллагын 99 хоолны дээж, 27 дотуур байрны нэг өдрийн хоолны дээжийг Стандарт хэмжил зүйн хэлтсийн хими, нян судлалын шинжилгээнд хамруулан үнэлгээ дүгнэлт хийсэн. Тандалд судалгаагаар 11 хүнсний худалдаа эрхлэгчээс хадгалах хугацаа хэтэрсэн 37 нэр төрлийн 165 ширхэг 617700т, 2.8 кг, 400.0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн илэрсэн зөрчлийг аж ахуй нэгжийн дотоод хяналтын журмын дагуу газар дээр нь устгуулан зөрчлийг арилгуулсан. Зөрчлийн тухай хуулийн дагуу 2 аж ахуй нэгжид 2.0 сая төгрөгний шийтгэл ногдуулсан байна. | 70 |
| 2.1.2.5 | | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг бэхжүүлнэ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 8200 | 178.8 | 2000 | 2000 | Гамшгийн үеийн бэлэн байдлын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 38 нэр төрлийн 106,0 сая төгрөгийн нөөцтэй. Аймгийн, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг "Амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэл"-ийн 50 нэр төрөл, сумдын эрүүл мэндийн төвүүд амин чухал шаардлагатай эмийн 33 нэр төрлийн 2 сарын нөөцтэй байна. Эрүүл мэндийн байгууллагууд 8 нэр төрлийн 8.1 сая төгрөгийн ариутгал, халдваргүйтгэлийн бодисын 1 сарын нөөцтэй байна. Улиастай суманд зохион байгуулсан газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх команд штабын сургуулилтад 3 баг 30 гишүүнтэй 3 автомашин, 38 нэр төрлийн 106.8 сая төгрөгийн эм бэлдмэлийн нөөцийг тооцоолж оролцсон. Эрүүл мэндийн салбарын гамшгаас хамгаалах хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 2 удаа тодотгол хийсэн. | 70 |
| 2.1.2.6 | | “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 15.0 | 0 | 100 | 5.0 | 5 зорилтын хүрээнд 28 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна. "Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах" 2 сарын аяныг зарлан дүгнэсэн. Аяны хүрээнд 24 сум, сумын эрүүл мэндийн байгууллага, Улиастай хотын 60 гаруй аж ахуй нэгж албан байгууллагын 14832 иргэнд хүрч үйлчилсэн. Төрийн 31 албан байгууллагын 18-86 насны эрэгтэй 599, эмэгтэй 1361 албан хаагчдын биеийн жингийн индексийг TANITA BC-587 маркийн электрон жинлүүр ашиглан тодорхойлоход: Өөхний хэмжээгээр 51% нь илүүдэл жинтэй, 26% нь тарган, 21% нь хэвийн, 2% нь туранхай байсан бол биеийн жингийн индексээр 10% нь хэт таргалалттай, 19% нь таргалалттай, 39% нь илүүдэл жинтэй, 30% нь хэвийн, 2% нь туранхай байгаа нь нийт хэмжилтэд орсон хүмүүсийн 77% нь төвийн таргалалттай, 68 % нь илүүдэл жин таргалалттай байна. Судалгааны үр дүнг НЭМҮТ-ийн 90 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрүүл зан үйл, эрүүл идэвхтэй амьдрал, эрүүл мэндийн боловсрол олгох, “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны үйл ажиллагааг иргэдэд сурталчилан, Түмэн дасгалыг түгээж ажлын байрны дасгалыг хэвшүүлж байна. | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2.7 | “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 95.0 | 0 | 100 | 30.0 | “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг 8 зорилт 52 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжилтийг ханган ажиллалаа. 3 дугаар улиралын байдлаар халдварт өвчний 429 тохиолдол бүртгэгдсэнээс Ковид-19 тохиолдол 26 буюу 6.1%-ийг бусад халдварт өвчин 93.1%-ийг эзэлж байна. Үүнээс: Салхинцэцэг 186 (41.9), заг хүйтэн 71 (16.1), тэмбүү 45 (10.5), трихамониаз 7 (1,6 хувь), сүрьеэ 6 (1,4 хувь) байна. 2022 оны мөн үетэй харьцуулахад нийт халдварт өвчин дотор заг хүйтэн 18%-иар буурч, салхинцэцэг, тэмбүү, трихамониаз өссөн үзүүлэлттэй байна. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрөөр 932 иргэнд сургалт хийж, 800 гаруй гарын авлага тараасан. Ерөнхий боловсролын Жавхлант цогцолбор сургуулийн 9-11-р ангийн 135 сурагчдад хөгжөөнт тоглоом тоглуулж, АХА тэмцээнийг зохион байгуулсан. Товлолын болон нэмэлт дархлаажуулалтын 19 нэр төрлийн 98.7 сая төгрөгийн вакцин, био бэлдмэл, дагалдах хэрэгсэл, 2 төрлийн 1.6 сая төгрөгийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж татан авч хуваарилсан. Сахуу татран, улаанбурхан, улаануудын вакцин В гепатитын иммунглобулиний 4900 хүн тун вакцин, биобэлдмэлийг татаж, дархлаажуулалтын явцад хяналт тавин ажиллаж байна. Товлолын дархлаажуулалт 98.5%-тай, улаан бурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтыг 10 сараас 8 нас хүртэлх хүүхдүүдийн дунд зохион байгуулсан бөгөөд хамралт 78% -тай хийгдсэн байна. | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2.8 | | “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 60.0 | 0 | 100 | 20.0 | Аймгийн хэмжээнд төрөлт 947, үүнээс 952 амьд төрөлт, 130 кесар хагалгаа хийгдсэн байна. Өсвөр насны охидын төрөлт 32, үүнээс насны байдлаар: 15-1, 16 -2, 17 -4, 18 -9, 19 -16 буюу нийт төрөлтийн 3.4%-ийг эзэлж байна. Дутуу төрөлт 33, амьгүй төрөлт 3, зулбалт 21, үр хөндөлт 11 байна. Хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх технологийг нэвтрүүлэн 280 эмэгтэйд оношилгоо, шинжилгээ хийгдсэн байна. Дутуу болон бага жинтэй төрсөн 20 нярайд гэр бүлд түшиглэсэн "Имж эх" асаргааг хэрэгжүүлэн, 573 нярайд түнхний дутуу хөгжлийг илрүүлэх оношилгоог хийж, түнхний дутуу хөгжилтэй нярайг сар тутамд хянаж, 5 нярайд сурфактант эмчилгээ хийгдсэн байна. Эх баригчийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 1, ЭХЭМҮТ-д ажлын байрны сургалтад 4 эх баригч хамрагдсан. Охид эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд 24 эрүүл мэндийн байгууллага нь нөхөн үржихүйн болон цэвэршилтийн насны 1800 охид, эмэгтэйчүүдэд мэдээлэл, сургалт сурталчилгаа хийсэн. Мөн 12-13 насны 150 охидод шилжилтийн насны онцлог, биед гарах өөрчлөлтийн талаар, ЕБС -ын ахлах ангийн нийт 663 суралцагчдад нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, БЗДХ өвчин агуулгын хүрээнд сургалт зохион байгуулж, нээлттэй ярилцлагыг хийсэн. Нөхөн үржихүйн насны 17102 эмэгтэйгээс 9713 буюу 56,8 % ЖСА хэрэглэж байна. Нөхөн үржихүйн насны зорилтод бүлгийн 1219 эмэгтэйд мэдээлэл хүргэж, хөгжлийн бэрхшээлтэй 72 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байна. Өндөр тунт А амин дэм 6859, жирэмсэн болон хөхүүл эхийн олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг 23000, хүүхдийн олон найрлагат бичил тэжээлийн холимог 1930 ширхэг, 23 сартай хүүхдийн ОНБТХ-ыг 1010 хүүхэд, 595 жирэмсэн,1848 хөхүүл эхэд хэрэглэсэн байна. | 100 |
| 2.1.2.9 | | “Хавдрын эсрэг” арга хэмжээ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 80.0 | 0 | 100 | 30.0 | Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 16 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хавдрын өвчлөл 753 байгаагаас шинээр оношлогдсон 18, хавдрын шалтгаант нас баралт 9 байна. Амбулаторийн үзлэгт идэвхитэй хяналтын 101, урьдчилан сэргийлэх үзлэгийн 35, өвчний учир 129 хүн тусламж үйлчилгээ авсан ба , хэвтүүлэн эмчлэх хөнгөвчлөх эмчилгээнд 12 , хэвтүүлэн эмчлэх хими эмчилгээнд 12 хамруулан, 39 хүнд гэрийн эргэлт хийн асран халамжлагч 52 хүнд зөвлөгөө мэдээллийг хүргэсэн. Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдах насны 13775-аас 5150 хүн хамрагдсан ба хамралт 41.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 4463 иргэнээс 1200 иргэн хамрагдсан ба хамралт 34.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.31 хувиар өссөн. Хавдраас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд сургалт нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, Air 1 телевизээр "Бөөрний хавдар ба шалтгаант хүчин зүйлс, эмчилгээ" сэдэвт ярилцлагыг иргэдэд хүргэн, ерөнхий боловсролын сургуулийн 194 сурагч, цэргийн ангийн 45 ажилчдад " Хавдар үүсгэгч хүчин зүйл ба тамхидалт" сэдэвт сургалт мэдээллийг хийлээ. | 70 |
| 2.1.2.10 | | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 30.0 | 56.5 | 100 | 10.0 | 2023 онд Элэг бүтэн монгол арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт, 21 үйл ажиллагаа төлөвлөсөн. Аймгийн хэмжээнд Гепатит В, С вирусийн шинжилгээнд хамрагдвал зохих 47311 иргэнээс 18786 иргэн хамрагдаж хамралт хэрэгжилт 39,9 хувьтай байна. Гепатит В,С вирус илэрсэн 3919 байна. Шинээр 46 иргэн оношлогдсон. Үүнээс гепатит В вирусийн халдвартай 35 иргэн, С вирусийн халдвартай 11 иргэн байна. Аймгийн хэмжээнд 703 жирэмсэн эх хяналтад орж гепатит В,С вирусийн шинжилгээнд бүрэн хамруулсан. Халдвар шинээр оношлогдсон 1, хяналтад байгаа В вирусийн халдвартай 5, В болон Дельта хавсарсан халдвартай 1 жирэмсэн ээж байна. В вирусийн халдвартай эхээс төрсөн 16 нярайд иммуноглобулин хийгдсэн байна. Үүнээс дархлал тогтцын шинжилгээнд хамрагдсан 10, дархлал тогтсон 7 байна. Жирэмсний хяналтад байгаа эмэгтэйчүүд, гэр бүлийн хүнд “Жирэмсэн үеийн вируст гепатитын хор уршиг гэр бүлээ хамгаалах, вакцины үүрэг, төрсөн нярайд вакцин болон иммуноглобулин тарих дархлаа тогтоц үнэлэх арга, гэр бүл төлөвлөлт, В,С вирусийн халдвартай эх эмийн эмчилгээнд хамрагдах” зэрэг сэдвүүдийн хүрээнд харилцан ярилцах байдлаар 500 гаруй эхэд сургалт хийж зөвлөгөө мэдээлэл бүхий гарын авлага тараасан JCI Монгол төрийн бус байгууллагатай хамтран “Амьдрал бэлэг” төслийн хүрээнд элэгний В, С, Д вирусийн халдвартай элэгний цирроз, хавдар болон бусад эмгэг бүхий иргэдэд зориулсан "Сэтгэлийн хүчээр өвчнөө ялъя" сургалт зохион байгуулагдаж вирусын халдварын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч сэтгэлзүйн талаас хэрхэн даван туулах эрүүл мэндийн болон сэтгэлзүйн цогц сургалтад 70 гаруй иргэн хамрагдсан. Вирусын эмчилгээнд нийт 149 иргэн хамрагдаж байна. Үүнээс В Вирусийн халдвартай 52, С вирусийн халдвартай 37, В, Д вирусийн хавсарсан халдвартай 60 иргэн байна. | 70 |
| 2.1.2.11 | | “Харшлаас сэргийлэх” арга хэмжээ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 20.0 | 0 | 100 | 5.0 | 3 зорилт, 15 үйл ажилагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Харшлын эсрэг дэлхийн 7 хоног, “Ургамлын тоосны харшилтай тэмцье” аяны хүрээнд “Харшил түүнээс сэргийлье, хүнсний харшил үүсгэгч, агаарын бохирдол, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх нь,эмийн зохистой хэрэглээ, эмийн харшил” зэрэг сэдвүүдээр сургалт мэдээллийг 2500 иргэнд хүргэж, 505 ширхэг гарын авлага түгээж, эмэнд харшилсан иргэдийг “Эмийн гаж нөлөөний хуудас” -аар хянаж байна. Харьяа эрүүл мэндийн байгууллагууд “Эмийн харшлаас сэргийлэх, антибиотикийн зөв зохистой хэрэглээ” сэдвээр дотоод сургалтыг хийж, байгууллагын фейж хуудсанд мэдээллийг байршуулан 2074 хүний хандалт авч, нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг 11 газар, 11 хүнсний дэлгүүрт “Хүнсний харшил төрүүлэгч бүтээгдэхүүн”-ий талаар мэдээлэл өгч ажилласан. Арьсны өвчин судлалын үндэсний төвөөс зохион байгуулагдсан “Хүүхдийн арьсны онцлог, хүүхдэд зонхилон тохиолдох арьс харшлын эмгэг, арьс арчилгаа” сургалтад Тосонцэнгэл сумын 2 эмч хамрагдаж, дотоод сургалтаар 48 мэргэжилтэнд мэдээлэл хийсэн байна. . | 50 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2.12 | | “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 20.0 | 0 | 100 | 5.0 | Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетад орон нутгийн хөгжлийн сангаас 19,5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж 12 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжөөр хангасан. Эрэгтэйчүүдийн кабинетаар нийт 493 эрэгтэй , насны байдлаар 0-19 нас 100, 20-39 нас 67, 40-49 нас 47, 50-64 нас 126, 65-с дээш насны 153 эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд нийт 36821 эрэгтэй хамрагдахаас 12537 эрэгтэй үзлэг, шинжилгээнд хамрагдаж, хамрагдалтын хувь 34% байна. Үүнээс насаар нь авч үзвэл 0-5 нас 41,9%, 6-17 нас 70,7%, 18-30 нас 9,9%, 31-45 нас 2,66%, 46-60 нас 26,4%, 61-с дээш насныхан 27,3% хамрагдсан байна -Сургалт, мэдээллийг хүргэж, “Эрхээ, Тэгшээ” комик цуврал, “Үе тэнгийнхний дээрэлхэлт, дарамт” подкаст хийж байгууллагын пэйж хуудсаар олон нийтэд түгээсэн - Эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинэжилгээнд нийт 36821 эрэгтэй хамрагдахаас 12537 эрэгтэй үзлэг, шинжилгээнд хамрагдаж, хамрагдалтын хувь 34% байна. Үүнээс насаар нь авч үзвэл 0-5 нас 41,9%, 6-17 нас 70,7%, 18-30 нас 9,9%, 31-45 нас 2,66%, 46-60 нас 26,4%, 61-с дээш насныхан 27,3% хамрагдсан байна. - ЕБС уудын ахлах ангийн нийт 663 сурагчдад" Нөхөн үржихүйн эрүүл мэнд," Гэр бүл төлөвлөлт"," БЗДХ өвчин" “ Тамхидалт ба Электрон тамхины хор нөлөө ” сэдвүүдээр сургалтыг зохион байгуулж, тулгамдаж буй асуудал, анхаарах асуудлаар нээлттэй ярилцлага зохион байгуулж, зөвлөгөө мэдээллээр хангасан Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/66 дугаар тушаалаар "Жендэрийн дэд салбар зөвлөл"-ийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан Жендэрийн эрх тэгш байдлын талаар 10 төрлийн уриалга, видеог цахимаар түгээж 105 иргэнд мэдээлсэн. Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран “Архины хор уршиг, архидан согтуурахаас сэргийлье” сэдвээр 35 аж ахуйн нэгж, 3 сургуулийн 1171 иргэн, 215 төрийн албан хаагчдад сургалт хийж, 500 ширхэг гарын авлага, санамж тараан 31 төрлийн постер мэдээллийг цахимаар түгээж 18846 хандалт авсан. | 90 |
| 2.1.3.2 | | Лавлагаа шатлалд хийгддэг оношилгоо, эмчилгээг аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэвтрүүлнэ. | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ | 4500.0 | 2 | 6 | 1200.0 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн "Эрүүл мэндийг дэмжих төв" нь эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ,оношилгоог хийж байна. Брилиант эмнэлэгтэй хамтран ходоодны эрт үеийн хавдар хуулах хагалгаа - 2 , улайн хоолойн өргөссөн судас боох ажилбар – э -ийг орон нутагт хийсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нар улаан хоолой, бүдүүн гэдэсний ургацаг авах 46 ажилбарыг хийсэн байна. Зүрх судасны кабинет нь зүрхний ачааллалтай сорилыг хийж эхлээд 25 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс 7 хүнийг ангиографийн шинжилгээнд явуулж стент тавиулсан."Гурван гал" эмнэлэгтэй хамтран чихний хэнгэрэг нөхөх, хамрын муруй засах, хамрын таславчын муруй засах, хамрын хөндийн ур авах, самалдаг түлэх, самалдаг тайрах хагалгааг 176 хүнд хийсэн. Гэмтлийн гаралтай тархины бүх төрлийн хагалгааг хийж, 11 хүнд тархины хагалгаа амжилттай хийгдсэн байна. Дунд чөмгөний хугарлыг CRM аппаратын тусламжтайгаар түгжих хагалгааг нэвтрүүлэн 4 тохиолдолд тусламж, үйлчилгээг амжилттай хийсэн. Мэргэшсэн эмчтэй Урологийн кабинет байгуулагдан бөөр шээсний доод замын дурангийн хагалгаа ажилбарыг хийж, түрүү булчирхайн дурангийн хагалгаа-25, бөөрний усжилтын улмаас шээлгүүрт стент гуурс тавиулах-3, давсганы чулуу-1, шээдэг сүвний нарийсал-3, давсганы хавдар-1 хийгдсэн байна. | 90 |
| 2.1.3.3 | | Мобайл технологийг өргөжүүлэн, үйл ажиллагаагаа эрчимжүүлнэ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | УТ | 1628.0 | 3 | 25 | 408.0 | 2023 оны эхний 10 сарын байдлаар Мобайл технологийн тоног төхөөрөмжийг ашиглан 1700 гаруй иргэнд тусламж, амбулаторийн болон явуулын тусламж, үйлчилгээг хүргэн ажилласан байна. Үүнээс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад 72 иргэнийг онош тодруулахаар илгээж, мэргэжлийн тусламж, үйлчилгээг авч ажилласан. Мөн энэ онд Улиастай сумын Дөрвөн-Оноо, Биндэргарав өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр Мобайл технологийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн, тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 6 СЭМТ, 2 ӨЭМТ, нийт 8 эрүүл мэндийн байгууллага Мобайл технологийн тоног төхөөрөмжийг тусламж, үйлчилгээндээ ашиглаж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад бусад 13 эрүүл мэндийн байгууллагыг Мобайл технологийн тоног төхөөрөмжөөр хангах тухай хүсэлтийг хүргүүлсэн. | 100 |
| 2.1.4.1 | Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ | “Чадварлаг эмч” арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 85 | 0 | 100 | 30 | 2023 онд 13 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж, эмч, сувилагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд 10.0 сая, Сувилагч мэргэжлийг сурталчлах үйл ажиллагаанд 4.0 сая, “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл завханчууд” 2 сарын аянд 8.0 сая, эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулж урамшуулахад 4.0 сая, цусны донорыг сурталчлах, донор бэлдэх үйл ажиллагаанд 2.0 сая, алслагдсан сум, багийн иргэдэд “Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх” явуулын үзлэг, оношилгоог зохион байгуулахад 50.0 сая, “Чадварлаг баг хамт олон”-ыг шалгаруулж урамшуулахад 25.0 сая төгрөгийг зарцуулаад байна. Арга хэмжээний хүрээнд: Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарын 54 хувь нь, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарын 95 хувь нь үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэшил эзэмшсэн байна. АШУҮИС-тай хамтран “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага, Эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээ” агуулга бүхий сургалтад 350 гаруй эмнэлгийн мэргэжилтэн, ажлын байрны чадавхжуулах сургалтад давхардсан тоогоор 1100 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. Хөдөөгийн багийн 30 бага эмчийг мэргэжил дээшлүүлэх 14 хоногийн сургалтад хамруулсан байна. Нийт эмнэлгийн мэргэжилтний 27 хувь нь мэргэжлийн зэрэгтэй жилдээ 20 гаруй нь зэрэг хамгаалж байна. Говийн бүс, урд бүс, хойд бүсийн 9 сумандотор, эх барих эмэгтэйчүүд, халдварт/сүрьеэ, дүрс оношилгоо, лаборатори (Зөөврийн рентген, Элэгний B,C вирус, БЗДХ, сахар, холестерин, туберкулины сорил) нарийн мэргэжлийн эмч нарын явуулын эмнэлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээг зохион байгуулан ажиллаж, давхардсан тоогоор 9411 иргэнд хүрч үйлчилсэн. | 90 |
| 2.1.5.1 | Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ | Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, журмыг иргэдэд сурталчилна | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 15 | 0 | 50 | 5.0 | Танхимын сургалтыг ЭМД-ын тухай хууль, Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан 2022 оны ЭМДҮЗ-ийн 01, 05, 11 тогтоол, 2023 оны 6, 8-р тогтоолуудаар ЭМГ, АНЭ болон ӨСЭМТ-ийн мэргэжилтнүүдэд мэдээлэл өгч хамтран ажилласан 9 удаагийн сургалтаар 152 эмч мэргэжилтэн, 48 байгууллагын дарга сумын Засаг даргад, иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх сургалтыг 6 байгууллагын 80 гаруй ажилтан албан хаагчдад зохион байгуулсан. Цахим болон онлайн сургалтыг Эрүүл мэдийн даатгалын тухай хууль, ЭМД-ын ач холбогдол, ЭМС-ын шинэчлэл, 2022 оны ЭМДҮЗ-ийн 01, 02, 05, 06 дугаар тогтоол, 2023 оны 6, 8 дугаар тогтоолуудын талаар 9 удаа хийж давхардсан тоогоор 238 эмч албан хаагч хамрагдсан. Эмийн сангийн эрхлэгч нарт цахим сургалтыг 3 удаа зохион байгуулж 35 эмийн сан хамрагдсан. ЭМД-ын хэлтсийн Facebook хуудасны хандалтын тоог нэмэгдүүлж ЭМДЕГ-аас гаргасан мэдээ мэдээллийг орон нутгийн хамгийн олон дагагчтай 8, эрүүл мэндийн байгууллагын 5, ахмадын байгууллагын 2, 24 сумын 24 facebook групп, чат болон мессенжер групт (Нийгмийн даатгалын байцаагч нарын групп, Эрүүл мэндийн байгууллагын ажилтан нарын групп, Байгууллагын дарга нарын шуурхай ) байршуулж байна. Хэлтсийн Page хуудасны дагагчийн тоог 340-аар өсгөж 544 дагагчтай болсон. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5.2 | | Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг чадавхжуулна | 2021-2024 | ЭМГ, АЗДТГ | ОНТ | 25 | 0 | 7 | 15.0 | Эрүүл мэндийн газрын байранд шилжүүлж, 4 өрөө тасалгаанд байршуулж, ажлын байраар хангасан. | 100 |
| **2.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **89.64** |
| **2.2** | **Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжин, тамирчдын тив, дэлхий, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ** | | | | | | | | | | |
| 2.2.1.1 | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлнэ | Спортын холбоо, магадлан итгэмжлэгдсэн клуб, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагаа дэмжинэ | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 30.0 | 35.0 | 10.0 | 10.0 | Сар шинийн харваа -2023" үйл ажиллагаанд 2.8 сая, Даян мэргэн арга хэмжээнд 15,0 сая, аймгийн үндэсний харвааны цол хүртсэн харваачдад 962.0 мянга, аймгийн Дартсын холбоонд 2.0 сая, аймгийн Хөл бөмбөгийн холбоонд 4.2 сая, Цогтфитнесс клубт 1.0 сая, Берлин 2023 дэлхийн зуны тусгай олимпын волейболын төрөлд оролцох тамирчдад 7.0 сая, Самбо бөхийн азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцогч Бямбадоржид 1.5 сая, аймгийн Марафон гүйлтийн тэмцээнийг зохион байгуулахад 1.0 сая, Хүүхдийн спортын VII наадамд оролцогч тамирчдад 10.0 сая, баруун бүсийн сагсан бөмбөгийн тэмцээнд 3.5 сая, Ахмад шатарчдын тэмцээнд 1.1 сая, Я.Доржийн нэрэмжит "Завхан цом"-2023 өсвөр үеийн жүдо бөхийн тэмцээнд 8.0 сая, нийт 58,1 сая төгрөгийн дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас үзүүлсэн байна. | 100 |
| 2.2.1.2 | | Зарим суманд биеийн тамирын арга зүйчийг орон тоогоор ажиллуулна | 2021-2023 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 0.0 | 2 | 8 | 0.0 | Баянтэс суманд орон тооны арга зүй ажиллаж, Тосонцэнгэл, Их-Уул, Сантмаргац, Сонгино, Тэс суманд хавсран гүйцэтгэж байна. | 70 |
| 2.2.1.3 | | "Хөдөлгөөн – Эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 20.0 | 10% | 70% | 5 | Хөдөлгөөн-Эрүүл мэнд арга хэмжээний зорилтын хүрээнд: "Амка dance" бүжгийн клуб, "Цогт фитнесс" бялдаржуулах төв, "Амар амьдрал" ТББ , "Ахмадын хороо"-той хамтран ажиллаж байна. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулья", "Энэ жилдээ - эрүүл жиндээ" аяны хүрээнд эрүүл зохистой болон таргалалтын үеийн 4-5 төрлийн хоол, зутан, зуушны үзэсгэлэнг гаргаж, олон нийтийн сүлжээгээр түгээн ажиллалаа. ТҮМЭН дасгалыг ажлын байран дээрээ хийж хэвшсэн байгууллага, иргэд 30 хувьтай байна. Сум бүрд явган аялал алхалт, идэвхтэй хөдөлгөөнийг хийж хэвшээд байгаа бөгөөд аймгийн хүн амын 40 хувь нь идэвхтэй хөдөлгөөнийг хийж хэвшээд байна Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Нийтийн биеийн тамир, спортод цаг гаргая" 2 сарын аяны хүрээнд нийтийг хамарсан биеийн тамир, спортын уралдаан тэмцээнүүд, дугуйн аялал, бүх нийтийн алхалт, уулын аялал, чийрэгжүүлэлт, фитнес, клубийн үйл ажиллагаа, өглөөний дасгал, гүйлт, шугаман бүжиг, биелгээ гэсэн төрлөөр 50 гаруй үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 24 сумын 60139 хүн хамрагдсан. Аяны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байгууллага, иргэд аж ахуй нэгж, сумдыг урамшуулж 5.0 сая төгрөг зарцуулсан байна. Цэцэрлэг, сургуулийн нийт суралцагчдын 85 хувь нь өдөр тутам дасгал хөдөлгөөн хийж, ЕБС их завсарлагааны дасгалыг хийж байна. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, оролцоо нэмэгдсэн. Албан байгууллага, аж ахуй нэгж, спортын холбоодтой хамтран Завхан аймагт улс, бүсийн чанартай 5 тэмцээн уралдааныг зохион байгуулсан. (Амар амьдрал ТББ, Amka dance бүжгийн клуб нь спорт бүжгийн 170 сургагч багш бэлтгэсэн. 500-1000 хүний бүрэлдэхүүнтэй бий биелгээ, шугаман бүжиг, нийтийн спорт бүжгийн тоглолт хийсэн.) ЕБ-ын 13 сургууль бялдаржуулах кабинетыг байгуулж, тоног төхөөрөмжтэй болсон байна. (Алдархаан, Асгат, Баянтэс, Баянхайрхан, Завханмандал, Дөрвөлжин, Нөмрөг, Сантмаргаз, Түдэвтэй, Цагаанчулуут, Улиастай ЕБ-ын 3-р сургууль) | 90 |
| 2.2.2.1 | Үндэсний болон мэргэжлийн спортыг хөгжүүлнэ | Үндэсний спортыг хөгжүүлж, улсын чанартай уралдаан тэмцээнийг орон нутагт зохион байгуулна | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 110.00 | 1 | 1 | 40.0 | Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын баруун бүсийн сагсан бөмбөгийн тэмцээнийг аймагт зохион байгуулж, үйл ажиллагаанд нь аймгийн Засаг даргын нөөц сангаас 3.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Тэмцээнд Увс, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан аймгийн 120 тамирчин оролцож, аймгийн эрэгтэй, эмэгтэй баг тамирчид 1, 3 байранд шалгарч Баянхонгор аймагт зохион байгуулагдах хүүхдийн спортын шигшээ тэмцээнд оролцох эрх авсан. Завхан аймгийн Алдархаан сумын уугуул, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Пүрэвийн Жигжидсүрэнгийн нэрэмжит "Ахмад шатарчид"-ын улсын аварга шалгаруулах 18 дахь удаагийн тэмцээнийг 2023 оны 06 дугаар сарын 24-25 ны өдрүүдэд зохион байгуулсан. Монголын "Хөл бөмбөгийн холбоо"-оос санаачлан 21 аймгийн түвшинд зохион байгуулж буй Грассрүүдтс сургалт, аймгийн Засаг даргын нэрэмжит өсвөрийн U14, U16 насны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж аймгийн Засаг даргын нөөц сангаас 4.2 сая, Сантмаргаз сумын харьяат самбо бөхийн дэлхийн хошой мөнгө, жүдо бөхийн олон улсын тэмцээний алт, мөнгө, хүрэл медальт олон улсын хэмжээний мастер Янжмаагийн Доржийн нэрэмжит "Завхан цом"-2023 өсвөр үеийн жүдо бөхийн тэмцээнийг үндэсний хэмжээнд 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулж аймгийн Засаг даргын нөөц сангаас 8.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. | 100 |
| 2.2.2.2 | | Спортын шүүгч, дасгалжуулагчийг бэлтгэж, хүний нөөцийг бэхжүүлнэ | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 35.0 | 10 | 50.0 | 20.0 | Монголын волейболын холбооноос 2023 оны 2 сарын 23-28 нд Ховд аймгийн волейболын шүүгчийн сургалтыг зохион байгуулж, аймгаас биеийн тамирын багш нарыг хамруулан Волейболын нэгдүгээр зэргийн шүүгчээр Тосонцэнгэл-1, Улиастай-2, Түдэвтэй-1 нийт 4 багшийг бэлдсэн байна. 2023 оны 05 сарын 19-21 нд Сант суманд үндэсний бөхийн гарын даа бэлтгэх сургалтыг зохион байгуулж, үндэсний бөхийн 3 шүүгч бэлдсэн. | 100 |
| 2.2.2.3 | | Аймгийн Засаг даргын дэргэд "Өсвөрийн шигшээ баг"-ийг байгуулна | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 80.00 | 0 | 9 | 20.0 | Аймгийн Засаг даргын дэргэд "Өсвөрийн шигшээ" багийг жүдо бөх, чөлөөт бөх, волейбол, сагсан бөмбөг, хөл бөмбөг, үндэсний сур, ширээний теннис, цанын спорт гэсэн 8 төрлөөр байгуулагдсан. 2023 оны Монгол Улсын аварга шалгаруулах чөлөөт бөхийн U15 ангиллын тэмцээнээс 3 хүрэл медаль хүртэж охидын багийн дүнгээр 3-р байр, Самбо бөхийн өсвөрийн Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 9 медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр, U-15 насны волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд охид тэргүүн байр, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах волейболын тэмцээнээс хөвгүүд мөнгөн медаль хүртсэн, нийт өсвөрийн шигшээ багийн тамирчид 5 алтан медаль, 3 мөнгөн медаль, 7 хүрэл нийт 41 медаль хүртсэн. | 100 |
| 2.2.2.4 | | Биеийн тамир, спортын байгууллагыг тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 400.0 | 0 | 10 | 100.0 | Даян мэргэн арга хэмжээний хүрээнд 24 сумын сургуулийг шагайн харвааны иж бүрэн зурхайгаар хангасан. Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төвд сагсан бөмбөгийн шийт авахад зориулж аймгийн Засаг даргын нөөц сангаас 1.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.3.1 | Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн байгууллагын тоог нэмэгдүүлж. | Сургууль түшиглэсэн бялдаржуулах төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 20.0 | 2 | 8 | 5.0 | Орон нутгийн төсвийн 5,0 сая төгрөгийн дэмжлэгээр Улиастай сумын ЕБ-ын 3-р сургуулийг бялдаржуулах төвийн тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагаа тогтмол явагдаж байна. | 100 |
| 2.2.4.1 | Иргэдэд үйлчлэх нийтийн спорт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ | Нийтийн биеийн тамир, соёл амралтын хүрээлэнг өргөжүүлнэ | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 460.0 | 12 | 25 | 120.0 | Аймгийн сум бүрт хүүхдийн тоглоомын талбай, Улиастай сумын 6 багийн нутаг дэвсгэрт хүүхдийн тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбайг байгуулан хүүхэд тоглох, чөлөөт цагаа өнгөрөөх орчин бүрдсэн. Улиастай сумын Богдын гол багт "Соёл амралтын хүрээлэн" -нд сагс, волейбол, хөл бөмбөгийн талбай, дугуйн төрөл, дасгал хөдөлгөөн хийх талбайг байгуулж, нйитийн биеийн тамираар хичээллэх орчныг бүрдүүлж өдөртөө 100 -аас дээш тооны иргэд хамрагдаж байна. 2023 онд Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, иргэд нийтээрээ агаар, салхинд байх ногоон орчныг бүрдүүлсэн "Гэрэлт гудамж" -ийг орон нутгийн төсвийн 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж, Улиастай сум хариуцан зохион байгуулж худалдаа үйлчилгээний цэгүүдийг байршуулсан байна. | 90 |
| 2.2.5.1 | Эрүүл зөв хооллох дадал, хэвшлийг бүх нийтэд түгээн дэлгэрүүлнэ | Эрүүл, хооллолт, фитнесс клуб, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжинэ | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 15.0 | 3 | 12 | 5.0 | Аймгийн Дартсын холбоонд 2.0 сая, аймгийн Хөл бөмбөгийн холбоонд 4.2 сая, Цогтфитнесс клубт 1.0 сая, сагсан бөмбөгийн холбоонд 3.5 сая, Ахмад шатарчдын холбоонд 1.1 сая, Жү-до бөхийн холбоонд 8.0 сая нийт 19.8 сая төгрөгийн дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас үзүүлсэн байна. | 100 |
| 2.2.6.1 | Зорилтот бүлгүүдэд чиглэсэн амралт сувиллын газрын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөдөлгөөн заслын кабинет, талбайг байгуулна | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 50.0 | 200 | 400 | 20.0 | "Хөдөлгөөн -Эрүүл мэнд" арга хэмжээний зорилтын хүрээнд 2022 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган орон нутгийн төсвийн 8.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. 2023 онд Улмажлалт нөхөн сэргээх тасагт сэргээн засах үйлчилгээг 609 ХБ-тэй, архаг суурь өвчтэй 89 иргэнд хүргэсэн байна. Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг долоо хоног бүр спорт зааланд дасгал, хөдөлгөөн хийж, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Алхалт, дугуй, гүйлтийг дэмжих саруудын хүрээнд арга хэмжээнүүдийг зохион явуулж, аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 150 гаруй ахмад хамрагдлаа. Ахмадын биеийн тамирын арга хэмжээг нэгдсэн удирдамжийн дагуу Софт волейбол, ширээний теннис, бүжиг, шатрын төрлөөр явуулж, Улиастай сумын ахмадуудын дунд явагдсан арга хэмжээнд 3,500,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна. | 100 |
| 2.2.7.1 | Бие бялдарын сорилыг чанартай зохион байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ | Аймгийн хэмжээнд бие бялдрын түвшин тогтоох сорилыг бүх шатанд зохион байгуулна | 2021-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 15.0 | 4.5% | 20% | 5.0 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 5-аа с дээш насны хүүхдүүд, төрийн болон аж ахуй нэгж байгууллагын албан хаагчдыг хамруулан бие бялдрын түвшин тогтоох сорилыг жил бүрд авч байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар 18000 хүн хамрагдсанаас 10000 –ийг хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын нэгдсэн программд мэдээллийг оруулсан. Зорилтод хүн амын 35 хувийг хамруулсан мэдээлэл байна. | 100 |
| 2.2.8.1 | Цогцолбор сургуулиудыг түшиглэн биеийн тамирын төрөлжсөн салбар ангиудыг нээнэ | Цогцолбор сургуулиудыг түшиглэн биеийн тамирын төрөлжсөн салбар анги нээнэ | 2022-2024 | БТСГ,АЗДТГ | ОНТ | 25.0 | 0 | 45.0 | 10.0 | Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/559 дугаар захирамжаар Улиастай сумын ЕБ-ын лаборатори Чандмань-Эрдэнэ сургуульд спортын төрөлжсөн анги нээн ажиллуулахад зориулж 5,000,000 сая төгрөгийг олгосон. Сургалтын хөтөлбөрийг БШУГ-ын даргаар батлуулж хэрэгжилтийг хангаж байна. | 70 |
| **2.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **93.85** |
| **2.3** | **Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон, насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 2.3.1.1 | Хамран сургалтыг нэмэгдүүлнэ | Боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 11.0 | 83.7% | 86.7% | 3 | Төрийн өмчийн 38 цэцэрлэгийн 192 бүлэгт 4968, хувилбарт сургалтын14 бүлэгт 203, төрийн бус өмчийн 2 цэцэрлэгийн 4 бүлэгт 97 хүүхэд нийт 5268 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, цэцэрлэгийн хамран сургалт 82.5%, хувилбарт сургалтын хамран сургалт 3.8%, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 85.8% байна. Ерөнхий боловсролын 29 сургуулийн 628 бүлэгт 15611 суралцагч, Хөгжим бүжгийн коллежийн 4 бүлэгт 61 суралцагч нийт 632 бүлэгт 15672 суралцагч суралцаж, бага боловсролын хамран сургалт 96.4%, суурь боловсролын хамран сургалт 93.8% байна. Их-Уул сумын I, Тосонцэнгэл сумын III, V, VI, Тэлмэн сумын цэцэрлэгт шинээр тус бүр 1 бүлэг нэмж 130 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, цэцэрлэгийн хамран сургалт 3%, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 3.3%, бага боловсролын хамран сургалт 0.3%-иар тус тус нэмэгдсэн байна. | 100 |
| 2.3.1.2 | | Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулна | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 155 | 30% | 60% | 50 | 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 56 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Насан туршийн боловсролын хүрээнд сургууль завсардсан хөгжлийн бэрхшээлтэй гэрийн асаргаанд байдаг 72 хүүхдэд гэрийн явуулын сургалтаар боловсролд тэгш хамруулах ажлыг зохион байгуулсан. Мөн НҮБ-ын хүүхдийн сангийн дэмжлэгээр 400 ширхэг радио төхөөрөмжийг сургууль завсардсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгож, Тосонцэнгэл сумын 1-р сургуульд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд" зориулсан танхимыг шинээр байгуулснаар сургуулийн гадна буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурч хөгжих боломж бүрдсэн. 2023-2024 оны хичээлийн жилд 0-16 насны тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай 211 байна. Дээрх хүүхдүүдтэй ажиллаж байгаа багшид цалингийн нэмэгдэл урамшуулал өгөх, мөн ганцаарчилсан хөтөлбөрөөр ажиллах арга зүйн сургалт, зөвлөмжийг цэцэрлэг, сургуулиудад хүргүүлэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.1.3 | | Насан туршийн боловсрол олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 438 | 23% | 45 | 148 | 2022-2023 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрөөр 217 хүүхэд хамрагдсан. Энэ хичээлийн жилд шинээр элссэн 11, үүнээс бага боловсролд 9, суурь боловсролд 94, бүрэн дунд боловсролд 114 суралцагч суралцаж байна. Боловсролын ерөнхий хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан аймгийн Насан туршийн суралцахуйн төвийг шинэчлэн байгуулж, бүтэц орон тоог баталж, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох ажил хийгдэж байна. | 90 |
| 2.3.2.1 | Бүх шатны сургалтын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлнэ | Бүх шатны сургалтын байгууллагыг чанарын үнэлгээний судалгаанд амжилттай хамруулна | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 55 | 38% | 60.0% | 15 | БШУ-ны сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын дагуу "Чанарын үнэлгээний судалгаа"-г 2022.10.18-21-нд зохион байгуулж, Тосонцэнгэл сумын лаборатори 1-р сургууль, Улиастай сумын Жавхлант цогцолбор сургууль, Улиастай сумын лаборатори Чандмань-Эрдэнэ сургууль, Политехник коллеж Тосонцэнгэл сум дахь МСҮТ хамрагдлаа. Уг судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн 6,10,12 дугаар ангийн хүүхдүүд, Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагаас 2-3 дугаар курсын суралцагчдыг түүврийн аргаар сонгож, бичгийн шалгалт, асуулга судалгаа, ажиглалт, фокус ярилцлага, орчны үнэлгээний судалгаа гэсэн үзүүлэлтээр 12 дугаар ангийн 120, 10 дугаар ангийн 140 суралцагч хамрагдсан. БШУ-ны сайдын 2023 оны А/56 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ”-г 2023.03.27-31-нд автомашины засварчин, барилгын засал-чимэглэлчин, барилгын сантехникч, гагнуурчин, оёмол бүтээгдэхүүний оёдолчин, тогооч, барилгын цахилгаанчин, үсчний мэргэжлээр бичгийн шалгалт, асуулга судалгаа, хичээл ажиглалт, бүлгийн ярилцлага хэлбэрээр зохион байгуулж, Тосонцэнгэл сумын МСҮТ-ийн удирдлага 2, мэргэжлийн багш 5, суралцагч 7, Политехник коллежийн удирдлага 2, мэргэжлийн багш 5, суралцагч 36 хамрагдаж, ажил олгогч, төгсөгч, эцэг, эх, асран хамгаалагч нар асуулга судалгаанд оролцлоо. Чадамжийн төвийн чанарын үнэлгээ Политехник коллежид 2023.10.09-10-нд хийгдлээ. | 100 |
| 2.3.2.2 | | Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 290 | 24 сургуулийн хэмжээст оноо 478 | 490 | 80 | 2022-2023 оны хичээлийн жилд Монгол хэл, бичгийн шалгалтад 828 шалгуулагч бүртгүүлснээс 815 шалгуулагч шалгалтад хамрагдсанаас 125 шалгуулагч 400-аас бага оноо авсан байна. 2022-2023 оны хичээлийн жилд ЭЕШ-ын хэмжээст оноог нэмэгдүүлэхийн тулд ерөнхий боловсролын сургуулиуд өөрийн хөрөнгөөр "ЭЕШ-800" платформыг худалдан авахад 20,0 сая төгрөгийг зарцуулж, "Grand IT" компанитай хамтран хэрэгжүүлж, программд 10 судлагдахуунаар давхардсан тоогоор 1068 суралцагч, 360 багш сар бүр элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх сорилго тест дээр ажилласан байна. БШУГ-ын мэргэжилтнүүд, мэргэжлийн хөгжлийн бүлгийн чиглүүлэгч багш нартай хамтран математик, англи хэл, монгол хэлний судлагдахуунаар Цагаанчулуут сумын ЕБС, Тосонцэнгэл сумын лаборатори 1-р сургууль, Түдэвтэй сумын ЕБС, Тэс сумын ЕБС, Улиастайн бүсэд танхимаар зохион байгуулахаар төлөвлөж, англи хэлний хичээлээр 553, монгол хэлний хичээлээр 299, математикийн хичээлээр 712 суралцагч тус тус хамрагдахаар бүртгүүлсэн байна. Урд бүсийн сургалтыг Цагаанчулуут сумын ерөнхий боловсролын сургуульд 1-р улирлын амралтаар зохион байгуулж 57 суралцагч хамрагдсан. | 90 |
| 2.3.2.3 | | Олимпиад, уралдаан тэмцээнд оролцогчдын амжилтыг ахиулна | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 165 | 0 | 6% | 45 | 2022-2023 оны хичээлийн жилийн Улсын төрөлжсөн олимпиадын хоёрын давааг аймагтаа амжилттай зохион байгуулж, ерөнхий боловсролын 29 сургууль, мэргэжлийн боловсролын 1015 багш, суралцагч оролцсон ба аймгийн Засаг дарга амжилттай оролцсон багш, суралцагчдыг урамшуулахад 5.0 сая төгрөгийг зарцууллаа. Олимпиадын 2-ын даваанд эхний байр эзэлсэн 44 багш, суралцагчид Улаанбаатар хотод гурвын даваанд амжилттай оролцож, Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн 11 дүгээр ангийн суралцагч С.Энхтуяа газар зүйн хичээлээр III байр эзэлж, хүрэл медалиар шагнагдсан. Мөн Сантмаргаз сумын ерөнхий боловсролын сургуулийн суралцагч Э.Санчирмаа Хэл иргэншлийн хүрээлэнгээс зохион байгуулсан "Сайхан бичигтэн" уралдаанд улсад III байр, Улиастай сумын лаборатори Чандмань-Эрдэнэ сургуулийн суралцагч Б.Өнөрсайхан Олон улсын логик паззлын уралдаанд III байр эзэлсэн байна. Өглөөний уншлага Үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан Улсын уралдаанд Улиастай сумын ерөнхий боловсролын III сургуулийн Ц.Наранчимэг багштай 4а анги II байр, STEM боловсролын улсын уралдаанд Эрдэнэхайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын багш А.Долгормаа шилдэг 10 багшид шалгарч, улсын уралдаанд тусгай байр эзэлсэн. | 100 |
| 2.3.2.4 | | Танхимын сургалтыг цахим сургалттай хослуулан хэрэгжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 55 | 100% | 100% | 15 | Улиастай сумын ерөнхий боловсролын сургуулиуд, МСҮТ, ХБК-ийн англи хэлний багш нарт ”Excel” хөтөлбөрийн багш Lisa Renae Klempel, Deporah Fenton, Christopher William Neil нар Excel ангид 18 багш, Enrichment ангид 14 багш тус тус хамрагдаж, нэгдүгээр улиралд нийт 64 цагийн хичээл, face to face хичээлийн 180 цаг, 90 цагийн хичээлд ажиглалт хийж зөвлөгөө өгсөн. 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 24 сургуулийн 12 дугаар ангийн 845 суралцагчийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх “ЭЕШ 800" программ хангамжийг "Гранд Ай Ти" ХХК -тай хамтран хэрэгжүүлж байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 3,4 дүгээр ангид математикийн хичээлийн "Eduten", 5,6 дугаар ангийн Англи хэлний хичээлийн "Pearson" цахим хөтөлбөр,"Medlee" цахим сургуульд ерөнхий боловсролын сургуулийн 10,11 дүгээр ангийн 769 суралцагч хамрагдаж байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.3.1 | | Сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байрын орчны гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 194 | 66% | 87% | 50 | 2022-2023 оны хичээлийн жилд Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд 22 дотуур байр буюу нийт байрын 84% нь орон нутгийг хөгжүүлэх сан болон байгууллагын хөрөнгө, эцэг эхчүүдийн дэмжлэгтэйгээр камержуулалт хийсэн. Боловсрол шинжлэх ухааны газраас 2023-2024 оны хичээлийн жилд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор камерын ашиглалтын бүрэн байдалд үнэлгээ дүгнэлт өгч, орон нутгийг хөгжүүлэх сангийн дэмжлэгтэйгээр хичээлийн байранд 7-9 камер, дотуур байруудад 5-6 камерыг шинээр суурилуулах төлөвлөлт хийж байна. Сургууль, цэцэрлэг, дотуур байриуд гадна гэрэлтүүлгээр хангагдсан, хэвийн ажиллаж байна. | 100 |
| 2.3.3.2 | | Боловсролын байгууллагыг стандартад нийцсэн ус, ариун цэврийн байгууламжаар хангахад дэмжинэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 500 | 24 | 31 | 135 | Сургалтын байгууллагын нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих ажлыг 4 ээлжээр зохион байгуулсан. 1,2-р ээлжийн ажлыг Улсын төсвийн 7197.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 13 сумын 42 обьектийг "Жавхлант Тур", "Сипи Медиа", "Сантех Увс", "Хатан Түнгэл" ХХК гүйцэтгэж , Асгат, Баянтэс, Тэс, Баянхайрхан, Ургамал, Отгон, Яруу, Нөмрөг, Сантмаргаз, Сонгино, Цагаанхайрхан, Түдэвтэй, Дөрвөлжин сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрыг стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжаар сольсон. 3-р ээлжинд Улиастай, Алдархаан, Идэр, Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн, Цагаанчулуут, Шилүүстэй, 4-р ээлжинд Эрдэнэхайрхан, Завханмандал, Цэцэн-Уул нийт 11 сумын нийт 62 обьектийг ариун цэврийн байгууламжаар солихоор 3-р ээлжийн зураг төсвийн ажлыг "Ноёдын тур" ХХК, 4-р ээлжийн зураг төсвийн ажлыг "Хидро инженеринг" ХХК хийж гүйцэтгэн, магадлалаар хянагдаж байна. | 100 |
| 2.3.3.3 | | ЕБС-ийг хүүхэд тээврийн зориулалтын автомашинаар үе шаттай хангана | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 255 | 7 | 11 | 75 | Улиастай сумыг Хүүхэд тээвэрлэх зориулалтын автобусаар хангах зорилгоор дунд оврын 2 автобус авч тээврийн үйлчилгээ үзүүлж байна. | 100 |
| 2.3.3.4 | Сургалтын орчны аюулгүй байдлыг сайжруулна. | "Хүүхдэд ээлтэй дотуур байр" арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 5800 | 8 | 15 | 1000 | Энэ хичээлийн жилд дотуур байранд 1586 хүүхэд амьдарч байгаагийн 1356 буюу 90.7 хувийг малчдын хүүхэд эзэлж байна. 2022 онд ОНХС-ийн 14.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Асгат, Завханмандал, Отгон, Тэлмэн сумын сургуулийн дотуур байр, Тайваны хүүхдийн сангийн 23.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэхайрхан, Сонгино, Түдэвтэй сумын сургуулийн дотуур байр, Улиастай сумын ерөнхий боловсролын лаборатори Чандмань-Эрдэнэ сургуулийн дотуур байр, 2023 онд ОНХС-ийн 18,0 сая төгрөгийн хөрөнгөөр Улиастай сумын Жавхлант цогцолбор сургууль, Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургууль, Баянтэс сумын сургуулийн дотуур байрыг тус тус зөөлөн эдлэлээр хангасан. 2022 онд ОНХС-ийн 40,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Их-Уул, Идэр, Сантмаргаз, Тосонцэнгэл сумын сургуулийн дотуур байрыг "Хүүхэд хөгжлийн танхим", Тайваны хүүхдийн сангийн 10.493 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улиастай сумын лаборатори Чандмань-Эрдэнэ, Цагаанчулуут, Тэс, Дөрвөлжин, Баянтэс, Отгон, Идэр сумын сургуулийн дотуур байранд "Номын өргөө" байгуулж, Японы хүүхдийг ивээх сангийн 90,0 сая төгрөгийн хөрөнгөөр Нөмрөг, Их-Уул, Баянтэс, Тэс, Цагаанчулуут сумын дотуур байранд зөөлөн эдлэл нийлүүлж, суралцагчдад хичээлийн хэрэглэл дулаан гутал олгосон. Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 100 ортой дотуур байр ашиглалтад орж, Асгат, Цэцэн-Уул сумын 100 ортой дотуур байрын барилга баригдаж, Баянхайрхан, Отгон сумын дотуур байр засвар хийгдсэн. Зөөлөн эдлэлээр хангагдсан дотуур байр 16, "Хүүхэд хөгжлийн төв"-тэй дотуур байр 4, Номын өргөө байгуулсан дотуур байр 7, шинээр ашиглалтад орсон 1, засвар хийгдсэн 2, баригдаж байгаа 2 байна. | 100 |
| 2.3.3.5 | | Сургалтын байгууллагын материаллаг бааз, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг сайжруулна | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 320 | 18 | 50 | 70 | 2021 онд ОНХС-ийн 80,0 сая төгрөгийн хөрөнгөөр Улиастай сумын ерөнхий боловсролын 5 сургууль, Тосонцэнгэл сумын 1,2 дугаар сургууль, Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуульд, 2022 онд ОНХС-ийн 150,0 сая төгрөгийн хөрөнгөөр Идэр, Тэлмэн, Нөмрөг, Түдэвтэй, Сонгино, Тэс, Баянтэс, Яруу, Дөрвөлжин, Сантмаргаз, Шилүүстэй сумын ерөнхий боловсролын сургууль, Улиастай сумын 1,4,9-р цэцэрлэг, Тосонцэнгэл сумын 5 дугаар цэцэрлэгт, 2023 онд ОНХС-ийн 50,0 сая төгрөгийн хөрөнгөөр Завханмандал, Ургамал, Цагаанчулуут сумын ерөнхий боловсролын сургууль, МУ-ын Консерваторийн харьяа ХБК, Политехник коллежид "Багш хөгжлийн төв"-ийг байгуулсан. 2022-2023 оны хичээлийн жилд БШУЯ-ны 141,826 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тавилга тоног төхөөрөмжийг 7 сургуульд (Сантмаргаз 32,366 сая, Түдэвтэй 11,213 сая, Завханмандал 25,366 сая, Сонгино 18,600 сая, Эрдэнэхайрхан 27,066 сая, Идэр14,137 сая, Улиастай ЧЭС 13,078 сая), БШУЯ-ны 35,773 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гал тогооны тавилга тоног төхөөрөмжийг 1 сургууль, 1 цэцэрлэгт ( Цэцэн-Уул 30.0 сая, Сантмаргаз хүүхдийн цэцэрлэг 5,773 сая), Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19 цэцэрлэгт 272.1 сая төгрөгийн гадна талбайн тоног, төхөөрөмж, 14 цэцэрлэгт 97.9 сая төгрөгийн хөгжмийн тоног төхөөрөмж, 29 сургуульд 736.2 сая төгрөгийн хөгжмийн тоног төхөөрөмж, 125.7 сая төгрөгийн өнгөт телевизор, зөөврийн компьютер олгогдсон. 23 сургууль,4 цэцэрлэгт Багш хөгжлийн төв байгуулсан. Гадна тоглоомын талбай, хөгжмийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, гал тогооны тоног төхөөрөмж сайжирсан. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.3.6 | | Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 8082 | 0 | 100% | 2500 | 2023-2024 оны хичээлийн жилд Үдийн хоолонд бага боловсролын 7450 суралцагч буюу нийт суралцагчдын 46.6% хамрагдаж байна. 2022 онд ОНХС-ийн 120,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Завханмандал, Отгон, Эрдэнэхайрхан, Сонгино сумын ерөнхий боловсролын сургууль, Нөмрөг сумын цэцэрлэг, Улиастай сумын VI цэцэрлэгийг I, II хоолны тогоо, цахилгаан жигнүүр, цахилгаан пийшин, аяга таваг ариутгагч зэрэг тоног төхөөрөмжөөр хангасан. БШУЯ-ны 30,0 сая төгрөгийн санхүүжилтээр Цэцэн-Уул сумын ерөнхий боловсролын сургуульд гал тогооны тоног төхөөрөмж, Сантмаргаз сумын хүүхдийн цэцэрлэгт 5,773 сая төгрөгийн санхүүжилтээр гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. 2023 онд Улиастай сумын 3 цэцэрлэгийг ОНХС-ийн 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар I, II хоолны тогоо, цахилгаан жигнүүр, цахилгаан пийшин, цахилгаан махны машин, цахилгаан будаа агшаагчаар хангасан. БШУЯ-ны 6.3 сая төгрөгийн санхүүжилтээр Баянтэс сумын ЕБС-ийн гал тогоонд аяга хатаагч, ариутгагч, цахилгаан гурил зуурагч, Баянхайрхан сумын ерөнхий боловсролын сургуульд аяга таваг угаагч, хатаагч, ариутгагч автомат машин, шарах шүүгээ, цахилгаан гурил зуурагч тус тус хангасан. БШУГ, Баянтэс, Их-Уул, Тэлмэн, Тосонцэнгэл 1, 2, Баянхайрхан, Сантмаргаз сумын сургуульд "Хоол зүйч" ажиллаж байна. Ундны эх үүсвэрээ хангаж буй – 13, төвлөрсөн шугамд холбогдсон – 12, Зөөврөөр авч буй - 4 сургууль байна. Хоол зүйчтэй болсон сургуулийн тоо 7, тоног төхөөрөмжөө шинэчилсэн сургууль 7, цэцэрлэг 5 байна. | 100 |
| 2.3.4.1 | Хүүхдийн хөгжил хамгаалал, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээг хөгжүүлнэ | Хүүхэд залуучуудыг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ, БСУГ | ОНТ | 136 | 30% | 100% | 34 | 2022-2023 оны хичээлийн жилд хүүхдийн эрх хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд ГБХЗХГ-тай хамтран хүүхдийн зөвлөгөөнийг зохион байгуулж, 29 сургуулийн 1160 хүүхэд хамрагдсан. Мөн Боловсрол шинжлэх ухааны газраас анги удирдсан багш ангитайгаа хэрхэн ажиллах эцэг, эх асран хамгаалагч нарт "Хүүхдийн эрх хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн нас сэтэхүйн" онцлогийн талаар мэдээлэл, зөвлөмж, хичээл боловсруулан хүргүүлсэн. Сургуулиуд орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн гишүүдийн хамтаар зохион байгуулсан "Хорт зуршил, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам" сургалтад 29 сургуулийн 420 хүүхэд оролцсон. Улиастай сумын ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Электрон тамхинаас татгалзая" сарын аянг 2023 оны 11 сарын нээс 12 сарын 15- ны хооронд зохион байгуулж, 6-12 дугаар ангийн суралцагчдын дунд электрон тамхины хор хөнөөл түүнээс урьдчилан сэргийлэх арга зам сэдвийн хүрээнд цуврал сургалт зохион байгуулах, ханын сонин гаргах, тэмцээн, уралдааныг зохион байгуулж байна. | 100 |
| 2.3.4.2 | | Хүүхдийн хөгжил, төлөвшил, ёс зүйд чиглэсэн зөвлөх үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 168 | 14 | 44 | 40 | Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багш нар 1260 эцэг, эхчүүдэд "Хүүхдийн хөгжил төлөвшилд гэр бүлийн оролцоо" сэдвээр сургалт зохион байгуулсан. Улиастай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчид, багш, удирдах ажилтан, эцэг, эх асран хамгаалагч нартай “Мэргэжил бүхэн сайхан” уулзалт зохион байгуулж, 327 суралцагч, эцэг, эхийн 50 төлөөлөл, анги удирдсан багш, сургуулийн захирал, Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүдийн төлөөлөл 400 гаруй иргэд оролцлоо. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран ахмад багш нарын зөвлөх үйлчилгээг 2022-2023 оны хичээлийн жилд хэрэгжүүлж ахмад 3 багш 20 хүүхдэд хоцрогдол арилгах сургалт, багш нарт ёс зүй харилцаа хандлагын сургалтыг зохион байгуулж, 37 багшид зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. 2023 оны 2 сард цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, нийгмийн ажилтан нарт "Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, ёс зүй харилцаа хандлага" сэдвээр сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 112 удирдах ажилтан оролцлоо. | 100 |
| 2.3.5.1 | Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн баталгааг хангана | “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 190 | 20% | 50% | 60 | "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 удаа хэлэлцэн баталж, шилдэг 100 багшийг шалгаруулж, зөөврийн компьютероор шагнаж, урамшуулахад 200.0 сая төгрөг зарцуулсан. Сургалт, зөвлөгөөнд давхардсан тоогоор 2188 багш ажилтан, олимпиад, уралдаан тэмцээнд 1181 багш, туршлага судлах үйл ажиллагаанд 45 багш, удирдах ажилтан, мэргэжилтэн, урамшуулал, дэмжлэгт 124 багш, 5 сургууль тус тус хамрагдсан. Батлагдсан төлөвлөгөөний хүрээнд 28 үйл ажиллагаанд давхардсан тоогоор 3538 багш, удирдах ажилтан хамрагдаж, 100.0 сая төгрөг зарцууллаа. | 100 |
| 2.3.6.1 | Мэргэжлийн | Гадаад, дотоодын захиалгат сургалтын хөтөлбөрүүдийг мэргэжлийн сургуулийг түшиглэн хэрэгжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 25 | 0 | 3 | 7 | Ховд аймагт зохион байгуулагдсан Баруун бүсийн мэргэжлийн сургалтын байгууллагын удирдах ажилтан, багш нарын семинарт Монгол Улсын Консерваторийн харьяа Хөгжим бүжгийн Коллеж, Политехник коллеж, Тосонцэнгэл сумын МСҮТ, Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож, үр дүн, тулгамдаж буй асуудлуудаа тодорхойлон гаргаж, зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлсэн. Боловсролын Ерөнхий Газраас Олон улсын "Pearson English" англи хэлний цахим болон танхимын сургалт хосолсон цогц хөтөлбөрийг 39 ерөнхий боловсролын сургуульд туршиж байгаа бөгөөд Завхан аймгийн Алдархаан, Идэр сумын ерөнхий боловсролын сургуулиуд дээр амжилттай хэрэгжиж дууссан. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.6.2 | Мэргэжлийн сургуулиудын хөгжлийг дэмжиж, хамтран ажиллана | Аймгийн Засаг даргын ивээл дор Завхан аймгийг тогтвортой хөгжүүлэх эрдэм шинжилгээний хурлыг уламжлал болгон зохион байгуулна. | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 24 | 2 | 0 | 0 | "Завхан-100" эрдэм шинжилгээний бага хурлыг Улаанбаатар хотноо АЗДТГ, Завхан судлал төвтэй хамтран зохион байгуулсан. Хуралд Завхан нутгаас гаралтай эрдэмтэн судлаачид ,бизнес эрхлэгчид оролцож аймгийн эрчим хүч, хөдөлмөрийн зах зээл, зам харилцаа, дэд бүтэц, боловсролын хөгжлийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, мөн орон нутагтаа бордоо, жимс, зөгийн аж ахуйг байгуулах, геологи, уул уурхай, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар судалгаа шинжилгээнд тулгуурлан хэлэлцүүлж ОНТ-өөс 15.0 сая төгрөг зарцууллаа. БШУЯ, Шинжлэх ухаан Технологийн сан, Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний байгууллага, Шинжлэх ухааны академи, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран “Шинжлэх ухаан, технологи, инновацийг орон нутагт нутагшуулья” аян зохион байгуулж, "Бүс нутгийн хөгжил, төлөвлөлт, гарц шийдэл” бодлогын хэлэлцүүлэг, инновацийн бүтээгдэхүүний үзэсгэлэн, "Миний анхны инженерчлэл” workshop, “Стартап менторшип”, “SciCon-Завхан” шинжлэх ухаан, танин мэдэхүйн арга хэмжээ, "Засагт хан аймгийн Сартуул Сэцэн засгийн хошуу: Түүх, соёл” сэдэв эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдаж, 1000 гаруй хүүхэд, залуучууд, бизнес эрхлэгчид, эрдэмтэн судлаачид, төрийн албан хаагчид оролцлоо. Аймгийн Засаг дарга Монгол Улсын Шинжлэх ухааны академи, ШУ-ны академийн Түүх угсаатны зүйн хүрээлэн, ХААИС-тай хамтран ажиллах гэрээ байгууллаа. | 100 |
| **2.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **97.22** |
| **2.4** | **Судалгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулж, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр ашгийг нэмэгдүүлсэн байна** | | | | | | | | | | |
| 2.4.1.1 | Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардлыг нэмэгдүүлнэ | Мэргэжлийн сургуулийн судалгааны үр дүнг орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагаанд ашиглана. | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 24 | | 2 | 8 | МУИС- ийн Завхан сургуулийн багш нар аймгийн 38 цэцэрлэг, 30 сургуулийн 2016-2020 оны төсвийн зардалд шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Иргэдийн инновацийн санаачлагыг дэмжих MON-X хөтөлбөрийн хүрээнд орон нутагт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох судалгаа онлайнар хийгдэж хог хаягдал их, менежмент муу, үйлдвэрлэл бага, хэрэглээний халуун ус байхгүй гэсэн асуудал иргэдийн дундаас хамгийн тулгамдсан асуудал гэж тодорхойлогдож, 8 инновацлаг санаа оролцсон. Улсын шилдэг 40-д Завхан ногоон гарц нэгдэл ТББ-ын "Ногоон гарц эко төв"-ийн инновацлаг санаа шалгарсан. МУИС-ийн Завхан сургууль ЕБС-ийн ахлах ангийн суралцагчдаас мэргэжил сонголтын талаар, ажил олгогчдоос төгсөгчдөд тавьж буй шалгуур, эрэлттэй боловсон хүчний судалгаа авч байна. Тосонцэнгэл сумын МСҮТ нь 2022-2023 оны хичээлийн жилд эрэлттэй мэргэжлийн судалгаанд үндэслэн ойн нөхөрлөлийн ажилтан, ойн аж ахуйн ажилтан, уламжлалт мал ахуйн фермер, эрчимжсэн мал аж ахуйн фермер мэргэжлийн хөтөлбөрийг шинээр нээсэн. | 100 |
| 2.4.1.2 | | Алслагдсан бүс нутагт үүрэн холбооны дахин дамжуулах станц байгуулж, интернетийн сүлжээг өргөжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,БСУГ | ОНТ | 480 | 13 | 2 | 160 | 2023 онд Отгон сумд Мобиком-1, Юнител-1, Улиастай сумд Мобиком-1, Юнител-1 үүрэн холбооны дахин дамжуулах станц, Завханмандал, Цагаанчулуут сумдад Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн 25м өндөр цамхаг ашиглалтад орж, тус бүс нутгуудад үүрэн холбоо, интернэт үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн. | 100 |
| **2.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **100** |
| **2.5** | **Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэж, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжин амьдралын чанарыг дээшлүүлнэ** | | | | | | | | | | |
| 2.5.1.1 | Ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна | Ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 40 | 25.7% | 22% | 10 | Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн анхан шатны мэдлэг олгох, ажлын байран дахь харилцааны ур чадвар, сэтгэл зүйн сургалтад 4 сумын 75 залуучууд хамруулсан. Сургалтын үр дүнд анкет бэлтгэх, ажлын ярилцлагад бэлтгэх, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай танилцах түүнд тохируулан асуулгад бэлтгэх, ажлын байр бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг олж мэдэн түүнтэй хэрхэн танилцах зэрэг суурь ур чадварыг олгож иргэдийг хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх, ажил хөдөлмөр эрхлэх орлого ашиг олоход нь дэмжлэг үзүүлж байна. Мөн "Старт-Ап" залуучуудад гарааны бизнесийн дэмжлэг үзүүлэх сургалт, зөвлөгөө мэдээллийг өгч шалгарсан багт санхүүгийн дэмжлэг олгосон. | 100 |
| 2.5.2.1 | Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлнэ | Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 0 | 80% | 85% | | 2023 онд 1635 шинэ ажлын байр бий болгохоор төлөвлөснөөс байнгын ажлын байранд 332, улирлын ажлын байранд 60, түр ажлын байранд 657 нийт 1049 иргэн ажилд орсон бөгөөд үүнээс эмэгтэй 612 иргэн байна. Эхний 10 сарын байдлаар 1199 иргэн шинээр бүртгүүлж тайлант сарын эцэст 352 ажил хайгч иргэн идэвхтэй байгаагаас 202 нь эмэгтэй ажил хайгч байна. Ажил хайгч иргэдийн 274 буюу 77.8 хувь нь боловсролтой, мөн 139 буюу 39.4 хувийг 15-34 насныхан эзэлж байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 3-р улирлын байдлаар 77.1 хувь байна. | 70 |
| 2.5.3.1 | Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлнэ | Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 20 | 23% | 35% | 5 | Нийт аж ахуйн нэгж байгууллагын 81,2 хувь буюу 706 ажил олгогчийг нийгмийн даатгалд хамрууллаа. Нийгмийн даатгалд 23185 хүн хамрагдсаны 4065 иргэн буюу 17.5% нь сайн дурын даатгуулагч байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 40,1 хувийг нийгмийн даатгалд хамруулсан байна. | 90 |
| 2.5.4.1 | Ажлын байрны захиалгад нийцүүлсэн бодлогоор ажилгүйдлийн түвшинг бууруулна | Ажлын байрны захиалгад нийцүүлсэн бодлогоор ажилгүйдлийн түвшинг бууруулна | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 80 | 4.3% | 3% | 20 | Ажлын байр бий болгох нөхцөл боломж болон иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан богино хугацаанд ур чадвар олгох сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. 2023 онд мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран Оёдол эсгүүр, Тогооч, Сантехникийн чиглэлээр 45 иргэнийг танхимын сургалтад хамруулан 3 чиглэлээр 2-р түвшний чадамж олгосон. Сургалтад хамрагдсан иргэдийн 66.6 хувь буюу 30 иргэнийг ажилд зуучлан, ажил олгогчоос 219 ажлын байрны захиалга ирж, 48.8 хувьд нь буюу 107 иргэнийг ажлын байранд зуучилсан байна. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.5.1 | Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ | Мэргэжлийн сургалтын байгууллагын сургалтын технологи, арга зүй, орчин нөхцөлийг сайжруулна | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 200 | 1 | 3 | 50 | Багш нарын заах арга зүйг сайжруулах зорилгоор “Арга зүйн ажил”-ын цагийг 2023-2024 оны хичээлийн жилээр төлөвлөж багш нараас заах арга зүйн чиглэлээр авах сургалтын хэрэгцээний судалгаанд үндэслэн, хичээлийн жилийн хугацаанд 7 хоног бүрийн 2 дахь өдөр 2 цагийн хугацаатайгаар зохион байгуулж байна. Мөн“Ахмад багш нарын холбоо”-той хамтран 2022-2023 оны хичээлийн жилд залуу багш нарын заах арга зүйг дээшлүүлэх, зөвлөх туслах үйлчилгээг үзүүлсэн. Дотуур байрны суралцагчдын амьдрах, суралцах нөхцөлийг сайжруулах чиглэлээр хуучин сургуулийн байранд засварын ажил гүйцэтгэж, суралцагчид байрлах 9 өрөө, гал тогоонд урсгал засвар, 1 ариун цэврийн өрөөг шинээр засаж тохижуулсан. Тогооч мэргэжлийн дадлагын газрыг шинэ тоног төхөөрөмжөөр хангаж, багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 10 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжөөр хөрөнгөөр хангасан. | 100 |
| 2.5.5.2 | | Үйлчилгээний салбарт ажиллагсдыг мэргэжлийн сургуульд бэлтгэнэ | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 15 | 250 | 330 | 5 | Аймгийн Политехник коллеж, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд оёдолчин, үсчин гоо сайханч, тогооч зэрэг мэргэжилтнүүдийг бэлтгэн сургаж байна. Энэ онд 2 ээлжийн төгсөлтөөр 259 төгсөгч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд мэргэжил олгох болон давтан сургалтаар оёдолчин 20 иргэн, хоолны технологичоор 19 иргэн нийт 298 үйлчилгээний салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэгдсэн байна. | 70 |
| 2.5.6.1 | Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг цахимжуулж | Аймгийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. | 2023-2023 | ХХҮГ, АЗДТГ | ОНТ | 10 | 0 | 1 | 10 | Мөнх-Ирээдүй-Ундарга хөдөлмөрийн биржтэй хамтран төгсөх ангийн 788 хүүхдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. | 30 |
| 2.5.7.1 | Аймгийн хэмжээнд хувийн хэвшилд ажиллагсдын тоог нэмэгдүүлнэ | Хөдөлмөрийн үнэлэмжийг цагаар болон хоногоор тооцох аргачлалыг мөрдлөг болгох нөлөөллийн ажлыг зохион байгуулна | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 0 | 4 | 8 | | Цагийн хөдөлмөрийн хөлсийг 4500 төгрөгөөр тооцон олгож, хөдөлмөрийн үнэлэмжийг цагаар болон хоногоор тооцох аргачлалыг мөрдлөг болгон аж ахуй нэгжүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгохгүй байх нөхцөлийг бүрдүүлэн ажиллах нөлөөллийн ажлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян болон хөдөлмөрийн улсын байцаагчийн албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулан ажиллалаа. Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэн 834 иргэнийг түр ажлын байраар хангалаа. | 100 |
| 2.5.8.1 | Гэр бүлд чиглэсэн арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулна. | Гэр бүлд зөвлөгөө өгөх сэтгэл зүйн төв байгуулна. | 2023-2023 | ХХҮГ, АЗДТГ | ОНТ | 30 | 0 | 1 | 30 | Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвд Гэр бүлд зөвлөгөө өгөх сэтгэл зүйн өрөөг тохижуулан, 2023 онд зорилтод бүлгийн 12 гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт Гэр бүлд зөвлөгөө өгөх сэтгэл зүйн төвийг байгуулах ажлын хүрээнд нэг өрөөг тохижуулан, 24 иргэнд гэр бүлийн зөвлөгөө мэдээлэл өгсөн. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын батлагдсан орон тоонд Гэр бүлд зөвлөгөө өгөх сэтгэл зүйчийн орон тоо батлагдаагүй тул Гэр бүлд зөвлөгөө өгөх сэтгэл зүйн үйлчилгээ тогтвортой явагдахгүй байна. 2024 оноос аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын батлагдах орон тоонд Гэр бүлд зөвлөгөө өгөх сэтгэл зүйчийн орон тоог нэмж баталж өгөх саналыг дээд шатны байгууллагад уламжилсан. | 90 |
| 2.5.8.2 | | “Залуу гэр бүл” арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 0 | 523 | 630 | 0 | Шинээр гэр бүл болж буй залуучуудад “Гэрлэхийн өмнөх боловсрол олгох сургалт, үйлчилгээг хүргэх” гэрлэлтийн батлах гардуулах ёслолын өргөөг орон нутгийн төсвийн санхүүжүүлт (25 сая төгрөг)-ээр засварлан тохижуулж байна. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан "Тогтвортой амьдрал амгалан гэр бүл” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургалт, нөлөөллийн ажлыг 8 удаа зохион байгуулж 260 гэр бүлийг хамруулсан. Мөн бүх сум, төрийн болон төрийн бус байгууллагууд "Тогтвортой амьдрал амгалан гэр бүл" арга хэмжээний хүрээнд гэр бүлийн мэдлэг хандлага чадвар төлөвшүүлэх, Гэр бүлийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, гэр бүлийн үнэ цэнийг олон нийтэд хүргэх, түгээх ажлыг зохион байгуулан 5300 орчим гэр бүлийг хамруулсан байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.9.1 | Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлнэ | Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлнэ | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 20 | 5% | 10% | 5 | Хүүхдийг нийгмийн амьдралд оролцох, эвлэлдэн нэгдэх, хүүхдийн эрхийг хангах аливаа асуудлаар шийдвэр гаргахад оролцох, "Тэгш оролцоо-2023" баруун бүсийн хүүхдийн чуулганыг Завхан аймгийн хүүхдийн "Даян-Очир" зусланд Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан аймгийн 253 хүүхэд, чиглүүлэгч багшийг оролцуулан зохион байгуулсан. Тус зуслангийн хөгжлийн хөтөлбөрт оролцож буй 4 аймгийн оролцогч хүүхдүүд Өвөл, Зун, Намар, Хавар гэсэн дөрвөн бүлэгт хуваагдан "Монгол бахархал" өртөөчилсөн үйл ажиллагааны хөтөлбөр, "Хамтдаа бүтээцгээе" амьдрах ухааны өртөөчилсөн үйл ажиллагааны хөтөлбөр, "Монголын хүүхдийн зөвлөл"-ийн өдөрлөг, "Урлаг-Спорт"-ын Чөлөөт сонголтын хөтөлбөрийн хүрээнд 5 өдрийн турш зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдаж, хүүхэд, багачууд маань аймгуудын бахархал болсон зүйлийг таниж мэдэх, багаар ажиллах, өөрийгөө илэрхийлэх, авъяасаа хөгжүүлэх бусдыг хүндэтгэх, хайрлахад суралцахаас гадна шинэ найз нөхөдтэй болж, цагийг бүтээлч, хөгжилтэй өнгөрүүлсэн. Оролцогч нийт хүүхдүүд "Сургууль, сум орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй хүүхдийн асуудал"-ыг хэлэлцэж орон нутгийн удирдлагуудад "Бидний дуу хоолой" илгээлтийг хүргүүллээ. Уг илгээлтийг Завхан аймгийн 24 сумын Засаг дарга нарт хүргүүлэн орон нутгийн бодлого боловсруулахад хүүхдийн дуу хоолойг сонсох, хүүхдийн саналыг харгалзан үзэж шийдвэрлэн ажиллахыг үүрэг чиглэл болгон хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан бүх сум, сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгуулагад хүрч ажиллан хүүхдийн дуу хоолойг сонсож, хамтран ажиллаж байна. | 100 |
| 2.5.10.1 | Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах үйлчилгээний чанарыг сайжруулна. | Аймгийн нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулна | 2022-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 18 | | 12 | 6 | Жендэрт суурилсан хүчирхийлэл ба Гэр бүлд суурилсан хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв нь 2023 онд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч 51 хүн ( насанд хүрсэн 26, хүүхэд 25)-ийг 1-10 хоногийн хугацаатайгаар 184 хоног хамгаалах байранд байрлуулан, аюулгүй байдлыг хангаж, хохирогчдод шаардлагатай багц үйлчилгээнүүдийг төлөвлөн үзүүлсэн. Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хохирогчдод сэтгэлзүйн зөвлөгөө өгөх орчинг бүрдүүлэх, амьдрах ухааны сургалт олгох зорилгоор 4 улирлын хүлэмж байгуулан өргөст хэмх, улаан лооль тариалж, хүлэмжний дотор хэсэгт сэтгэл зүйн булан байгуулсан. Нэг цэгийн үйлчилгээний төвд аймгийн Засаг даргын захирамжаар 2023 онд 20,0 сая төгрөгний дэмжлэгийг аймгийн ОНТ-өөс олгосон. Нэг цэгийн үйлчилгээний төвийн эрх зүйчийг "И тусламжийн арга зүй", "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, насанд хүрэгчидтэй ажиллах кейс үйлчилгээ" зэрэг 10 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт хамруулж чадавхжуулсан байна. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй "Гүүд нэйборс" олон улсын төрийн бус байгууллагаас зохион байгуулсан "Сэтгэл зүйн зөвлөгөөний цогц сургалт"-нд Нэг цэгийн үйлчилгээний төвийг хамруулан 2,1 сая төгрөгийн сэтгэл зүйн үйлчилгээний цогц хөтөлбөрийн багц хэрэглэгдэхүүнээр хангасан. | 100 |
| 2.5.10.2 | | Архины хамааралтай гэр бүлд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна. | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 105 | 43 | 61 | 30 | Аймгийн Засаг даргын захирамжаар "Тогтвортой амьдрал амгалан гэр бүл" арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сум бүрийн Засаг даргын Тамгын газраас гэр бүлийн үнэ цэнэ болон Гэр бүлийн тухай хууль тогтоомжийг сурталчлах сургалт нөлөөллийн 28 ажлыг зохион байгуулан 7800 орчим гэр бүлийг хамруулсан байна. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зорилтот гэр бүлийн 20 өрхийн 60 хүнийг хамруулсан "Аз жаргалтай гэр бүл" өдөрлөгийг зохион байгуулсан. | 100 |
| 2.5.11.1 | Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанарыг | Хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулна | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 20 | 270 | 270 | 5 | Аймгийн хэмжээнд 30 хамтарсан багт 303 гишүүнтэй ажиллаж байна. Хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд НАМС программ, кейс бүрдүүлэлт, эрсдэлт өрхүүдтэй ажиллах арга зүй өгсөн хэлэлцүүлэг, сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор хамтарсан багийн 48 нарийн бичгийг хамруулсан. Улиастай сумын 6 багийн хамтарсан багийн 13 гишүүнийг хамруулсан зөвлөн туслах ажлыг зохион байгуулан аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Улиастай сумын ЗДТГ, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан "Хариуцлагатай хамтарсан баг-2023" аяны хүрээнд 29 хамтарсан багийн зүгээс 123 удаагийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг иргэд олон нийт болон зорилтод бүлгийн айл өрхийн дунд зохион байгуулж, 6673 хүнийг хамруулсан. Аянд амжилттай оролцож бусдын сайн сайхны төлөө сэтгэл зүтгэл гарган ажиллаж, мэргэжлийн үйлчилгээг үр дүнтэй үзүүлсэн эхний 5 хамтарсан багийг шалгаруулан шагнаж урамшуулсан. ХНХЯ-аас зохион байгуулсан хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад 24 сумын 30 хамтарсан багийн 118 гишүүн хамрагдсан. Энэхүү сургалтыг зохион байгуулахад ХНХЯ-аас 32.0 сая төгрөгийг зарцуулсан. | 100 |
| 2.5.11.2 | | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг сайжруулна | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 8 | 95% | 98% | 2 | Гэмт хэрэг, зөрчлийн улмаас сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа, хохирсон, гэрч болсон хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажилласан 30, хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэрч, хохирогч болсон хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн өмгөөлөгч томилсон 8 тохиолдол байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой хүүхдийн эрх зөрчигдсөн 21 гомдол мэдээллийг журмын дагуу шийдвэрлэж хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн. Хүүхдийн эрхийг зөрчсөн 1 иргэнд зөрчлийн хэрэг үүсгэн торгуулийн арга хэмжээ авсан байна. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2 хүүхдэд холбогдох журмын дагуу үйлчилгээ үзүүлж байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.11.3 | сайжруулна | Иргэд, олон нийтэд хүүхэд хамгааллын нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 0 | | 2 | 0 | Иргэд олон нийтэд хүүхэд хамгааллын нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын тушаалаар баталсан хүүхдийн хөгжил хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр ахлуулсан, хүүхдийн хамгаалал, хариу үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, хяналт үнэлгээ мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Яруу, Цэцэн-Уул, Сантмаргаз, Сонгино, Баянтэс, Асгат, Баянхайрхан, Түдэвтэй, Отгон, Шилүүстэй, Цагаанчулуут зэрэг 13 суманд ажиллаж, иргэд олон нийт, эцэг эхчүүд, хүүхдүүдэд Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг хөдөлгөөнт, явуулын хэлбэрээр, газар дээр нь хүргэн, олон нийт, багш, ажилчид, хүүхдүүдийг мэдлэгжүүлэх, зөвлөн туслах, эрсдэлийг илрүүлэх, зөрчлийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа. Ажлын хэсгийн зүгээс 13 сумын Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан баг, Хүүхдийн элчийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, иргэд, олон нийт, ерөнхий боловсролын сургуулийн багш ажилтнууд, суралцагчид, дотуур байранд амьдарч буй хүүхдүүдэд зориулсан гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах явдал, хүмүүжлийн зерэг арга, үе тэнгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, цахим орчны зөв зохистой хэрэглээг таниулах сургалт сурталчилгааг 13 сургуулийн 301 багш, ахлах, дунд ангийн 3716 сурагч, байрны 507 хүүхэд, 459 эцэг эхчүүдийг хамруулж зохион байгуулан мэдээлэл түгээж ажиллалаа. | 100 |
| 2.5.12.1 | Хөдөлмөр эрхлэлтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах түвшинг нэмэгдүүлнэ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв байгуулна. | 2023-2023 | ХХҮГ, АЗДТГ | ОНТ | 40 | 0 | 1 | 40 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ХБИ-ийн хөгжлийн төвийг 2024 онд байгуулахаар төлөвлөж байна | 0 |
| 2.5.13.1 | Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудыг дэмжинэ | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудын мэдээллийн санг бий болгоно | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 2 | 175 | 250 | | Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний Зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах, ахмад настанд санхүүгийн дэмжлэг олгох, хүүхэд хамгаалагч үйлчилгээг зохион байгуулах гэсэн 3 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 30 ахмад мэргэжилтнээс зөвлөх үйлчилгээг авч 32,4 сая төгрөгний урамшуулал олгохоос одоогийн байдлаар 5 мэргэжилтнээс 3 байгууллагад 1200 цагийн зөвлөх үйлчилгээг үзүүлэн 5,4 сая төгрөгийг зарцуулж, түүний үр дүнд 5 түр ажлын байр бий болсон. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд 38 төслийг хүлээн авч, 21 ахмадын төсөл шалгарч, 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээ байгуулан ХЭДС-аас 105,0 сая төгрөгний дэмжлэг олгогдон 21 шинэ ажлын байр бий болсон. Хүүхэд хамгаалагч төслийг аймгийн Цагдаагийн газартай хамтран хэрэгжүүлж, Тосонцэнгэл суманд 2 ахмад настанг ажиллуулж байна. Гэрээт хугацааны ажлын үр дүнд 1,680,000 төгрөгний урамшууллыг олгохоор төлөвлөж 2-4 түр ажлын байр бий болгон ажиллаж байна. | 100 |
| 2.5.13.2 | | Сумын ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжинэ | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 36 | 0 | 10 | 10 | Завхан аймагт ахмадын анхан шатны хороо 24, зөвлөл 74, ахмадын хэсэг 114 ажиллаж тэдгээрт 300 орчим ахмад идэвхтэн сонгуультны үүрэг гүйцэтгэж байна. 18 сумын ахмадын хороо ахмадын өргөө, танхим, өрөөтэй. Аймгийн ахмадын хороо нь Ахмадын ордонтой болсноор Улиастай сумын ахмадууд болон аймгийн нийт ахмадууд олон нийтийн үйл ажиллагаа тасралтгүй зохион байгуулан ажилладаг. Билгийн улирлын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр 10 дугаар сарын 1-нд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулан дэмжин ажилладаг сумдыг бүсчилэн бүсийн сумдын ахмадуудын дунд урлаг спортын тэмцээн наадам, олон нийтийг хамарсан нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад дэмжин ажилладаг. | 100 |
| 2.5.14.1 | Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ | Зарим суманд залуучуудын хөгжлийн төв байгуулна | 2021-2022 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 30 | 1 | 1 | 15 | 2022 онд Их-Уул суманд залуучуудын хөгжлийн төвийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 160 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын 65 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлсэн. Залуучуудад үйлчилгээ хүргэх ажилтнуудыг чадавхижуулах арга зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулж жендэрийн сургагч багшаар бэлтгэсэн. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар дахь Залуучуудын хөгжлийн төв болон Их-Уул сум дахь залуучуудын хөгжлийн төвөөс харьяалах нутаг дэвсгэрийн залуучуудад сургалт нөлөөллийн ажил, олон нийтийг хамарсан ажлуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| 2.5.14.2 | | Аймгийн залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг дэмжинэ | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 60 | 622 | 120 | 15 | Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Залуучуудын хөгжлийн төвөөс 2023 онд 22373 хүнд 7 төрлийн үйлчилгээг хүргэн ажилласны 7097 хүнд танхимаар, 15276 хүнд цахимаар хүрч үйлчилсэн байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.15.1 | Гэр бүлийн гишүүдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна | Гэр бүлийн гишүүдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 20 | 0% | 3% | 5 | Жендэрийн салбар хорооны 2023 оны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэр бүлийн гишүүдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын хүрээнд аймгийн хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагуудаас сургалт сурталчилгаа, оролцоо, нөлөөллийн 68 төрлийн ажил хийгдэж, 5800 орчим гэр бүлийг хамруулсан байна. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан аянд идэвхтэй оролцож хамтран ажиллалаа. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Эрүүл мэндийг дэмжих төв”-д Андрологийн 1 кабинетыг байгуулан Орон нутгийн хөгжлийн сангаас 19,500,000 төгрөгөөр 12 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжөөр хангаж урологийн эмч эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн үйл ажиллагаа нь тогтворжиж байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/449 дүгээр тушаалаар батлагдсан “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам”-ыг хэрэгжүүлэн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 493 , насны байдлаар 0-19 насны 100, 20-39 насны 67, 40-49 насны 47, 50-64 насны 126, 65-с дээш насны 153 эрэгтэйд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс: дурангийн хагалгаа 18, нээлттэй хагалгаа 20 хийсэн байна. | 100 |
| 2.5.16.1 | Халамж зайлшгүй хүрэх шаардлагатай зорилтот бүлгүүдэд халамжийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 0 | 2239 | 2120 | | Нийгмийн халамжийн сангаас 2023 оны 10 сарын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт 1042 иргэн, тусламж хөнгөлөлтөд 980 иргэн, нийт 2022 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн Олон нийтийн оролцооны төсөл хөтөлбөрийн үйлчилгээний өөрөө өөртөө ажлын байр бий болгох төсөлд 40 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж 78.3 сая төгрөгийг олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настангуудад туслах зорилгоор "Хөтөч анд" бие даан амьдрах төв болон Улаанбаатар хот дахь "Түгээмэл хөгжил" бие даан амьдрах төвтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх хувийн туслах бэлтгэх сургалтыг Улиастай суманд зохион байгуулж 25 иргэн хувийн туслах үйлчилгээ үзүүлэх эрх авсан. Эрх авсан иргэдээс Улиастай сумд 2, Тосонцэнгэл сумд 2 иргэн хувийн туслах үйлчилгээг туршилтаар хэрэгжүүлээд байна. | 100 |
| 2.5.16.2 | | “Хүнсний талон” олгох үйл ажиллагаар зорилтот өрхэд хүргэнэ | 2021-2024 | ХХҮГ,АЗДТГ | ОНТ | 0 | 1206 | 1158 | | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн тоог 36 хувиар бууруулснаар 11 сум хүнсний эрхийн бичгээс татгалзаж, хөдөлмөр эрхлэгч сум болсноор хүнсний эрхийн бичигт 13 сумын 435 өрхийн 1137 хүн хамрагдаж байна. | 100 |
| **2.5 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **89.58** |
| **2.6** | **Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэн, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ** | | | | | | | | | | |
| 2.6.1.1 | “Үндэсний бахархал, Монгол өв соёл” арга хэмжээг хэрэгжүүлнэ | Суралцагчдад зориулсан Монгол эх оронч үзэл төлөвшүүлэх нөлөөллийн ажлыг нэмэгдүүлнэ | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 200 | 1500 | 5000 | 50 | "Үндэсний бахархал, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд бүх талын оролцоог хангах, томоохон хэмжээний уран бүтээл туурвих" зорилтын хүрээнд: 5 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 11,0 сая төгрөгийг зарцуулж, 5379 хүүхэд, залуучуудад үйлчилгээ үзүүлсэн. Завхан аймгийн Тосонцэнгэл сумын уугуул Бригадын генерал Цэвэлмаагийн Жавхланбаатарын нэрэмжит "Монгол цэрэг 102" цэргийн дууны наадмыг Тосонцэнгэл суманд зохион байгуулж, 21 оролцогч оролцсон. Эко клубийн 38 суралцагчдыг хамруулсан орон нутагтай танилцах аяллыг зохион байгуулж, аяллын хүрээнд АХА тэмцээнийг зохион байгууллаа. "Дөл" тэмцээнд ерөнхий боловсролын сургуулийн 10-11 ангийн 120 хүүхэд оролцсон. "Паацаахайд тохиолдсон хөгтэй явдал" хүүхдийн жүжгийг Түдэвтэй сумын Соёлын төвд үнэ төлбөргүй тоглож, 400 гаруй хүүхэд багачуудад хүргэсэн. Аймгийн 100 жилийн ойн хүрээнд туурвисан Б.Цогнэмэхийн зохиол “Асарын өндөр түүхэн” аялгуут жүжгийг Улаанбаатар хотод 2, Улиастай хотод 3 удаа тоглож, 4800 үзэгчдэд хүргэсэн байна. | 100 |
| 2.6.1.2 | | Монгол зан заншил, өв соёлыг сурталчлан таниулах сургалтын танхим байгуулахад дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 240 | 1500 | 12000 | 60 | Сумдын соёлын төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд Монгол ёс заншлын танхим байгуулан тохижуулж, цэцэрлэгийн 3500 гаруй хүүхэд танин мэдэхүйн чиглэлээр, сургуулийн 6200 суралцагч, 1000 гаруй иргэд сургалт, хэлэлцүүлэгт оролцсон байна. Их-Уул, Баянтэс, Идэр сумууд бие даасан ёс заншлын өргөөтэй болсон бөгөөд аймгийн Музей, Асгат, Сонгино, Цэцэн-Уул, Тэс, Тэлмэн, Түдэвтэй сумын соёлын төвүүд ёс заншлын танхим, ёс заншлын буланг шинээр тохижуулан Үндэсний тоглоом наадгайн боловсролын хөтөлбөрийг хүүхэд залуучуудад хэрэгжүүлж байна. Мөн Түдэвтэй сумд Морин спортын уяачдын холбооны Хийморийн өргөө шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. | 100 |
| 2.6.1.3 | | Соёлын биет бус өвийг өвлөн тээгчдийг бүртгэн баримтжуулж, түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 120 | 550 | 560 | 30 | Төрийн тахилгат Отгонтэнгэр уулын магтаал “ОРОЙН ЧИМЭГ” уртын дууны анхдугаар наадмыг Улаанбаатар хот, Орхон аймаг, Отгон, Шилүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Улиастай сумд амжилттай зохион байгуулж оролцсон 100 өвлөн уламжлагч аймгийн 100 жилийн нээлтэд оролцсон. Их-Уул сумын өвлөн уламжлагчдын эрхэмлэл монгол гутлын биет бус өвийн нэвтрүүлэг, Монгол улсын уран хатгамалч Б.Мөнхтуяагийн "Соёлын өв тээгч" нэвтрүүлгүүдийг МҮОНТВ-ээр үзэгчдийн хүртээл болгосон. “Хөвсгөл хотгойд Хөвчийн хүү” төрийн бус байгууллагатай хамтран Эсгий туургатан баримтат нэвтрүүлгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүндэтгэлийн өргөөнд зохион байгуулж “Оройн чимэг” уртын дууны хамтлаг, Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчдийг оролцуулж хамтран ажилласан. “Нүүдэлчин 2023” дэлхийн соёлын фестивальд оролцоход орон нутгийн хөгжлийн сангаас 20,0 сая, Соёлын яамнаас 16.8 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, Эх хэл, аман уламжлал илэрхийлэл, Ардын язгуур урлаг, Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл , Мал маллах арга ухаан, Уламжлалт арга ухаан, Уламжлалт гар урлалын төрлөөр 38 өвлөн уламжлагч оролцсон. | 100 |
| 2.6.1.4 | | Өрх бүр уйгийн бичгээ хөтөлж хэвшинэ | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 70 | 5500 | 15000 | 20 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Уйгийн бичиг хөтлөх арга зүй” сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг Анагаах Ухааны доктор, хүний их эмч, Хүн судлаач Э.Энхмаа удирдан сургалтад 23 сумын 100 гаруй хүн хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдсэн ба сургалтыг зохион байгуулахад ОНХС-аас 3,0 сая төгрөг зарцуулсан. Ж.Батсуурь, Э.Энхмаа нарын “Монгол улсын иргэн уйгийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар” ном, ахмад багш Ч.Янжинхүүгийн “Уйгийн бичиг хөтлөх арга зүй” гарын авлага нийт 94 ном гарын авлагаар сумдын номын сангийн фондыг баяжуулахад ОНХС-аас 2,0 сая төгрөгийг зарцуулсан.16 сумын уйгийн бичиг хөтөлдөг 8600 айл өрхийн судалгаа цаасаар авч нэгтгээд байна. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.2.1 | Соёлын биет болон биет бус өвийн судалгаа, мэдээллийн нэгдсэн сан бий болгож, өвлөн уламжлагчдыг өсвөр үе, залуучуудад сурталчлан таниулж, өвлөн уламжлуулна | Соёлын биет болон биет бус өвийн судалгаа, мэдээллийн нэгдсэн сан бий болгоно | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 70 | 0 | 50 | 15 | "Register4" программд улсын хамгаалалтанд байх 6, Аймаг нийслэлийн хамгаалалтанд байх 21 нийт 27 дурсгал, орон нутгийн хамгаалалтанд байх 693 цэгийн 7835 дурсгалын мэдээллийг тус программд оруулсан ба "Соёлын биет бус өв"-ийн бүртгэлийн www.rich.mongoluv.mn программд аймгийн 532 өвлөн уламжлагчийн судалгаа, мэдээллийг шинэчлэн баяжилт хийсэн. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг шинээр илрүүлэн, улсын бүртгэл мэдээллийн rich программд 665 дурсгалыг бүртгэж, Тэлмэн, Нөмрөг сумын нутаг дэвсгэрт байрлах Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлгүй түүх соёлын үл хөдлөх 2 дурсгалыг шинээр бүртгэн баримтжуулж программд бүртгэсэн. | 100 |
| 2.6.2.2 | | Биет бус өвийг хамгаалах, өвлүүлэхэд зориулж видео контент бэлтгэнэ | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 83 | 1 | 15 | 20 | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаар дамжуулан сурталчлан таниулах зорилгын хүрээнд 2 нэвтрүүлэг, 1 видео бичлэгийг Улиастай сумд, Их-Уул сумын нутгаас эрхээмэл монгол гутал, энгийн монгол гутал хийдэг 5 өвлөн уламжлагчаас нэвтрүүлэг бэлтгэн AIR 1 сувгаар иргэдэд хүргэсэн. Соёлын биет бус өвийг хадгалах хамгаалах өвлөн уламжлуулах чиглэлээр Эсгий туургатан төслийн багт холбогдох өвлөн уламжлагчдыг холбож нэвтрүүлэг бэлтгэхэд дэмжин ажиллаж, 2 видео бичлэг хийгдсэн. “Шагай наадгай” сэдэвт контентийг орон нутгийн телевиз болон олон нийтийн сүлжээгээр нэвтрүүлсэн. Тосонцэнгэл суманд зохион байгуулагдсан “Сайн ноён хан аймаг баатар засгийн хошуу” түүх, соёл, байгаль сэдэвт эрдэм шинжилгээний хуралд Далай чойнхор вангийн урчууд болон Б.Гүрбадам, Маньбазар нарын урласан бүтээлүүд болох 15 дэсийн 41 ширхэг үзмэр эд өлгийн зүйлээр дэглэсэн түр үзэсгэлэнгийн талаарх мэдээллийг ТВ-5 телевизэд өгч, уран хатгамалч Б.Мөнхтуяагийн Соёлын өв тээгч нэвтрүүлэг МҮОНТВ-р сар шинийн баяраар үзэгчдэд хүрсэн. Телевизийн нэвтрүүлэг 4, контент 3 хийгдсэн | 100 |
| 2.6.3.1 | Номын сангийн цахим сан хөмрөгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ | Номын сангийн цахим сан, фондыг баяжуулна | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 144 | 0 | 2% | 48 | Номын сангийн цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд орон нутгийн ууган хэвлэл болох Туяа сонины 1946-1990 он хүртэлх дугаарууд нийт 9933 нүүрийг Омека программд оруулж сонин хэвлэлийн 87% ийг цахимжууллаа. "Гайхмаар хурд" ХХК-наас интернетийн хурдыг 4GB-аар өсгөн авч ашиглаж байна. Гадаад уншлагын хурдыг нэмэгдүүлэх зорилгоор Лингорс байгууллага, Xreading цахим номын сантай хамтран нийт 45 уншигч хүүхдүүдийг гадаад уншлагын марафонд оролцуулаад байна. Ж.Батсуурь, Э.Энхмаа нарын “Монгол улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар” номыг 25 ширхэгийг худалдан авч, 23 сумын Соёлын төвийн номын санд баяжилт хийлээ. Мөн ахмад багш Ч.Янжинхүүгийн “Угийн бичиг хөтлөх арга зүй” гарын авлагыг хэвлүүлэн аймгийн хэмжээний айл өрхүүдэд хүргэхэд Соёл Урлагийн газраас 200,0 төгрөгийн дэмжлэг үзүүлж, сумдын номын сангууд уг номоос 69 ширхэг номоор баяжилт хийсэн. | 100 |
| 2.6.4.1 | Үндэсний бахархал, Монгол өв соёлоо өвлүүлэхэд чиглэсэн аялал жуулчлалын | Цахим орчин дахь аялал жуулчлалын мэдээллийг нэгдсэн сувгаар түгээнэ. | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 0 | 0 | 100 | | Цахим орчин дахь аялал жуулчлалын мэдээллийг нэгдсэн сувгаар түгээх ажлын хүрээнд аймгийн музейгээс түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тайлбар мэдээллийг БОАЖГ-т хүргүүлсэн. Их-Уул сумын Солонготын даваа, Сонгино сумын төвийн баруун талд төв зам дагуу, Цагаанхайрхан сумын Ганцын давааны угтах хаалга дээр соёлын аялал жуулчлалын мэдээлэл бүхий QR кодтой самбарын хийх ажлын даалгаврыг хийж гүйцэтгэсэн. | 70 |
| 2.6.4.2 | | Түүхэн дурсгалт газруудыг аялал жуулчлалын маршрутад оруулна. | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 0 | 0 | 10 | | Шинжлэх ухаан археологийн хүрээлэнтэй хамтран Эрдэнэхайрхан сумын Ар Баян айраг, Их хайрхан, Завханмандал сумын Таван лам, Аргалант, Ургамал сумын Голын Баян улаан, Бор хярын элс, Дөрвөлжин сумын Бүрчигтэй, Өвөр сайхан, Хар овоо, Яруу сумын Дулаан уул зэрэг газруудад хадны оршуулгын дурсгалыг илрүүлэх, судлах, авран хамгаалах ажлыг зохион байгуулсан бөгөөд судалгаанд 8 дурсгалт газар 8 дурсгал хамрагдсан. Хадны оршуулгын дурсгалын сэргээн засварлалтын ажлыг Соёлын өвийн Үндэсний төвөөр хийлгэсэн бөгөөд 2023.06 сард багтаан хүлээн авч дэглэлт хийхээр төлөвлөж ажлуудыг аймгийн маршрутад оруулах санал хүргүүлсэн. Ямаан усны археологийн дурсгалт газрын хүрээнд судлагдсан газруудыг аялал жуулчлалын маршрутад оруулахаар БОАЖГ-тай хамтран ажиллаж байна. | 70 |
| 2.6.5.1 | | Аймгийн бүх шатны сургалтын байгууллагын суралцагчдын эх хэл, бичиг соёлыг эзэмшсэн түвшинг ахиулна. | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 80 | 30% | 70% | 20 | Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны "Эх хэлний өдөр зарлах тухай" 25 дугаар зарлиг ѐсоор 2023-2024 оны хичээлийн жилийн нэгдүгээр цагийг “Үндэсний бичиг”-ийн хичээлээр эхлүүллээ. Энэхүү хичээлийг суралцагчдад үндэсний хэл, соёлоо сурталчлан таниулах, түүгээр бахархах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор монгол хэл, уран зохиол, монголын түүхийн хичээлийн сэдэв агуулгад нийцүүлэн зохион байгуулж, ерөнхий боловсролын 29 сургуулийн 2332 суралцагч хамрагдлаа. Уг хичээлийг “Завхан-Эх, хэл бичгээ эрхэмлэе” цахим хуудаст байршуулж, түгээн дэлгэрүүллээ.<br>“Эх хэл бичгээ эрхэмлэе” уралдаант аяныг Ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагчид, иргэд, Монгол бичиг сонирхогчдын дунд зохион байгуулж, мэргэжлийн 76 багш, мэргэжлийн бус 98 багш, 1320 суралцагч хамрагдаж 7037 постер, 85 эсээ бичлэг, 162 удаагийн самбарын бичиглэл, 10 багшийн 20 цахим хичээл, бусад бүтээлүүд нийтлэгдсэнээс эхний 3 байрт орсон багш, суралцагчдыг шагнаж урамшуулсан. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.5.2 | Монгол хэл, бичгийн нийтийн болон албан хэргийн хэрэглээг өргөжүүлнэ | Аймгийн хэмжээнд Үндэсний бичгийн шат дараалсан сургалтыг зохион байгуулна. | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 160 | 40% | 80% | 40 | Сумдын Засаг дарга нарт Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн Ажлын албаны даргын 2022 оны А/38 тоот тушаалаар батлагдсан “Төрийн албан хаагчдад зориулсан монгол бичгийн сургалтын хөтөлбөр”-ийн дагуу Сумын хэлний бодлогын салбар зөвлөл, мэргэжлийн багш нартай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн төрийн байгууллагын албан хаагчдад монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтыг тасралтгүй явуулж, хэрэгжилтийг тайлагнах үүрэг чиглэлийг албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж байна. Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн сургагч багш нартай хамтран аймгийн хэмжээнд байгууллагын архив бичиг хэргийн ажилтнуудад “Цахим бичвэр боловсруулах арга зүй” сургалтыг танхимаар байгууллагын дарга, удирдах ажилтнуудад Монгол хэлний тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл сургалтыг цахимаар зохион байгуулж, 200 гаруй удирдах ажилтан болон архив, бичиг хэргийн ажилтнууд хамрагдлаа. Сургалт, уралдааныг 5 удаа 100 гаруй төрийн албан хаагч, 6536 суралцагч амжилттай оролцсон. | 100 |
| 2.6.5.3 | | Хувийн байгууллагуудын хаягжилт, барааны тэмдэгт, шошго зэрэгт Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | 2021-2023 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 30 | 0 | 100% | 10 | "Монгол бичиг-III" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Стандарт хэмжил зүйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн С/41 тоот тушаалаар баталсан Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага MNS5283:2022 стандартыг баталж, төрийн байгууллагууд уг шаардлагын дагуу гаднах болон өрөө тасалгааны хаягаа хос бичгээр хөтөлж эхэлсэн. Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлөөс аймгийн хэмжээний 24 сумын хаягжилтын судалгааг авч нэгтгэлээ. Аймгийн 24 суманд 191 төрийн байгууллага 2100 өрөө тасалгаа ашигладаг байна. Байгууллагын гаднах хаягжилтыг 115 байгууллага хос бичгээр хаягжуулсан бол 76 байгууллага хаягжуулаагүй ба нийт байгууллагуудын 60 хувь нь гаднах хаягаа монгол болон крилл үсгээр хаягжуулсан байна. Мөн 2100 өрөө, тасалгааны 1085 өрөөг хос бичгээр хаягжуулж хэрэгжилт 51 хувьтай байна. | 50 |
| 2.6.6.1 | Соёлын биет, биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна | Музейн хосгүй ховор үнэт дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийг бүртгэлжүүлэн, даатгалд хамруулна | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 110 | 0 | 20 | 30 | Аймгийн Төгс буянт жавхлант хийдийн дэд хамба Ч.Дашдоржид хадгалагдаж буй “Үлгэрийн далай” хэмээх Монгол бичгийн номыг бүртгэн баримтжуулсан. Аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа үзмэрүүдээс хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх үзмэрийн судалгаа хийж яаманд уламжилж, даатгалд хамруулахаар 97 дэсийн 98 үзмэрийн жагсаалт гаргасан. Даатгалд хамруулах төсөв шийдэгдээгүй. | 70 |
| 2.6.6.2 | | Ховор эд өлгийн зүйлс эзэмшигчдэд гэрчилгээ олгож, урамшуулна | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 120 | 0 | 1 | 30 | Баримтат өв эзэмшигчдийн судалгааг аймгийн Музей, сумдын соёлын төв хамтран хийж Соёлын яаманд хүргүүлсэн. Баримтат өвийн шинэчилсэн загвараар Завхан аймгийн Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар наадмын хүрээнд 16 сумын 131 шилдэг өвлөн уламжлагчид гэрчилгээ олгож, шилдэг бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж ард иргэдэд сурталчлан таниулсан үзмэрүүдээс Аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа үзмэрүүдээс хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх 10 дэсийн 10 үзмэрийн тодорхойлолтыг яаманд хүргүүлсэн. | 50 |
| 2.6.6.3 | | “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 400 | 90% | 95% | 100 | “Соёлын сэргэлт 2023” аяны хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг, аймгийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 23 сумын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн 67 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг дэлгэн харуулсан үзэсгэлэнг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулж ажилласан. Б.Цогнэмэхийн зохиолоор “Асарын өндөр” түүхэн аялгуут жүжгийг “Үндэсний бахархал Монгол өв соёл” арга хэмжээний хүрээнд тайзны бүтээл болгож, 5 удаагийн тоглолтоор 4800 үзэгчдэд хүргэсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/31 захирамжаар Орон нутгийн онцлогт тулгуурсан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг Сумдын Соёлын төв, Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид, өвлөн уламжлагчид, сумын удирдлагууд, ард иргэдээс 12 үндсэн арга хэмжээний хүрээнд ирүүлсэн 200 гаруй саналыг нэгтгэн боловсруулж, хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулж 3 үндсэн арга хэмжээний хүрээнд 8 үйл ажиллагаа болгон нэгтгэн төлөвлөгөөний төслийг боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөлөгчдийн хурлын Нийгэм, цахим хөгжлийн хорооны хурлаар хэлэлцүүлсэн. | 90 |
| 2.6.7.1 | Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмж, нэр төрөл, хамтын ажиллагааг өргөжүүлнэ | Мэргэжлийн урлагийн байгууллага, соёлын төвүүдийг шаардлагатай хөгжмийн зэмсэг, хувцас, хэрэглэлээр хангана | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 296 | 35% | 47% | 90 | Соёлын төвүүд 103,0 сая төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлж, дараах зардалд зарцуулсан. Тавилга эд хогшил 3150,0, шатахуун 11500,0 урсгал засвар, ном хэвлэл 13000,0, урлаг уран бүтээл 49000,0, бичиг хэрэг 10500,0, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл 16000,0 2019, 2022 оны ажлаа дүгнүүлж үр дүнд суурилсан санхүүжилт аймгийн хэмжээнд 272,5 сая авч ажилчдын нийгмийн асуудалд 15%, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд 40%, урлаг уран бүтээл хийхэд 30%, урамшуулал 15%-г зарцуулан ажиллаж байна. ОНХС-н хөрөнгөөр Сонгино сум 75.0 сая төгрөгийн лед дэлгэц, Их-Уул сум хандиваар 2 компьютер авч, үүрэн холбооны өндөр хурдны интернетэд 23 сум холбогдсон. | 50 |
| 2.6.7.2 | | “Цахим соёл” арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 315 | 0% | 40% | 80 | 23 сумын соёлын төв 20 контент, ХЖТ-ын уран бүтээлчид 17 контент, Түдэвтэй сумын соёлын төв “Жогорхой” хошин дуулалт жүжиг, Паацаахайд тохиолдсон хөгтэй явдал хүүхдийн жүжиг, Цагаанчулуут сум Алтан хөрш хүүхдийн дуулалт жүжгийг найруулан тавьж, цахим орчноор дамжуулан түгээн дэлгэрүүлсэн байна. Соёл урлагийн газрын пэйж хуудсыг тогтмол хөтлөн үйл ажиллагааны мэдээлэл оруулж 1,9 мянган дагагчидтай болсон байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.7.3 | | “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 195 | 0% | 60% | 50 | Бүх нийтийн соёл, боловсролын хүрээнд түгээн дэлгэрүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж 100 гаруй хүн, Соёлын яамнаас үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Соёлын сэргэлт аян"-ыг Завхан аймагт аяныг Чойжин Ламын сүм музей, Соёл урлагийн газар хамтран зохион байгуулж, нээлтийн үйл ажиллагаанд 2488, соёл гэгээрлийн лекцэд 480, Соёлын ажилтнуудыг чадавхжуулах үзэсгэлэн, өдөрлөг, соёл олон нийтийн ажил арга хэмжээнд 920, сургалтад198, урлагийн тоглолтод 5800 гаруй хүн хамрагдсан байна. “Бүх нийтийн Соёлын боловсрол” болон “Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлого” сэдвээр 45 номын санчдад сургалтыг зохион байгуулсан. “Бүх нийтийн Соёлын боловсрол” арга хэмжээний хүрээнд 4 сайдын хамтарсан гэрээний дагуу төлөвлөгөөг гаргаж 5 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| 2.6.8.1 | Соёл урлагийн салбарын хүний нөөцийг чадавхжуулна | Соёл урлагийн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж, мэргэшүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулна | 2021-2024 | БСУГ,АЗДТГ | ОНТ | 80 | 65% | 68.6% | 20 | Соёл урлагийн 26 байгууллагад нийт 226 уран бүтээлч, ажилтан ажиллаж байна. Л.Ванганы нэрэмжит Хөгжимт жүжгийн театрт 63 уран бүтээлч ажиллаж байгаа бөгөөд 4,7% нь мэргэжлийн бус байна. Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын санд 12, аймгийн Музейд 15 ажилтан ажиллаж байна. Сумдын Соёлын төвд 136 ажилтан ажиллаж байгаа бөгөөд 34% нь мэргэжлийн бус байна. Монголын номын сангийн холбоотой хамтран “Хил хязгааргүй номын сан” төслийн хүрээнд зохион байгуулсан чадавхжуулах сургалтад 45 номын санч, “Соёлын сэргэлт 2023” аяны хүрээнд зохион байгуулсан чадавхжуулах сургалтад соёл урлагийн 27 байгууллагын 198 ажилтан, түүх, археологийн хүрээлэн, СӨҮТ-тэй хамтран зохион байгуулсан сумдын музейн ажилтнуудыг чадавхжуулах онлайн сургалтад 23 ажилтан хамрагдаж, ХЖТ-ын 3 уран бүтээлчийг мэргэжил эзэмших сургалтын төлбөрт ОНХС-ийн 10,0 төгрөгийн дэмжлэг үзүүлж, 2 албан хаагч Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад, аймгийн ХБК-ийн бакалаврын хөтөлбөрт соёлын төвийн хөгжмийн болон бүжгийн 7 багш суралцаж байна. | 100 |
| **2.6 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **85.26** |
| **ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮН** | | | | | | | | | | | **92.59** |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| **3.1** | **Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрт хүрсэн, дундаж давхарга зонхилсон, эдийн засгийн суурийг бүрдүүлж, хөрөнгө оруулалт хуримтлалын чадавхаа бэхжүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай аймаг болно** | | | | | | | | | | |
| 3.1.1.1 | Макро эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ | Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,ХХААГ | УТ | 0 | 7% | 2% | 0 | Аймгийн хэмжээнд 2022 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 645.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 20.3 хувиар буюу 109.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. 2023 оны дотоодын нийт бүтээгдэхүүний статистик үзүүлэлт гараагүй байна. | 90 |
| 3.1.2.1 | Орон нутгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэхэд чиглэсэн эдийн засгийг бодлого явуулна | Дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах үйлдвэрлэлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувийг | 2021-2024 | АЗДТГ,ХХААГ | УТ | 0 | 12.1% | 27.60% | 0 | Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2023 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 75 тэрбум 539.5 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 28.4 хувиар буурсан байна үүнд уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурсан нь нөлөөллөө. Нийт үйлдвэрлэлээс 80.7 хувийг уул уурхайн олборлолт, 13.1 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 5.2 хувийг цахилгаан дулааны үйлдвэрлэл, 1.0 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна. | 70 |
| 3.1.2.2 | | Үйлчилгээний салбар /аялал жуулчлал/-ын салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,ХХААГ | УТ | 0 | 41.7% | 47.00% | 0 | Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хорооны 2023 оны эхний сарын хилийн хөдөлгөөний мэдээгээр тээврийн хэрэгсэл 1206, иргэд 4650, ачаа 120.2 тн зөөвөрлөгдсөн байна. Хилийн боомтоор зорчсон иргэдийн 64.2 хувийг гадаад улсын иргэд, 35.8 хувийг Монгол улсын иргэд эзэлж байна. Ачаа тээшний 64.2 хувь нь орсон, 35.8 хувь нь гарсан үзүүлэлттэй байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар манай аймагт нийт 17166 жуулчин ирснээс дотоодын жуулчин 15066 гадаадын жуулчин 2100 байна. Жилийн эцсийн дотоодын нийт бүтээгдэхүүний статистик мэдээ гараагүй байна. | 50 |
| 3.1.2.3 | | Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,ХХААГ | УТ | 0 | 46.2% | 25.40% | 0 | Аймгийн хэмжээнд 2022 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 623.9 тэр бум төгрөг болсон байна. Үүнээс хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 359.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 17.9 хувиар буюу 54.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. 2023 оны дотоодын нийт бүтээгдэхүүний статистик үзүүлэлт гараагүй байна. | 90 |
| 3.1.2.4 | | Дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшлийн нэмэгдэл бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,ХХААГ | УТ | 0 | 63.2% | 79.30% | 0 | 2022 оны байдлаар аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн салбар 93.4 тэрбум төгрөг өмнөх оноос 39 хувиар буюу 26.2 тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбар 192.7 тэрбум төгрөг өмнөх оноос 17.2 хувиар буюу 28.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. 2023 оны дотоодын нийт бүтээгдэхүүний статистик үзүүлэлт гараагүй байна. | 90 |
| 3.1.3.1 | Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлнэ | Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлнэ | 2021-2024 | ТХ,АЗДТГ | ОНТ | 0 | 7669.5 | 9,757.60 | | 2023 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн татварын нийт орлого төлөвлөгөөгөөр 14167,9 сая төгрөгнөөс 16447,9 сая төгрөгний орлого орж татварын орлого 2280,0 сая буюу 106,0 хувиар давж биелсэн байна. Аймгийн төсвийн орлого 4089,6 сая төгрөгнөөс 3018,5 сая төгрөгийн орлого орж 1071,1 сая төгрөгөөр тасарч, сумдын төсвийн орлого 10078,2 сая төгрөгнөөс 13429,4 сая төгрөг орж 3351,2 сая төгрөгөөр давж биелсэн байна. | 90 |
| 3.1.4.1 | Төсвийн үр ашигтай, ил тод, шуурхай байдлыг хангуулна | Төсвийн үр ашигтай, ил тод, шуурхай байдлыг хангуулна | 2021-2024 | АЗДТГ,СЗДТГ | ОНТ | - | 22,151.90 | 26,347.40 | | 2023 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн зарлага төлөвлөгөөгөөр 67228,9 сая төгрөгнөөс 53945,3 сая төгрөгний зарлага гарсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэмнэгдэх зардлуудыг хэмнэж, хяналт тавин ажилласнаар нийт зарлага 13283,6 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.5.1 | Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэрэглээ, экспортыг нэмэгдүүлнэ | Жилд 500-1000 тонн мах боловсруулах хүчин чадалтай махны үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ | 2021-2024 | ХХААГ, АЗДТГ | БӨХ, ТХ | 700.0 | 4,373.6 | 5,821.26 | 250.0 | "Дэлхийн банкны экспортыг дэмжих төслийн түншлэлийн хөтөлбөр"-ийн төсөлд мах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Завхан хүнс групп ХХК хамрагдаж 458 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд эхний ээлжид 213 сая төгрөгийн зээлийн хөрөнгөөр мах хөргөх өрөөний тоног төхөөрөмжийг шинэчлэх, HACCP стандартыг нэвтрүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээг авсан бөгөөд 2023 оны 10 сард аюулын дүн шинжилгээ эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (HACCP)-нд давтан аудит хийлгэсэн. | 70 |
| 3.1.5.2 | | Орон нутгийн нөөцөд тулгуурлан бие даасан махны экспортын гэрээ хэлэлцээрт оролцоно. | 2021-2024 | АЗДТГ-ын ТЗУХ | ОНТ | 80 | суурь түвшин гараагүй | 8 | 20 | Завхан аймгийн хэмжээнд "Завхан хүнс" групп, "Завхан Мах маркет" ХХК, "Баян нью фүүд центури" ХХК, Нисэх агро ХХК, "Сэцэн Агро" ХХК, "Тэс –Шим" хоршоо зэрэг 6 аж ахуйн нэгж мах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор үйлдвэрийн аргаар боловсруулсан мах нийлүүлэх бие даасан махны экспортын гэрээ байгуулсан аж ахуйн нэгж байхгүй. Улаанбаатар хот дахь гэрээт үйлдвэрүүдэд мах бэлтгэн нийлүүлж байна. | 50 |
| 3.1.6.3 | Орон нутаг дахь үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ | Гэрийн нөхцөлд боловсруулсан цагаан идээний сав баглаа боодлыг сайжруулна | 2021-2024 | ХХААГ | УТ, ТХ | 70 | 5 | 8 | 20 | Сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 11 сумын 37 иргэн аж ахуйн нэгж жилд дунджаар 310.8 тн сүү бэлтгэн зах зээлд нийлүүлж нийт хүн амын сүүний хэрэгцээний 3.2%-ийг, хөдөө аж ахуйгаас 62.8 хувийг бэлтгэж өрхийн үйлдвэрлэлийн түвшинд бэлтгэгдсэн сүү цагаан идээгээр хангаж байна. Сүү сүүн бүтээгдэхүүний гол нөөцийг Их-Уул, Тосонцэнгэл, Идэр, Отгон сум бүрдүүлж байгаа бөгөөд Идэр сумын "Амьтад дөрвөн баатар" ХХК 6 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна. | 100 |
| 3.1.7.1 | Малаас гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлээр дамжуулж, хөдөө аж ахуйн салбарын орлогыг нэмэгдүүлнэ | Малын дайвар бүтээгдэхүүнийг стандартын дагуу бэлтгэж, хагас боловсруулан, зах зээлд нийлүүлэх цехийн үйл ажиллагааг дэмжинэ | 2021-2024 | ХХААГ | УТ, ТХ | 700 | 4 | 14 | 240 | 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд Орон нутгийн хөгжүүлэх сангаас 90.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дөрвөлжин суманд мал нядалгааны цех байгуулахаар тусгагдаж, сумын Засаг даргад эрх шилжсэн боловч тодорхой ажил хийгдээгүй байна. | 0 |
| 3.1.7.2 | | Махны эрүүл ахуй, чанар стандартад хяналт тавьж экспортлогч үйлдвэрүүдтэй уялдуулан борлуулалтад | 2021-2024 | ХХААГ | УТ, ТХ | 80 | 0.50% | 30% | 20 | 2023 оны 10 дугаар сард Мах Маркет ХХК олон улсын чанарын тогтолцоо (HACCP) тогтолцооны давтан аудитаар орж баталгаажсан. Одоогоор үйлдвэрийн аргаар боловсруулсан мах нийлүүлэх экспортын гэрээ байгуулаагүй байна. | 30 |
| 3.1.8.1 | Орон нутгийн барилгын материалын нөөцөд тулгуурлан, хөнгөн үйлдвэрүүдийг байгуулж, борлуулалтын сүлжээг бий болгоно. | Зарим суманд импортын бэлдэцийг ашиглан мод, модон эдлэлийн үйлдвэр байгуулна. | 2023-2023 | ХХААГ, АЗДТГ | УТ, ТХ | 300 | 0 | 2 | 300 | 2023 оны 04 дүгээр сард ОХУ-ын Тува улсын худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөгчид бизнес эрхлэгчид Завхан аймгийн бизнес эрхлэгчидтэй уулзалт зохион байгуулан мод модон эдлэл, аялал жуулчлал, хэвлэл мэдээллийн салбарын хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. | 30 |
| 3.1.8.2 | | Хувийн орон сууцны бэлдэцийг нийлүүлэх төвлөрсөн цэгүүд бий болгоно | 2021-2024 | ХХААГ | УТ, ТХ | 100 | 0 | 1 | 50 | Хувийн орон сууцны бэлдэцийг нийлүүлэх төвлөрсөн цэг байгуулахаар Завхан аймгийн Улиастай сумд Богдын гол ын гүүрний цаана модон материалын зах, цэг байгуулах газрыг шийдвэрлэж, хашаа баригдсан боловч үйл ажиллагаа жигдэрч эхлээгүй байна. | 30 |
| 3.1.8.3 | | Шахмал түлшний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ | 2022-2024 | ХХААГ | УТ, ТХ | 1000 | | 1 | 1000 | 2022 онд Тосонцэнгэл сумд шахмал түлшний үйлдвэр байгуулах ажилд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гэрээ байгуулан, түлхүүр гардуулах нөхцөлөөр тендер зарлаж, гүйцэтгэгч аж ахуй нэгж техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, зураг төсөл, төсвийг хийсэн болович угсралтын ажил эхлээгүй тул 2 тэрбум төгрөг буцаан татагдсан. | 0 |
| 3.1.8.4 | | Ханын дүүргэлтийн материал үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ | 2022-2024 | ХХААГ | УТ, ТХ | 620 | | 3 | 500 | 2023 онд Улиастай сумын Өлзийт багт хувийн аж ахуй нэгжийн санхүүжилтээр хөнгөн блокны үйлдвэр байгуулагдан үйл ажиллагаа жигдэрч хөөсөн хөнгөн блок үйлдвэрлэж байна. Үйлдвэрийн нөөц Алдархаан сумд фосфорт, шохойн чулууны нөөц ихтэй. Мөн хоногт/1000 м3 зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай зуурмагийн үйлдвэр байгуулагдсан. Цаашид Яруу, Тэлмэн, Сантмаргаз сумдад тоосгоны үйлдвэр байгуулах шаврын нөөц байна. | 30 |
| 3.1.8.5 | | Барилгын цутгалтад ашиглах хайрганы үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ | 2022-2024 | ХХААГ | УТ, ТХ | 420 | | 4 | 420 | Завхан аймгийн Улиастай сумд хувийн аж ахуйн нэгжийг дэмжиж барилгын цутгалтанд ашиглах норм стандартын шаардлага хангасан хайрга, дайрга үйлдвэрлэх 2 үйлдвэрийг байгуулсан. Мөн 1000 м3/хоног хүчин чадалтай зуурмагийн үйлдвэрийг байгуулсан. Шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн хайрга, дайрга, бетон зуурмагийг хэвийн нийлүүлж, үйл ажиллагаа жигдрэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.9.1 | Гамшгийн үеийн эдийн засгийг тогтворжуулж, хувийн салбарын санхүүгийн чадамжийг дээшлүүлнэ | Гамшгийн үед хувийн салбарын санхүүгийн алдагдлыг багасгана | 2021-2024 | АЗДТГ | ОНТ, ТХ | 350 | 5 | 15 | 100 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 58 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд 343.350.000 /гурван зуун дөчин гурван сая гурван зуун тавин мянган/ төгрөг, - Аймгийн 2023 онд хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан 2 ажил үйлчилгээг гүйцэтгэхэд 80 сая төгрөг тус тус батлуулсан байна. Аймгийн 24 сумд 2023 онд гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтын хэрэгжилтийг хангуулахаар тусгагдсан санхүүжилт Засаг даргын нөөц санд 120 сая төгрөг төсөвлөн батлуулсан байна. | 90 |
| 3.1.9.2 | | Гамшгийн үед төр, хувийн хэвшлийн бэлэн байдлыг хангуулан, хамтын ажиллагааг өргөжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ | ОНТ, ТХ | 200 | 5 | 10 | 50 | Аймгийн гамшгаас хамгаалах 10 алба, 35-н мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр тодотгол хийлгэн ажилласан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагын харилцан ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулийг 2023 оны 06 дугаар сарын 06-09-ний өдрийн хооронд зохион байгуулсан. Монгол Улсын Шадар сайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.12 дахь хэсэг, Онцгой комиссын 2023 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх, аймаг орон нутагт тохиолдож болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, сэргээн босгоход сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, аж ахуй нэгж байгууллага, ард иргэдийн бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн баталсан Ургамал, Түдэвтэй сумдад Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Шилүүстэй, Цагаанхайрхан сумдад гамшгаас хамгаалах команд штабын сургууль, Эрдэнэхайрхан, Дөрвөлжин сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах удирдамжийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 18-ний өдрөөс 10 дугаар сарын 29-ны хооронд зохион байгуулсан. Сумдын үнэлгээ: Түвтэй сум-91% А, Ургамал сум- 78.5% С, Цагаанхайрхан сум-90.7% А, Шилүүстэй сум-74% С, Эрдэнэхайрхан сум-85% В, Дөрвөлжин сум-70.3% С. Сургалтанд нийт 3197 хүн хамрагдсан. | 100 |
| 3.1.9.3 | | Гамшгийн үеийн нөхцөл байдалтай уялдуулан стратегийн нөөц бүрдүүлнэ. | 2021-2024 | ОБГ,АЗДТГ | ОНТ, ТХ | 280 | 7 | 15 | 80 | Аймгийн аюулгүй нөөцөд 150 сая төгрөгөөр 187.5 тн өвс бэлтгэхээр нээлттэй тендерийн сонгон шалгаруулалт хийгдэж, Очдол-Өлзийт ХХК шалгарсан. | 30 |
| 3.1.10.1 | Технологи мэдээллийн паркад суурилсан ХАА, хүнс, барилга, биотехнологийн туршилтын лабораториудыг байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | Сүлжээ дэлгүүрүүдэд нийлүүлэх малын гаралтай бүтээгдэхүүний чанарын | 2023-2024 | ХХААГ, АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 750 | 8 | 10 | 500 | Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй учир ажил хийгдээгүй. 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлсэн. | 0 |
| 3.1.10.2 | | Инженер техникийн салбарын мэргэжилтэн болон чадварлаг боловсон хүчнийг бодлогоор дэмжинэ | 2021-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 80 | 0 | 15 | 20 | Хөдөө аж ахуйн их сургуультай хүний нөөц, тоног төхөөрөмж, эрдэм шинжилгээ судалгаа хийх шинэ технологи инновацын бүтээгдэхүүн хөгжүүлэх ажилд хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна. Аймгийн Политехник коллежид барилгын засал чимэглэл, мужаан, сантехник, цахилгаанчны чиглэлээр 2023 онд 61 хүүхэд тус мэргэжлээр төгсөж 62 хүүхэд тус мэргэжлээр суралцаж байна. | 90 |
| 3.1.11.1 | Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн түвшинд хөгжүүлнэ | Гарааны бизнес төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 700 | 48 | 120 | 200 | АНУ-н хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Хөгжлийн шийдэл ТББ байгууллагын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрөөс Ногоон анд ХХК Улаан хальст саримс тариалалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 10.0 сая төгрөг, Жинст хайрханы эрдэнэ арвижих ХХК Улаан хальст саримс боловсруулж бүтээгдэхүүн болгоход зориулж 8.2 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг олгосон. Хөгжлийн шийдэл ТТБ-ын Best хөтөлбөрөөс гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 50.0 хүртэлх сая төгрөгийн зээлийг олгохоор төсөл сонгон шалгаруулах шатандаа явж байна. | 70 |
| 3.1.11.2 | | Улс, бүс нутаг, аймагт үзэсгэлэн худалдааг зохион байгуулна | 2021-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 200 | 5 | 5 | 50 | "Цагаан сар-2023" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд Архангай , Төв, Завхан аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 50 гаруй иргэн, аж ахуйн нэгж 67 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 60.2 сая төгрөгний борлуулалт хийсэн. Улаанбаатар хотод 2023.01.21-02.21-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Цагаан сар" үзэсгэлэн худалдаанд Тосонцэнгэл, Улиастай, Алдархаан сумдаас сармис, жимс, жимсгэнээр 1 аж ахуйн нэгж, 3 иргэн оролцсон. 2023 оны 05 дугаар сард хүнсний үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийг Баруун бүсийн үйлдвэрлэл эрхлэгчидтэй туршлага судлах, бараа бүтээгдэхүүнээ сурталчлан худалдан борлуулах бизнес аялал, үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. | 100 |
| 3.1.11.3 | | Аймгийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 0 | 25980.4 | 29192.4 | 0 | Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2023 оны 8 дугаар сарын байдлаар буурсан үзүүлэлттэй байгаа ч боловсруулах үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ 2022 оны мөн үетэй харьцуулахад 0,39% өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тэр дундаа нарийн боовны үйлдвэрлэлийн хэмжээ 4,79%, цэвэр усны үйлдвэрлэл 2,1% өссөн үзүүлэлттэй байна. Баталгаажуулалтын зөвлөлийн хурлын шийдвэрээр энэ оны 10 сарын байдлаар 23 сумын 201 иргэн, аж ахуйн нэгж, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд баталгаажуулах үйл ажиллагааг хийж, баталгаажуулалтын зөвлөлийн 12 удаагийн хурлаар 182 аж ахуй нэгж, 17 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгож үйл ажиллагаа жигдэрсэн байна. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.11.4 | | Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг нийлүүлэх тээвэр, логистикийн төвүүдийг томоохон хотуудад байгуулна | 2022-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 1000 | | 1 | 500 | Хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул ажил хийгдээгүй. | 0 |
| 3.1.11.5 | | Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх төв байгуулна | 2022-2023 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 400 | | 1 | 200 | Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхим, бизнес эрхлэгчидтэй хамтран "Бизнесийг дэмжих-Завханд үйлдвэрлэв" төвийг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр нээж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Тус төвд "Мөнхөд Мандаг" ХХК, Анд оймс, зэрэг нутгийн брэндүүд мөн хувиараа бизнес эрхлэгч, иргэн аж ахуй нэгжийн бүтээлүүд худалдаалагдаж байна. | 90 |
| 3.1.11.6 | | Орон нутгийн давуу талыг түшиглэн хөрш зэргэлдээ улс, аймгуудад бүтээгдэхүүн нийлүүлэх сувгийг өргөжүүлнэ | 2021-2024 | ХАУТ | ОНТ, ТХ, БӨХ | 160 | 3 | 15 | 50 | Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн борлуулдаг Завханд үйлдвэрлэв онлайн дэлгүүр Хүннү зоогийн газрын танхимд 13 аж ахуйн нэгж үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. "Мөнхөд Мандаг" ХХК Номин сүлжээ дэлгүүртэй бренд бүтээгдхүүнээ борлуулах гэрээ хийж, бараа бүтээгдэхүүнээ борлуулж байна. Улиастай суманд Эм Ар Эм Эс ХХК 500 м2 талбай бүхий Баян бүрд агуулах худалдаа үйл ажиллагаа эхлүүлсэн . Тус компани нь Витафит, АПУ гэх мэт 6 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан бөөний үнээр сумдын худалдаа эрхлэгчдэд хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг худалдаалж байна. | 100 |
| 3.1.11.7 | | Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг борлуулдаг албан ёсны платформ бий болгож борлуулалтыг дэмжинэ | 2021-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 70 | 0 | 200000 | 3 | 100 жилийн ойг тохиолдуулан Call Center үйлчилгээ нэвтрүүлж аймгийн брэнд бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээний нэгдсэн мэдээллийн сувгийг бий болгосон аппликейшн боловсруулалтын ажил хийгдэж байна. zavkhan brend.com цахим флатформ хөгжүүлэлтийн эрх нээгдсэн бараа бүтээгдэхүүн байршуулах боловсруулалтын ажил хийгдэж байна. | 70 |
| 3.1.11.8 | | "Завханд үйлдвэрлэв" лого-г эзэмшүүлж үйлдвэрлэгчдийг дэмжинэ | 2021-2024 | ХАУТ | ОНТ, ТХ, БӨХ | 45 | 5 | 50 | 0 | ХАУТанхимын Завхан салбар "Завханд үйлдвэрлэв" логоны патентыг эзэмшиж байна. Одоогийн байдлаар 5 аж ахуйн нэгж өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн дээр логог хэрэглэж байна. | 70 |
| 3.1.12.1 | Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжинэ | Томоохон төслүүдийг орон нутгийн цахим сүлжээнд байршуулж, иргэдийн оролцох боломжийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХААГ | ОНТ | 1 | 60% | 100% | | ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлийн төсөл хүлээн авах хугацаа 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 10-ны өглөөний 08.30 цаг хүртэл цахимаар хүлээн авахаар зарласантай холбогдуулан мэдээллийг байгууллагын цахим хаяг болон Завхан аймгийн сайт, групп чатуудаар дамжуулан хүргэж ажилласан. Цахим программаар 1.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 16 аж ахуйн нэгжийн төслийг хүлээн авч 6 аж ахуйн нэгж иргэнд 788.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. | 90 |
| 3.1.13.2 | | Маркетингийн үйлчилгээ үзүүлэх зөвлөх компаниудтай хамтран ажиллана | 2021-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 25 | 1 | | | Жижиг, дунд үйлдвэрийн газар, Төрийн банк, Хөгжлийн шийдэл ТББ-ийн BEST хөтөлбөртэй хамтран Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн болон төсөл боловсруулах талаарх зөвлөгөө мэдээлэл өгөх сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж 50 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг, "БҮТЭЭЛЧ CEO" сургалтын хүрээнд 10 дугаар сарын 19-ны өдөр Best хөтөлбөрийн мэргэжилтэн Маркетинг- хэрэглэгчийн судалгаа ба бүтээгдэхүүн хөгжүүлэлт сэдвийн хүрээнд цахим сургалт зохион байгуулж 11 аж ахуйн нэгжийг хамруулсан. | 100 |
| 3.1.14.1 | | ЖДҮХС, СХС, ХЭДС -ийн зээлийн материал бүрдүүлэлт, шалгаруулалтыг цахим системээр дамжуулан хийнэ | 2021-2024 | ХХҮГ | ОНТ, ТХ, БӨХ | 40 | 5% | 20% | 0 | ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлийн төсөл хүлээн авах хугацаа 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 10-ны өглөөний 08.30 цаг хүртэл цахимаар хүлээн авахаар зарласантай холбогдуулан мэдээллийг байгууллагын сайт болон Завхан аймгийн сайт, групп чатуудаар дамжуулан хүргэж ажилласан. Цахим программаар 1.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 16 аж ахуйн нэгжийн төслийг хүлээн авсан. | 100 |
| 3.1.14.2 | Гарааны бизнес эхлүүлж буй аж ахуйн нэгж, иргэдийн ЖДҮХС, СХС, ХЭДС-ийн зээлийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ | Банкууд, бизнес эрхлэгчдийн уулзалт зохион байгуулна | 2021-2024 | ХХҮГ, BEST төсөл | ОНТ, ТХ, БӨХ | 14 | 500 | 1000 | 3 | Жижиг дунд үйлдвэрийн газар, Зээлийн батлан даалтын сан, Монгол банкнаас хамтран 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Бичил, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх” цахим сургалтад 34 аж ахуйн нэгжийг хамруулсан. | 100 |
| 3.1.14.3 | | СХС, ЖДҮХС, ХЭДС-ийн зээлийг орон нутгийн үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулна | 2021-2024 | ХХҮГ | ОНТ, ТХ, БӨХ | 3500 | 10% | 40% | 1000 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/247 дугаар захирамжаар 2022-2025 онд дэмжин хөгжүүлэх "Жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбар"-ын жагсаалтыг батлуулсан. 2023 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд зоорины аж ахуйн чиглэлээр-1, эрчимжсэн аж ахуйн чиглэлээр-3, тахианы аж ахуйн чиглэлээр-1, мах махан бүтээгдэхүүн болон хүнсний ногоо боловсруулах чиглэлээр-1 нийт 6 аж ахуйн нэгжийн 788.5 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна. Хоршоо хөгжүүлэх сангаас энэ оны 10 сарын байдлаар хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр олгосон зээл 28%, мал аж ахуйн чиглэлээр олгосон зээл 10.4%, хүнс үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр 7.2 хувийг эзэлж байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.14.4 | | Банкны болон төслийн зээлийн шалгуурт шинэ бизнесийг дэмжих хэмжээг нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХҮГ | ОНТ, ТХ, БӨХ | 4000 | суурь түвшин гараагүй | 20% | 1000 | Монгол улсын Засгийн газраас газар тариалан, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 3 жилийн хугацаатай жилийн 3 хувийн хүүтэй хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд ХААН банк 29 иргэн, аж ахуйн нэгжид 1.5 тэр бум төгрөгийн зээлийг олгосон байна. АНУ-ын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Хөгжлийн шийдэл ТББ байгууллагын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрөөс Ногоон анд ХХК Улаан хальст саримс тариалалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 10.0 сая төгрөг, Жинст хайрхны эрдэнэ арвижих ХХК Улаан хальст саримс боловсруулж бүтээгдэхүүн болгоход зориулж 8.2 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг олгосон | 100 |
| 3.1.15.1 | Малчид тариаланчид, сумын төвийн өрхүүдийн хамтын сан, хоршооны үйл ажиллагааг дэмжиж, өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. | Малчдын бүлэг, хоршоонд тулгуурлан мал нядалгааны цех байгуулах үйл ажиллагааг дэмжинэ | 2022-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 5000 | | 2 | 2000 | Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 оны 11 дүгээр сарын байдлаар мал нядалгааны цех байгуулах чиглэлээр олгосон зээл гараагүй байна. 2023 онд 1350 кг дайвар бүтээгдэхүүн боловсруулан зах зээлд нийлүүлсэн байна. | 30 |
| 3.1.15.2 | | Орон нутагт хэрэгжиж буй төслүүдийн дэмжлэгтэй байгуулагдсан бүлэг, хоршоодын үйл ажиллагааг дэмжинэ | 2021-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 2000 | 300 | 400 | 500 | Best хөтөлбөрийн газартай хамтран саримсны тариалан эрхэлж байгаа 62 аж ахуйн нэгж, иргэдэд хоршоо, хөдөө аж ахуйн зохистой дадлын чиглэлээр 3 удаагийн сургалт зохион байгуулсан. Улаан хальст саримсны борлуулалтыг хөгжүүлэх ажлын хүрээнд эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан сав баглаа боодолтой болгож зах зээлд худалдан борлуулах зорилгоор Улиастай саримс дундын хоршоо байгуулагдаж үйлдвэрлэлдээ Хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлсэн. "Монгол ногоо" төслийн газраас дундын хоршоонд үүргэвчин шүршигч 5 ширхэгийг нийлүүлсэн. АНУ-ын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Хөгжлийн шийдэл ТББ байгууллагын хэрэгжүүлж буй BEST / Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах ил тод байдлыг нэмэгдүүлэх / хөтөлбөрөөс Ногоон анд ХХК Улаан хальст саримс тариалалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 10.0 сая төгрөг, Жинст хайрханы эрдэнэ арвижих ХХК Улаан хальст саримс боловсруулж бүтээгдэхүүн болгоход зориулж 8.2 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг олгосон | 100 |
| 3.1.15.3 | | Хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох түргэвчилсэн сургалтуудыг зохион байгуулна | 2021-2025 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 40 | 0 | 250 | 10 | Хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох сургалтыг Best хөтөлбөрийн газартай хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй хүлээгдэж байна. Сургалтыг 12 дугаар сард мэргэжлийн холбоодтой хамтран хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | 0 |
| 3.1.15.4 | | Бизнес эрхлэгчдэд “Зээлийн батлан даалтын сан”-гаас дэмжлэг үзүүлэхэд зуучлах үйлчилгээг өргөжүүлнэ | 2021-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 0 | 1% | 4% | 0 | Монгол банкнаас жижиг дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгч, банкны эдийн засагч нарт зориулж Батлан даалттай зээлд хэрхэн хамрагдах вэ? сэдэвт сургалтыг эхний хагас жилийн байдлаар 3 удаагийн сургалт зохион байгуулж 50 аж ахуйн нэгж, иргэн, банкны эдийн засагч 15 хүнийг хамруулсан. Зээлийн батлан даалтад нийт Хас банкаар дамжуулан 2, Хаан банкаар дамжуулан 1, Төрийн банкаар дамжуулан 1 аж ахуйн нэгж хамрагдсан байна. Үүнээс 2023 онд орон сууцны зээлийн батлан даалтад 1 иргэн хамрагдсан. | 100 |
| 3.1.15.5 | | Өрхүүдэд санхүүгийн боловсрол олгох сургалт сурталчилгаа нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 100 | 1500 | 4000 | 30 | Сумдын ХААТасгийн ЖДҮ хариуцсан мэргэжилтэн нарт 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдөр жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн талаар 4 аж ахуйн нэгж, 1 иргэнд төсөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын талаар зөвлөгөө өгсөн. | 30 |
| 1 | | | | | | | | | | | **67.07** |
| **3.2** | **Байгальд ээлтэй технологи бүхий ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ** | | | | | | | | | | |
| 3.2.1.1 | Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлнэ | Үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудтай хариуцлагын гэрээ байгуулж ажиллана | 2021-2024 | АСЗДТГ | ОНТ | 0 | 0 | 2 | 0 | Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуй нэгжүүд харьяа сумдтайгаа хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| 3.2.1.2 | | Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж | 2021-2024 | БОАЖГ | ОНТ | 20 | 0 | 3 | 5 | Хяналт шалгалтын ажлыг 2 удаа хийсэн. Аймгийн хэмжээнд 536683.7 гектар талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын материал ирж дэмжигдээгүй. БОМТ-ний явцын хяналтыг 9-р сарын 27-29-ний өдрүүдэд хийж заавар зөвлөгөө өгч ажилласан. | 100 |
| 3.2.1.3 | | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ | 2021-2024 | БОАЖГ | ОНТ | 12 | | 1 | 3 | Аймгийн хэмжээнд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангуулах 3 зорилт 12 арга хэмжээ бүхий 2023 оны төлөвлөгөөг аймгийн дэд зөвлөлийн даргаар батлуулан ажиллаж байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч 12 аж ахуйн нэгжийн 2022 онд хүлээн авсан хандив дэмжлэг тусламжийн тайланг "www.eitimongolia.mn" цахим системээр гаргаж, тайланг аймгийн Zavkhan.gov.mn сайтын ил тод цэсэнд байршуулж, мэдээлсэн. Хариуцлагатай уул уурхай баруун бүсийн өдөрлөг арга хэмжээнд Засаг даргын орлогч , уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн, уул уурхай бүхий сумдын засаг дарга, иргэд хамтарсан уулзалт зөвөлгөөнд оролцсон. | 100 |
| 3.2.1.4 | | Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байршуулсан барьцаа хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавина | 2021-2024 | БОАЖГ | ОНТ | 1 | 5% | 100% | | Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуй нэгж-219.852.500 төгрөг. Хайгуулын үйл ажиллагаа явуулж буй 5 аж ахуй нэгж-5.353.000 төгрөг байршуулаад байна. Уул уурхайн хяналтын улсын байцаагч төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг улирал бүр хийж байна. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **92.5** |
| **3.3** | **Бэлчээрийн даацад нийцсэн ашиг шим өндөртэй эрүүл малыг өсгөн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлнэ** | | | | | | | | | | |
| 3.3.1.1 | Эрүүл өндөр ашиг шимт мал сүргийг үржүүлнэ | "Чинээлэг малчин" арга хэмжээ хэрэгжүүлнэ | 2021-2024 | ХХААГ, МЭГ,СЗДТГ | БӨХ, ТХ | 90 | 0 | 360 | 20 | Хүнсний аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд Аймгийн Засаг даргын ивээл дор Аймгийн Малчдын чуулга, уулзалтыг 2023 оны 02 сарын 15-ны өдөр холбогдох агентлаг, байгууллагуудтай хамтран зохион байгуулсан ба зөвлөгөөнд 24 сумын малчдын төлөөлөл бүхий 750 гаруй малчин, сумдын удирдлагууд оролцож залуу малчдыг төрөөс дэмжиж, залгамж халааг бэлдэх, мөн малчдын нийгмийн асуудалд анхаарах мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох, залуу гэр бүлийг дэмжих бодлогыг баримтлан ажиллах арга зам зэрэг асуудлыг хэлэлцлээ. Шинэ сэргэлт-мал аж ахуй залуу малчдын үндэсний чуулган Улаанбаатар хотод зохион байгуулагдаж 18-35 насны залуу малчдын төлөөлөл бүхий 27 малчин оролцлоо. | 70 |
| 3.3.1.2 | | Малын эрүүл мэндийн мөшгөх тогтолцоог ISO стандартад нийцүүлнэ | 2021-2024 | ХХААГ, МЭ,СЗДТГ | БӨХ, ТХ | 0 | 22540 | 150000 | 0 | 2020 онд Мал эмнэлгийн нэгдсэн системийг нэвтрүүлсэн. Үүнээс хойш 2 удаа шинэчлэгдсэн. Мал эрүүл мэндийн мөшгих тогтолцоог нэвтрүүлснээр малын шилжилт хөдөлгөөнийг хянах, малын хулгайтай тэмцэх, мал амьтны халдварт өвчнийг тандах, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх тэмцэх арга хэмжээг төлөвлөхөд шаардагдах мэдээллийн санг бүрдүүлсэн. 2023 онд 9037 Мал эмнэлгийн гэрчилгээ бичигдсэн. Үүнээс:<br>Амьтан хэрэгцээлэх зориулалтаар- 4730<br>Отор нүүдлийн зориулалтаар- 373<br>Бүтээгдэхүүний зориулалтаар- 3349<br>Үржлийн зориулалтаар- 585 гэрчилгээ бичигдсэн байна. | 100 |
| 3.3.1.3 | | Хөдөө аж ахуйн тасаг, мал эмнэлгийн тасаг , мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдийн ажиллах нөхцлийг сайжруулна | 2021-2024 | ХХААГ, МЭГ,СЗДТГ | БӨХ, ТХ | 70 | 2 | 7 | 20 | 24 сумын 18 сумдын ХААТасагт мал зүйч мэргэжилтэн ажиллаж байна. Үлдсэн 6 сум нь малзүйч мэргэжилтэн байхгүй бөгөөд тус судалгаа гарган ХХААХҮЯам, Монголын малзүйч, үржүүлэгчдийн холбоонд хүргүүлэн ажиллаа. Аймгийн хэмжээнд 10 үржүүлэг технологийн нэгж үйл ажиллагааг эрхлэн, мөн энэ ондоо багтаан шинээр 1 үржүүлэг технологийн нэгж байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ онд "АДАПТ" төслөөс санхүүжүүлэн Завхан Буурал үүлдрийн ямаа-20, Сартуул үүлдрийн хонь-20, хээлтүүлэгч хуц-4, ухна-4 сонгон Сартуул үүлдрийн хонь, Завхан Буурал үүлдрийн ямааны нийгэмлэгт хүлээлгэн өгсөн. | 100 |
| 3.3.1.4 | | Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ | 2021-2024 | ХХААГ, МЭ,СЗДТГ | БӨХ, ТХ | 40 | 27 | 33 | 10 | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлд Улиастай, Идэр сумын сүү-махны хосолмол үхэр үржүүлэгч 2, Алдархаан сумын сарлагийн аж ахуй эрхлэгч, Улиастай сумын тахианы аж ахуй эрхлэгч нийт 4 аж ахуй нэгж зээл авах төслөө ирүүлэн аймгийн дэд хорооны шийдвэрээр шалгарч нийт 600.0 сая төгрөгийн зээл олгогдохоор болсон. ХХС, ЖДҮ-сангаас зээл хүссэн, зээлд хамрагдахаар зэхэж буй аж ахуй нэгж хоршоодод Улиастай сум, ХХААГ, Сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд тогтмол сургалт мэдээлэл хийж байна. | 90 |
| 3.3.1.5 | | Малын халдварт, гоц халдварт өвчнөөр тайван бүсийг бий болгоно | 2022-2024 | ХХААГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 160 | | 2 | 40 | Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 01 тоот албан даалгавар, мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 сарын 11-ний өдрийн А/87 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 04 сарын 19-ний өдрийн А/134 тоот захирамж гаргуулан Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтанд 265.623 толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөн ажиллалаа .Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны хооронд зохион байгуулан ажиллалаа. Дархлаажуулалтын арга хэмжээнд 60 ажлын хэсэгт удирдах ажилтан 85, малын эмч 70, санитарч, техникч 23, туслах ажилтан 68, жолооч 54, нийт 300 хүн үүрэг гүйцэтгэж 10336 өрхийн 256825 үхэр, 72 гахай, нийт 256897 толгой мал, амьтан дархлаажуулалтанд хамруулсан байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/251 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/414 тоот захирамжийн дагуу Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтанд 308465 мянган толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөн дархлаажуулалтанд шаардагдах 308500 тун вакциныг мал эмнэлгийн ерөнхий газраас хүлээн авч аймаг, сум, мал эмнэлгийн үйлчилгээг нэгжийн дугаараар дугаарлан сумдын мал эмнэлгийн тасгийн байцаагч, тархварзүйч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт хүлээлгэн өгч ажиллалаа. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 297450 толгой мал амьтан хамрагдсан байна. | 100 |
| 3.3.1.6 | | Мал сүргийн чанар, үүлдэр угсааг сайжруулахад "Завхан цөм сүргийн салбар"-тай хамтран ажиллана | 2021-2024 | ХХААГ,СЗДТГ | БӨХ, ТХ | 60 | 2 | 5 | 20 | Малд үзлэг, ангилалт хийх ажлыг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын Үржлийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлын удирдамж, малд үзлэг ангилалт явуулах тухай хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-71 дугаар тушаалаар баталсан заавар зэргийг үндэслэн Сартуул үүлдрийн хонь, Завхан буурал үүлдрийн ямаан үзлэг ангилалт зохион байгууллахаар төлөвлөн ажиллаж байна. | 30 |
| 3.3.1.7 | | Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХААГ,СЗДТГ | БӨХ, ТХ | 60 | 23% | 40% | 20 | Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/205 тоот захирамж гаргуулан Аймгийн мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулан ажиллаж байна. 2023 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2675.5 мянган толгой мал хамрагдахаас 2541.7 мянган толгой мал хамрагдсан. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.2.1 | Бэлчээр ашиглалтыг сайжруулан, малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлнэ | Атаршсан тариалангийн талбайг эргэлтэд оруулж, малын тэжээл тариалалтыг | 2021-2024 | ХХААГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 400 | 1525 | 2200 | 100 | Аймгийн хэмжээнд 2023 онд үр тариа 2785 га, малын тэжээл 6517.1 га, төмс 186.6 га, хүнсний ногоо 182.7 га-д тариалалт хийсэн нь өмнөх оноос тариалсан талбай 3100.6 га-гаар буюу 47.1 хувиар нэмэгдсэн байна. Малын тэжээл тариалсан талбай 2914.1 га-гаар, хураан авсан ургац 10159 тн-оор нэмэгдсэн байна. | 100 |
| 3.3.2.2 | | Услалтын системийг сэргээн засварлана | 2022-2024 | ХХААГ | ОНТ, ТХ, БӨХ | 450 | | 770 | 200 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих “Хүнсний ногоо үйлдвэрлэл ба усалгаатай тариалан” хөгжүүлэх төслийн хүрээнд Улиастай сумын Ногоон хашаа, Тэлмэн сумын Хүрэн талын услалтын системийг 2022-2023 онд сэргээн засварлана. Хүрэн тал услалтын системийг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчээр "Цонбон тоосго" ХХК шалгарч одоогийн байдлаар толгойн барилгын ажил, суваг лайдах ажлыг хийж гүйцэтгэл 42 хувьтай, Ногоон хашаа услалтын системийг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчээр "Хан империал" ХХК нь шалгарч 5000 гаруй сувгийн хажуугийн хавтанг цутгаж толгойн барилгын ажлыг эхлэхээр бэлтгэл ажлаа хийж гүйцэтгэл 40 хувьтай байна. Одоогийн байдлаар тус 2 услалтын системийн барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна. | 30 |
| 3.3.2.3 | | Усны хайгуул судалгааг хийж, уст цэгийн тоог нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХААГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 200 | 538 | 558 | 50 | ХХААХҮЯаманд Цэцэн-Уул, Ургамал сумдын 10 уст цэгийн судалгааг хүргүүлсэн. АДАПТ төслөөс Алдархаан, Завханмандал, Сонгино, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй сумдад инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргахаар уст цэгийн хайгуул хийсэн. | 70 |
| 3.3.2.4 | | Бэлчээрийн ургамлын нөхөн сэргээлт, тариалалтыг нэмэгдүүлнэ | 2022-2024 | | ОНТ, ТХ, БӨХ | 40 | | 0.30% | 20 | Аймгийн хэмжээнд тариалалтын мэдээгээр 2022 онд малын тэжээл 3603 га талбайд тариалснаас 4768 тн хураан авсан, 2023 онд 6517,1 га талбайд тариалснаас 14927,1 тн тэжээл хураан авсан нь өмнөх оноос 10159 тн-оор илүү хураан авсан байна. | 70 |
| 3.3.2.5 | | Малын эрдэс, тэжээлийн үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ | 2022-2023 | | ОНТ, ТХ, БӨХ | 300 | | 1 | 150 | Үр тариа, малын тэжээл тариалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Баруун бүсийн гурил тэжээл" ХХК нь Тэс суманд багсармал тэжээл үйлдвэрлэхээр дунд оврын тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурилуулж шинээр ашиглалтад оруулсан. | 100 |
| 3.3.2.6 | | Малын тэжээл болон хүнсний ногоо тариалагчдын техник дундын төв байгуулна | 2021-2024 | ХХААГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 2400 | 0 | 6 | 1200 | "Шинэ хөдөө төсөл"-ийн хүрээнд 240.0 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар малын тэжээл тариалах, хураан авах трактор, тэжээл үрлэгч, хадуур, тармуур, хаман боогч, анжис зэрэг тоног төхөөрөмжийг хүлээн авч Асгат суманд үр тариа, малын тэжээл тариалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Жавхлант шим" ХХК-тай гэрээ байгуулан эзэмшүүлж байна. | 90 |
| 3.3.2.7 | | Бэлчээр ашиглагчдын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, “Малчдын дундын сан”-г байгуулна | 2021-2024 | ХХААГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 110 | 183 | 220 | 30 | Аймгийн хэмжээнд 187 бэлчээр ашиглагчдын хэсэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд шинээр 10 малчдын дундын сан байгуулагдсан. | 50 |
| 3.3.3.1 | Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгоно. | Завханд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нэгтгэн томоохон зах зээлд борлуулах бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ. | 2023-2023 | ХХААГ, АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 100 | 0 | 1 | 100 | Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн борлуулдаг Завханд үйлдвэрлэв онлайн дэлгүүр Хүннү зоогийн газрын танхимд 10 аж ахуйн нэгж үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. 100 жилийн ойг тохиолдуулан Call Center үйлчилгээ нэвтрүүлж аймгийн брэнд бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээний нэгдсэн мэдээллийн сувгийг бий болгосон аппликейшн боловсруулалтын ажил хийгдэж байна. zavkhan brend.com цахим флатформ хөгжүүлэлтийн эрх нээгдсэн бараа бүтээгдэхүүн байршуулах боловсруулалтын ажил хийгдэж байна. | 50 |
| 3.3.4.1 | | Малчдын залуу үеийг бэлдэнэ | 2021-2024 | ХХААГ,АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 100 | 50 | 300 | 30 | Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас 2023 онд 58 өрх тус бүрийг 5.0 сая төгрөгөөр, нийт 290.0 сая төгрөгөөр малжуулах төсөлд хамруулахаар төлөвлөснөөс 33 өрхөд 165.0 сая төгрөг олгохоор гэрээ хийгдсэн. 2023 оны хавар Улиастай сумын Политехник коллежийг малчин мэргэжлээр 17 суралцагч төгссөн бол одоо 20 суралцагч тус мэргэжлээр суралцаж байна. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.4.2 | | Хүн амын усан хангамжийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | ХХААГ,АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 40 | 538 | 8 | 10 | 2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дөрвөлжин, Завханмандал, Цагаанхайрхан, Тэлмэн, Түдэвтэй сумдад инженерийн хийцтэй бэлчээрийн гүн өрмийн худаг шинээр гаргасан. 2023 онд аймгийн орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар Алдархаан суманд инженерийн хийцтэй бэлчээрийн гүн өрмийн худаг шинээр гаргасан. Баянтэс, Баянхайрхан сумд инженерийн хийцтэй худаг гаргах тендер зарлагдаж гүйцэтгэгч компаниар "Гранд холдинг" ХХК шалгарч ажил хийгдэж байна. АДАПТ төслийн санхүүжилтээр Алдархаан, Завханмандал, Шилүүстэй, Отгон, Сонгино, Цэцэн-Уул, Цагаанчулуут сумдад инженерийн хийцтэй бэлчээрийн гүн өрмийн худаг шинээр гаргахаар 2 багцтайгаар тендер зарлагдаж багц-1 буюу Цагаанчулуут, Шилүүстэй сумдад худаг гаргах гүйцэтгэгч компаниар "Гранд холдинг" ХХК шалгарч гэрээ байгуулан ажил хийгдэж байна. багц-2 буюу Алдархаан, Сонгино, Завханмандал сумдад бэлчээрийн худаг гаргах сонгон шалгаруулалт зарлагдсан. Отгон, Цэцэн-Уул сумдад усны хайгуул хийгдсэн цэг байхгүй тул хүлээгдэж байна. | 70 |
| 3.3.4.3 | Малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ | Малчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрүүл дадал хэвшил төлөвшүүлнэ | 2021-2024 | ХХААГ,АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 80 | 4000 | 7000 | 20 | Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ний өдрийн "Өвөл хаврын цаг агаарын хүндрэл, байгалийн болзошгүй аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр захирамжийг хэрэгжлүүлэн отроор нүүдэллэн яваа малчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд анхаарч үзлэг, шинжилгээнд хамруулах, дархлаажуулалт, амин дэмээр хангах ажлыг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд 24 сумын 433 өрхийн, 782 иргэнд зөөврийн ЭХО болон мобайл технологийн тоног төхөөрөмжийг ашиглан явуулын тусламж, үйлчилгээг хүргэн ажилласан байна. Үүнээс: Жирэмсэн эх – 67, 0-5 хүртэлх насны хүүхэд – 68, Ахмад настан – 128, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн – 16, Архаг суурь өвчтэй иргэн – 177 байна. Улаанбурхан улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг сургууль цэцэрлэгийн зуны амралттай үед явуулын дархлаажуулалтыг зохион байгуулж нийт 1034 /14.7 хувь/ хүүхэд хамрагдсан байна. | 100 |
| 3.3.4.4 | | Малчид өвөлжөөндөө орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | ХХААГ,АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 200 | 50 | 150 | 50 | Энэ онд Нөмрөг, Их-уул, Тэлмэн, Тосонцэнгэл, Түдэвтэй, Тэс сумдын 11 малчин өрх өвөлжөөндөө өөрийн хөрөнгөөр шинээр сууц барьсан байна. | 100 |
| 3.3.4.5 | | Малчид, малчдын бүлэг, хоршооны сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, алдаршуулна | 2021-2024 | ХХААГ,АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 80 | 120 | 400 | 20 | Жижиг дунд үйлдвэрийн газраас Олон улсын хоршооллын өдрийг тохиолдуулан “Хоршоологчид тогтвортой хөгжил уриан дор Говьсүмбэр, Улаанбаатар хотод 2023 оны 06 сарын 29-нөөс 07 сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан арга хэмжээнд хоршоо, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн болон Улиастай сумын “Ногоон анд ХХК”, Тэлмэн сумын “Улаан хадны цуурай хоршоо”, Тосонцэнгэл сумын “Хөх тэнгэрийн булаг хоршоо”-ны 4 төлөөллийг оролцуулсан. | 100 |
| 3.3.5.1 | | Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалт, хадгалалт, борлуулалтыг дэмжинэ | 2021-2024 | ХХААГ,АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 80 | 36.5% | 45.00% | 20 | 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 602 өрх, 96 аж ахуйн нэгж үр тариа 2785 га, малын тэжээл 6517.1 га, төмс 186.6 га, хүнсний ногоо 182.7 га-д тус тус тариалалт хийж үр тариа 720.5 тн, малын тэжээл 14927.1 тн, төмс 1552.1 тн, хүнсний ногоо 1323.6 тн-ыг хураан аваад байна. Аймгийн хүн амын хэрэгцээт төмс, хүнсний ногооны 37.2 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна. | 90 |
| 3.3.5.2 | Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж, борлуулалтын сүлжээг өргөжүүлнэ | Хүнсний ногооны механикжсан зоорь байгуулах үйл ажиллагааг эхлүүлнэ | 2022-2023 | ХХААГ | УТ, ТХ, БӨХ | 700 | | 1 | 400 | Тосонцэнгэл суманд Тосон арвижих ХХК 300 тн, Улиастай суманд Загасан нүд-Загастай ХХК 500 тн, Алдархаан суманд Завхан солонго хоршоо 120 тн-ын багтаамж бүхий төмс, хүнсний ногоо хадгалах зоорины аж ахуй эрхэлж байна. Улиастай суманд төмс, хүнсний ногоог технологийн дагуу хадгалах 1000 тн-ын багтаамж бүхий зоорь барих тухай саналыг ХХААХҮЯаманд хүргүүлсэн. Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй хүлээгдэж байна. | 50 |
| 3.3.5.3 | | "Завханы улаан хальст саримс"-ийг брэндийн түвшинд хөгжүүлнэ | 2021-2024 | ХХААГ,АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 40 | 23.2 | 30 | 10 | Улиастай, Алдархаан, Отгон, Тэлмэн, Идэр сумдын 117 иргэн, аж ахуйн нэгж улаан хальст саримсыг 17.65 га-д тариалалт хийж 32.3 тн ургац хураан авсан. Улаан хальст саримсны борлуулалтыг хөгжүүлэх ажлын хүрээнд "Жаргалтай" хоршоон дээр оюуны эрхээр хамгаалагдсан газар зүйн заалтыг хамтран эзэмших замаар эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан сав баглаа боодолтой болгож зах зээлд худалдан борлуулах зорилгоор "Улиастай саримс" дундын хоршоо байгуулагдаж ХАА-н зохистой дадлын гэрчилгээ авсан байна. Газарзүйн заалттай бүтээгдэхүүнээр баталгаажуулах ажил бичиг баримт бүрдүүлэх шатандаа явж байна. | 90 |
| 3.3.6.1 | Төв суурин газрын хүн амыг түшиглэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ | Төв суурин газрын хүн амыг түшиглэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ | 2021-2023 | ХХААГ,АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 60 | 1800 | 2400 | 20 | Улиастай суманд “Загасан нүд-Загастай” ХХК 600 м2 талбайд, Тосонцэнгэл суманд "Тосон Эко хүнс" ногоочдын бүлэг 280 м2 талбайд өвлийн хүлэмжийн аж ахуйн тариалан эрхэлж байна. Аймгийн хэмжээнд 880 м2 талбайд 2 аж ахуйн нэгж өвлийн хүлэмжийн тариалан, 56 өрх зуны хүлэмжийн тариаланг 3916 м2 талбайд эрхэлж 32.7 тн эрт ургацын ногоог хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн. | 90 |
| 3.3.7.1 | Тариаланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, залуу тариаланч бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ | Тариаланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, залуу тариаланч бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | ХХААГ,АЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 2 | 150 | 200 | 0 | Монгол улсын Засгийн газраас газар тариалан, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 3 жилийн хугацаатай жилийн 3 хувийн хүүтэй хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд Хаан банк 29 иргэн, аж ахуйн нэгжид 1.5 тэр бум төгрөгийн зээлийг олгосон байна. Өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор ХХААХҮЯамнаас 49.664.628 төгрөгийн 13 төрлийн хүнсний ногооны үрийг татан авч 18 сумын тариалан эрхлэгчдэд 80 хувийн хөнгөлөлттэй үнээр Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан олгосон. | 90 |
| **3.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **80.00** |
| **3.4** | **Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.1.1 | Аймгийн аялал жуулчлалын гол, туслах маршрутад түшиглэн үйлчилгээ, мэдээллийн төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | Аялал жуулчлалын мэдээллийн төвийн үйл ажиллагааг сайжруулна | 2022-2024 | БОАЖГ | ОНТ, ТХ, БӨХ | 240 | | 4 | 120 | Аймгийн хэмжээнд Алдархаан, Их-Уул сумдад нийт 2 мэдээллийн төв үйл ажиллагаа явуулж байна. 2021 онд Их-Уул сумын мэдээллийн төвийн тохижилтын ажлыг хийсэн. 2022 онд мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааг сайжруулахаар АЖГХА-наас мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. | 100 |
| 3.4.1.2 | | Аялал жуулчлалын гол, туслах маршрутын дагуу эко ариун цэврийн байгууламж бий болгоно | 2021-2024 | БОАЖГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 200 | 0 | 6 | 50 | Улаагчны хар нуурын байгалийн цогцолборт газрын аялагчдын хамгийн их очдог гол цэг болох Зэгэстэй нуурт 2, Уртын булгийн адагт 1, нуурын дээд хэсэгт 1 тус тус хөрс рүү бохир нэвчихгүй кальцо байршуулсан, агааржуулагчтай соруулах шийдлээр хийгдсэн стандартын шаардлагад нийцсэн нийт 4 ариун цэврийн байгууламж, Отгонтэнгэрийн дархан цаазат газарт аялагчдын хамгийн их очдог гол цэг болох Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт хөрсөнд нэвчилтгүй, агааржуулагчтай соруулах шийдлээр хийгдсэн стандартын шаардлагад нийцсэн 2 байршилд баригдсан ариун цэврийн байгууламжийг бий болгосон. | 90 |
| 3.4.1.3 | | Амрах, үдлэх цэгүүд байгуулна | 2021-2024 | БОАЖГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 200 | 0 | 6 | 50 | Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт аялалын гол маршрутын дагуу түр буудаллах цэгийн тохижилтын ажлыг Амь Ус Трейд ХХК хийж гүйцэтгэсэн.Тосонцэнгэл, Их-Уул сумын авто зам дагуу түр буудаллах цэгийн байршлыг тогтоож тэргүүлэгчдийн хурлаар батлуулсан. Мөн Сонгино сумд авто замын дагуу Улсын төсвийн хөрөнгөөр "Нутаг ус " нэртэй амрах үдлэх цэг байгуулагдсан. | 100 |
| 3.4.2.1 | "Улаагчны хар нуур", "Отгонтэнгэр хайрхан"-ыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ | "Улаагчны хар нуур", "Отгонтэнгэр хайрхан"-ыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ | 2022-2024 | БОАЖГ | ОНТ, ТХ, БӨХ | 20,000 | | 40000 | 5000 | "Улаагчны хар нуур, Мухартын голын эргийн хамгаалалтыг сайжруулах" ажлыг Эко грийн түнш компанитай гэрээ байгуулан гүйцэтгэсэн. 2023 оны төсвийн тодотголоор Отгонтэнгэр хайрханы өвөрт ариун цэврийн 2 байгууламжтай болсон. | 100 |
| 3.4.3.1 | Завхан аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх маркетингийн арга хэмжээг хэрэгжүүлнэ | "Zavkhan.travel" сайт, апликэйшн, видео контент, танилцуулгыг олон нийтэд сурталчлан, хэрэглээг | 2021-2024 | БОАЖГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 40 | 250 | 4500 | 10 | "Zavkhan.travel" сайт эвдрэл гарсан. Видео контент, танилцуулгыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар фэйс бүүк хуудсаар дамжуулан мэдээ мэдээллийг хүргэж байна. | 50 |
| 3.4.3.2 | | Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилна | 2021-2024 | БОАЖГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 60 | 30% | 60% | 15 | Улаанбаатар Трейвэл Экспо-2023, Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн-2023" 2023 оны 05 дугаар сарын 19-21-ны өдрүүдэд "Мишээл Экспо" ОУҮХТ-д зохион байгуулагдаж аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Аймгийн аялал жуулчлалын холбоо, Жуулчны баазууд, Зочид буудал зэрэг үйлчилгээний байгууллагын төлөөлөл нийт 16 аж ахуйн нэгжийн 20 иргэн оролцлоо. Тус үзэсгэлэнгийн үеэр аялалын маршрут, бүтээгдэхүүн үйлчилгээ, орон нутгийн онцлог, 9 гайхамшиг, түүх дурсгалын газруудаа сурталчилсан эмхэтгэл, нугалбарыг бэлтгэж 500 гаруй иргэдэд тараасан. Бүгд Найрамдах Тува Улс, Завхан аймгийн хамтын ажиллагааг сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах хилийн боомтын үйл ажиллагааг сэргээх зорилгоор "Арцсуурь боомтын сэргэлт" арга хэмжээг Тэс суманд 2023 оны 08 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Зохион байгуулагдсан арга хэмжээний үеэр аймгийн Үзэсгэлэнт газрууд, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, албан байгууллагуудын мэдээллийг Орос хэл дээр гаргуулан нугалбар, гарын авлага, 8 өдрийн аяллын маршрут, брошюрыг 450 гаруй иргэнд тараасан. | 100 |
| 3.4.3.3 | | Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулна | 2021-2024 | БОАЖГ,СЗДТГ | ОНТ, ТХ, БӨХ | 40 | 4 | 4 | 10 | ITM үзэсгэлэн, Нүүдэлчдийн соёлын фестиваль, Хилийн үзэсгэлэн худалдаа, Тэсийн голын нүүдэлчдийн соёлын арга хэмжээнүүдэд аймгийн БОАЖГ, АЖХ, Соёлын газрын мэргэжилтнүүд болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөл оролцож, туршлага солилцож чадавхжсан. | 70 |
| **3.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **87.14** |
| **3.5** | **Эрчим хүчний найдвартай, аюулгүй тогтвортой байдлыг хангана** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5.1.1 | Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлнэ | Улиастай суманд дулааны станц барина | 2022-2024 | АЗДТГ | УТ, ТХ | 20094 | | 1 | 10000 | Улиастай сумын Жинст багт 25 Гкал/цаг хүчин чадалтай дулааны станцын барилгын ажлыг эхлүүлээд байна. БНСУ-ын 13 сая 95 мянган америк долларын хөнгөлөлттэй зээлээр 8.4 км дулааны шугам, 11 дулаан дамжуулах төв баригдахаар төлөвлөгдөж Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бюксан инженеринг” ХХК, туслан гүйцэтгэгчээр “МЭЗ” ХХК шалгарч 2024 оны намар ашиглалтад оруулахаар барилга угсралтын ажил хийгдэж байна. Зуухны үндсэн барилгын суурийн ажил бүрэн дуусч тоног төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж байна. Үүнд: МЕХАНИК УГСРАЛТ - 10 Гкал-2ш, 5Гкал-1ш зуухны угсралтын каркас босгохоос эхэлж өнөөдрийн байдлаар халах гадаргуу, металл хийцийн угсралт 95%-тай байна. - Зуухны үндсэн эд анги болох экран хоолой, барбан, ус халаагч, агаар халаагч 100% угсрагдсан дундын циклийн угсралт 95%-тай байна. Нүүрс хүлээн авах барилгын суурийн ажил 6,8 м суулгахаар төлөвлөн 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхэлсэн боловч гадаргын усны ундрага их байсан учир ажил удааширч одоогийн байдлаар түлш дамжуулах системийн барилгын зоорийн давхарын ажил 90%-тай байна. Бутлуурын барилгын суурь, Конвейр 1,2-н суурь, утаа сорогчийн барилгын суурийн ажлууд тус тус дуусч буцаж булах ажил хийгдэж байна. Цахилгааны дэд өртөөний барилгын суурийн ажил 70%-тай хийгдэж байна. 2023 онд төлөвлөсөн ажлууд 90%-тай хийгдэж, дулааны станцын төслийн ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 34%-тай байна. | 50 |
| 3.5.1.2 | | 21-р зуун хорооллын инженерийн дэд бүтцийг бий болгоно. | 2021-2024 | ГХБХБГ,АЗДТГ | УТ | 2500 | 1.8 | | 500 | Хорооллын гадна цахилгааны ажилд 400кВА хүчин чадал бүхий 2 ширхэг дэд станцын барилга, тоног төхөөрөмжийн угсралт, 2000 м кабель шугам хоолойн угсралтын ажил хийгдэхээр төлөвлөгдөж. Дэд станцын барилгын ажил, кабелийн угсралтын ажил, дэд станцын барилгын ажил хийгдсэн. 2022 онд "Бат комплект" ХХК дулааны суваг, худаг, 2810 м шугам хоолой, хэрэглээний халуун усны шугам 2320 у/м, цэвэр усны шугам 1405 м, бохир усны 976 м шугам хоолойн угсралтын ажил хийгдсэн. Шугам дулаалах, сувгийн хучилт хийгдэж улсын комисс ажилласан. | 100 |
| 3.5.1.3 | | Сумдын доторх цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээг үе шаттай шинэчилнэ | 2022-2024 | ГХБХБГ,АЗДТГ | УТ | 2500 | | 25% | 500 | Тосонцэнгэл, Тэс, Цагаанхайрхан, Нөмрөг, Сантмаргаз сумдын цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд станцыг шинэчлэх, сайжруулах ажлын зураг төсөл боловсруулагдаж Сантмаргаз сумын ЦДАШ-ыг Дооно Ойгон ХХК шалгарч ажил хийгдэж байна. Мөн Цэцэн-Уул сум 2024 онд 0,4 кВТ-ын шугамыг шинэчлэн 35кВт-ын ЦДАШ тавихаар төсөвт санал оруулаад байна. | 30 |
| 3.5.1.4 | | Дулааны шугамын 2-р хэлхээний шинэчлэлийн ажлыг эхлүүлнэ | 2022-2024 | ГХБХБГ,АЗДТГ | УТ | 2500 | | | 1000 | Дулааны станцын 2-р хэлхээний шугам сүлжээний зураг төсвийг "Кингсний инженеринг консалтинг" ХХК хийж хүлээлгэн өгсөн. Дэд бүтэц (цэвэр ус, ариутгах татуурга, холбоо дохиоллын) ажлуудыг Эрчим хүчний сайдын багцад тусгуулахаар өргөн бариад байна. | 30 |
| 3.5.1.5 | | Сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ГХБХБГ,АУЭХ С | ТХ | 1000 | 0 | 300 | 500 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Алдархаан сумд 5 МВт-ын нарны цахилгаан станц баригдаж, Жавхлант цогцолбор сургуулийн хичээлийн А блокыг Газрын гүний дулаанаар халаалтыг шийдээд байна. Мөн Тэлмэн сумд 5 МВт-ын салхины станц баригдахаар төлөвлөгдөж судалгааны ажил хийгдэж байна. ‘’Ньюком’’ ХХК 2023 онд Завхан аймгийн нутагт сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгааг хийж байна. Энэ дундаа Шилүүстэй сумын Сайхан багийн 11,929 га газарт сэргээгдэх эрчим хүчний нөөцийг тогтоох судалгаа хийхэд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж байна. Энэхүү судалгаа амжилттай хийгдсэнээр эрчим хүчний томоохон нөөцийг зөв зохистой ашиглаж, хүлэмжийн хийг бууруулах, дулаарлын эсрэг сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх бодитой ажил болох болно. | 50 |
| 3.5.2.1 | Аймаг, сумын төвийн нэгдсэн халаалтад холбогдсон өрхийн тоог нэмэгдүүлнэ | Сумдыг төвлөрсөн халаалтад холбоно | 2021-2023 | ААН,АЗДТГ | БӨХ | 3400 | 18 | 24 | 1200 | Их-Уул сум төвлөрсөн дулаан, цэвэр усны шугам сүлжээнд холбогдсоноор Завхан аймгийн 24 сумаас 23 сум дулаан, цэвэр усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоод байна. Алдархаан, Отгон сумдын дулаан, цэвэр, бохирын төвлөрсөн шугам сүлжээ УТ-ийн санхүүжилтээр "Шинэ сум" төслийн хүрээнд хийгдэн ашиглалтад хүлээж авсан. Завхан аймгийн Улиастай суманд 25 Гкал/цаг хүчин чадалтай дулааны станцын барилгын ажлыг эхлүүлээд байна. БНСУ-ын 13 сая 95 мянган америк долларын хөнгөлөлттэй зээлээр 8.4 км дулааны шугам, 11 дулаан дамжуулах төв баригдахаар төлөвлөгдөж Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бюксан инженеринг” ХХК, туслан гүйцэтгэгчээр “МЭЗ” ХХК шалгарч 2024 оны намар ашиглалтад оруулахаар барилга угсралтын ажил хийгдэж байна. 10 Гкал-2ш, 5Гкал-1ш зуухны угсралтын каркас босгохоос эхэлж өнөөдрийн байдлаар халах гадаргуу, металл хийцийн угсралт 95%-тай байна. Зуухны үндсэн эд анги болох экран хоолой, барбан, ус халаагч, агаар халаагч 100% угсрагдсан дундын циклийн угсралт 95%-тай байна. Нүүрс хүлээн авах барилгын суурийн ажил 6,8 м суулгахаар төлөвлөн 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхэлсэн боловч гадаргын усны ундрага их байсан учир ажил удааширч одоогийн байдлаар түлш дамжуулах системийн барилгын зоорийн давхарын ажил 90%-тай байна. Бутлуурын барилгын суурь, Конвейр 1,2-н суурь, Утаа сорогчийн барилгын суурийн ажлууд тус тус дуусч буцаж булах ажил хийгдэж байна. Цахилгааны дэд өртөөний барилгын суурийн ажил 70%-тай хийгдэж байна. 2023 онд төлөвлөсөн ажлууд 90%-тай хийгдэж, Дулааны станцын төслийн ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 34%-тай байна. Дулааны станцын 2-р хэлхээний шугам сүлжээний зураг төсөв хийгдсэн байна. | 90 |
| **3.5 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **58.33** |
| **3.6** | **Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөжүүлнэ** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6.1.1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зам, барилгын ажлуудыг хийж гүйцэтгэнэ | Нөмрөг сумыг "Арц суурь" хилийн боомттой холбох 199 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулна | 2021-2024 | ЗТХЯ,АЗДТГ | УТ | 10,464 | 0 | | 8,350.0 | Нөмрөг-Арц суурийн хилийн боомт хүртэлх 159.5 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын тендерийг Зам, тээврийн хөгжлийн яаманд зарласан, гүйцэтгэгчээр Аварга зам ХХК шалгарч зураг төсвийн ажил хийгдсэн. ЗТХЯ-нд 2021 оны 12 дугаар сард хүлээлгэн өгсөн. | 100 |
| 3.6.1.2 | | Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулна | 2022-2024 | ЗТХЯ, АЗДТГ | УТ | 188,810 | | | 75,524 | Зам, тээврийн хөгжлийн яаманд тендер зарласан, гүйцэтгэгчээр "Ангад арвижих" ХХК шалгарч зураг төсвийг хийж хүлээлгэн өгсөн. Улиастайгаас Тайшир хүртэлх замын ТЭЗҮ хийгдсэн. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр замын ажлыг эхлүүлэхээр болсон. | 30 |
| 3.6.1.3 | | Улиастай сумын Богд, Чигэстэйн голд 290.3 у/м төмөр бетон гүүр барина | 2022-2024 | ЗТХЯ, АЗДТГ | УТ | 8,800 | | | 3,520 | Гүүрийн зураг төсөв хийгдэн магадлалаар орсон. 2023 онд УТ-т санхүүжилт шийдэгдээгүй тул барилгын ажил эхлээгүй байна. 2024 оны улсын төсөвт тусгагдан батлагдсан. | 30 |
| 3.6.1.4 | | Доной хөндийгөөс Улаагчны хар нуур хүртэлх 74 км хатуу хучилттай авто замыг барьж эхлүүлнэ | 2022-2024 | ЗТХЯ, АЗДТГ | УТ | 260,110 | | | 104,044 | Донойн нисэх буудлаас Улаагчины хар нуур хүртэлх 74 км хатуу хучилттай авто замын зураг төсөв хийгдэн магадлалаар орсон. 2023 оны УТ-т санхүүжилт шийдэгдээгүй хасагдсан. Иймд 2024 онд УТ-т санхүүжилт тусгуулах шаардлагатай байна. | 30 |
| 3.6.1.6 | | Зарим сумыг улсын чанартай хатуу хучилттай авто замтай холбоно | 2022-2024 | ЗТХЯ, АЗДТГ | УТ | 42,000 | | 30 | 10,000 | Яруу сум-26 км, Идэр сум-12 км, Түдэвтэй-7км, Сантмаргаз-50 км Цэцэн-Уул-36 км тус сумдыг хатуу хучилттай авто замтай холбохоор төлөвлөж байна. Идэр сум хүртэлх 12 км хатуу хучилттай авто замын зураг төсвийг "Эн Би Си Си" ХХК гүйцэтгэн БХБЯ-д хүлээлгэн өгсөн. | 0 |
| 3.6.1.7 | | Шаардлагатай газруудад сайжруулсан шороон зам, гүүр, хатуу хучилттай замын арчлалт засварыг хийж, шинээр барина | 2021-2024 | ЗТХЯ,АЗДТГ | УТ | 2200 | | 20 | 500 | ОНХС-ийн 17сая төгрөгийн санхүүжилтээр "Жинчин гранд" ХХК-тай гэрээ байгуулж, гэрээний дагуу барилгын ажил 100% хийгдэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. ОНХС-ийн 45,2 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэж, тендер зарлуулан "Жинчин гранд" ХХК шалгарч гэрээ байгуулан ажил 100% хийгдэж ашиглатад хүлээлгэн өгсөн. ОНЗС-ийн хөрөнгө оруулалтын 80 сая төгрөгийн санхүүжилтээр Нутгийн удирдлагын ордны зүүн талын авто зогсоолийг засварлахаар тендер зарлан "Эко эвсэг зам" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Тус ажил 80% гүйцэтгэлтэй байна. ОНТ-ийн 91.9 сая төгрөгийн санхүүжилтээр Улиастай сумын Богдын гол багийн "Хайрхан" дэлгүүрийн баруун уулзвараас БХТН-ийн гарц хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх, ОНТ-ийн 99.8 сая төгрөгийн санхүүжилтээр БХТН-ийн гарцаас 3-р сургуулийн урд гарц хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх, ОНТ-ийн 95.4 сая төгрөгийн санхүүжилтээр Улиастай сумын Богдын гол багийн 3-р сургуулийн урд гарцаас Төв цэнгэлдэх хүрээлэнгийн арын хашааны өнцөг хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх ажлуудын гүйцэтгэгчээр "Энх энэрлийн өргөө" ХХК шалгарч, 100% хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. ОНТ-ийн 87.5 сая төгрөгийн санхүүжилтээр Улиастай сумын Богдын гол багийн Төв цэнгэлдэх хүрээлэнгийн арын хашааны өнцгөөс Ган доной ХХК-ийн уурын зуух хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх, ОНТ-ийн 95.3 сая төгрөгийн санхүүжилтээр "Ган доной" ХХК-ийн уурын зуухнаас "Авто тээврийн төв" хүртэлх авто замын 2 талд явган хүний зам хийх ажлуудын гүйцэтгэгчээр "Ингүүмэл зам" ХХК шалгарч, 100% хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн. ОНТ-ийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр Улиастай сумын Жинст, Жаргалант, Чигэстэй багийн Хатуу хучилттай авто замуудыг нөхөж засварлах, ОНТ-ийн 19.9 сая төгрөгийн санхүүжилтээр Улиастай сумын Богдын гол, Товцог, Өлзийт багийн Хатуу хучилттай авто замуудыг нөхөж засварлах ажлуудыг "Төгс зам" ХХК гүйцэтгэн хүлээлгэж өгсөн. | 90 |
| 3.6.2.1 | Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна | Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна | 2021-2024 | АЗДТГ,ЗТХЯ | УТ | 350 | 3 | 7 | 50 | 2022 онд ОНХС-ийн 80 сая төгрөгийн санхүүжилтээр бага оврын 1 автобус авсан. 2023 онд ОНХС-ийн 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улиастай сумын хүүхдийн автобус авах ажилд "Жинчин гранд" ХХК шалгарч, HUYNDAI COUNTY загварын бага оврын автобус нийлүүлсэн. | 100 |
| **3.6 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **54.3** |
| **3.7** | **Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлагыг хэрэгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ** | | | | | | | | | | |
| 3.7.1.2 | Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг веб хувилбарт оруулан, иргэдэд нээлттэй байдлаар зохион байгуулна | 2021-2024 | ГХБХБГ,СЗДТГ | ОНТ | 9 | 3 | 15 | 2 | Аймгийн ГХБХБГ дээр төв суурин газрын систем шинэчлэгдэж, цахимд шилжүүлэх ажил хийгдсэн. Цахим системд тухайн сумын жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг веб хувилбарт оруулан иргэдэд нээлттэй байдлаар байршуулсан.24 сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалтын цахим системээр дамжуулан хэрэгжилтийг ханган хяналт тавьж, www.egazar.gov.mn болон “Е газар” гар утасны аппликейшнээр дамжуулан иргэд олон нийтэд нээлттэй сурталчлан, 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авах ажлыг цахимаар зохион байгуулан ажилласан. Мөн "Цахим шилжилт" аяны хүрээнд 24 сум, Төрийн болон ТББ-дад сургалт мэдээлэл хийж, Улиастай суманд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 256 иргэнд газрын лавлагаа мэдээллээр үйлчилсэн. Төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллахыг газрын даамлуудад 10 хоногийн хугацаатай үүрэг өгч жилийн эцэст 100 хувьд хүргэхээр ажиллаж байна. 2023 онд аймгийн хэмжээнд 1733 нэгж талбарт 897 га газрыг төлөвлөж журмын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ оны 11 дүгээр сарын 20-ний байдлаар 41.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Гүйцэтгэлийн хувь бага байгаа шалтгаан нь газрын харилцааны салбар ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд орж байгаатай холбогдуулан Монгол улс даяар 2023 оны 7 дугаар сараас бүх газар олголтыг зогсоосонтой холбоотой байна. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.7.2.1 | Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татварыг биржийн системээр хөгжүүлнэ | Аймгийн хэмжээнд газрын биржийг хэрэглээнд нэвтрүүлнэ | 2021-2024 | ГХБХБГ,СЗДТГ | ОНТ | 3 | 760 | 2565 | 1 | Газрын цахим бирж www.mle.mn сайтаас ашиглах 2022 онд 197 дуудлага худалдааг зохион байгуулж аймгийн төсөвт 402.9 сая төгрөг төвлөрүүлсэн бол 2023 онд 122 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулахаар төлөвлөж 75 нэгж талбарт 3520 га газрын дууудлага худалдааг амжилттай зохион байгуулан 190.8 сая төгрөгийг төвлөрүүлээд байна. Мөн 1359 зах зээлийн үнийн мэдээг цахим биржид байршуулсан байна. Энэ онд 11867 нэгж талбарт 1,014 тэр бум төгрөгийн ногдуулалтыг үүсгэж, 11 сарын 1-ний өдрийн байдлаар 48.9 хувийн төлөлттэй байна. 2023 оны байдлаар 25381 нэгж талбар байгаагаас өмчлөлийн мэдээллийн системд бүртгэгдсэн 7571 нэгж талбар, эзэмшлийн 8379 нэгж талбар мэдээллийн санд Э дугаар авч бүртгэгдсэн байна. | 90 |
| 3.7.3.1 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга, байгууламж, засвар, их засварын ажлыг эрэмбэлж үе шаттайгаар | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга, байгууламж, засвар, их засварын ажлыг эрэмбэлж үе шаттайгаар шийдвэрлэнэ | 2021-2024 | ГХБХБГ,СЗДТГ | ОНТ | 0 | | | | Аймгийн хэмжээнд 2020-2024 оны хооронд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг 30 гаруй шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэн аймгийн ИТХ-ын хуралдааны 13 дугаар тогтоолоор баталгаажуулж эрэмбийн дагуу зураг төслийн ажлыг хийлгэж Улсын төсөвт батлуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Дээрх эрэмбийн хүрээнд 2021 онд шинээр 11 төсөл арга хэмжээ, 2022 онд 22 төсөл арга хэмжээ шинээр батлагдсан бол 2023 онд Улсын хэмжээнд шинээр хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй. | 90 |
| **3.7 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **83.33** |
| **ГУРАВДУГААР БҮЛГИЙН ДҮН** | | | | | | | | | | | **74.67** |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| **4.1** | **Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгоно.** | | | | | | | | | | |
| 4.1.1.1 | Ухаалаг системд суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ | e-mongolia цахим хэрэглэгдэхүүнийг иргэдэд сурталчилж, хэрэглээг нэмэгдүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,СЗДТГ | УТ | 15.0 | 15% | 60% | | Дотоод удирдлагын нэгдсэн ERP, е mongolia системд төрийн байгууллагуудын 80 хувь нь холбогдсон бөгөөд ашиглалтын хувийг салбар бүрээр төрөлжүүлэн нэмэгдүүлэхээр ажиллаж байна.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын харьяа Завхан аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтэс шинээр байгуулагдаж операторын горим болон киоск машин, утасны аппликейшнаар үйлчилгээ хүргэх цэгүүдийн тоог нэмэгдүүлж, цахим үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх зорилгоор Улиастай,Тосонцэнгэл сумдад ОНТ,ОНХС-ын санхүүжилтээр “Хурдан” цэгийг байгуулж, Улсын бүртгэлийн хэлтэс, ГХБХБГазрын киоск машинаар болон Баруун бүсийн худалдааны төв, Нэгдсэн эмнэлэг, Шуудан үйлчилгээний газар, 24 сумын ЗДТГ-ын операторoор давхардсан тоогоор 15000 иргэдэд цахим үйлчилгээ үзүүлсэн. | 90 |
| 4.1.1.2 | | Төрийн архивын цаасан баримтыг тоон хэлбэрт шилжүүлэх ажиллагаар эрчимжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ,СЗДТГ | ОНТ | 50.0 | 215 хөмрөг, 226 данс | 295 хөмрөг 1046 данс | 15.0 | Төрийн архивын тасгийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 36 хөмрөгийн 505 дансны 506 хадгаламжийн нэгж баримтын 48,287 хуудас баримтыг сканердан цахим хэлбэрт шилжүүлж , 36 хөмрөгийн 505 дансны 500 хадгаламжийн нэгж, 49,374 хуудас баримтыг Document төрийн архивын баримтын мэдээллийн санд шивэн оруулж 188438 хүний нэр, агуулгыг тодорхойлон бичиж тоон хэлбэрт шилжүүлсэн. Цахим хувийн хэрэгжилт 100,9 %, мэдээллийг программд шивж тодорхойлон бичилт 103,0 % хэрэгжиж байна. Төрийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор А4, А3 сканер 2 ширхэгийг худалдан авахаар шийдвэрлэж 2023.11.08-ны өдрийн А/65 дугаар тушаал гарсан. | 100 |
| 4.1.2.1 | Төрийн албан хаагчдыг цахим хэрэглэгдэхүүн ашиглан сургана | Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд удирдлагын системийг нэвтрүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ,СЗДТГ | УТ | 50.0 | 5 | 25.0 | 15.0 | Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И Монгол академитай хамтран Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн erp. е mongolia портал системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж аймгийн Засаг даргын Тамгын газар болон хэлтэс агентлаг нэвтрүүлсэн бол энэ онд 24 сумдын 100 гаруй байгууллага тус системтэй холбогдож, төрийн албан хаагчдыг гарын авлагаар ханган ажиллаж байна. Системтэй холбоотой сургалтыг төрийн албан хаагчдад тогтмол хийж, заавар зөвлөгөө өгч байна. Мөн албан бичиг солилцооны дундын docX системд байгууллагууд ээлж дараатай холбогдож байна. | 90 |
| 4.1.2.2 | | Хурал, уулзалт зохион байгуулах онлайн танхимтай болно. | 2022-2024 | АЗДТГ,СЗДТГ | ОНТ, ТХ | 400.0 | | 6 | 50.0 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Сүлд танхимыг онлайн хурлын танхим болгох зорилгоор тохижилт хийж тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг 2022 онд Ивээж ХХК гүйцэтгэгчээр шалгаран орчин үеийн онлайн хурлын танхимтай болж 2023 онд бүх шатны төрийн байгууллагуудын цахим сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж байна. | 100 |
| 4.1.3.1 | Төрийн үйлчилгээнд чанарын стандартыг нэвтрүүлж, иргэд, олон нийт хяналт тавих | Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлсэн төрийн байгууллагыг нэмэгдүүлж, иргэдийн оролцоотой хяналт, үнэлгээг бэхжүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,СЗДТГ | ОНТ | 400.0 | 1 | 6 | 100.0 | Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх ажлын төсвийг 2024 оны төсөвт тусгахаар санал өгсөн. Бодлогын баримт бичиг болон хяналт шинжилгээ үнэлгээний ажилд иргэдийн оролцоотой хяналт үнэлгээг бэхжүүлэх ажлууд хийгдэж байна. | 70 |
| **4.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **90** |
| **4.2** | **Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгоно.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.1.1 | Иргэдээ сонсдог, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэр гаргадаг тогтолцоог бэхжүүлнэ. | Иргэдийн санал бодлыг сонсох цахим хэрэглэгдэхүүнийг бий болгоно. | 2021-2024 | АЗДТГ,СЗДТГ | ОНТ | 370.0 | 0 | 3 | 95.0 | Цахим аймаг болох зорилтын хүрээнд төрийн албан хаагч болон төрийн үйлчилгээний операторуудыг сургаж дадлагажуулах, мэдээллийн технологийн ур чадвар олгох сургалтуудыг ээлж дараатай зохион байгуулж, орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хэрхэн авах талаар заавар, зөвлөмж өгөн ажиллаж байна. Мөн төрийн үйлчилгээний талаар иргэдийн санал, хүсэлтийг цахимаар авч, холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн үүрэг чиглэл өгч, хуулийн хугацаанд хариуг хүргүүлэн ажилласан. Төрийн үйлчилгээг цахимаар авах сургалт зөвлөгөөг орон нутгийн иргэдэд тогтмол хүргэж байгаагийн зэрэгцээ аймгийн 100 жилийн ойгоор иргэдийн санал хүсэлтийг хүлээж авах, иргэд, байгууллагыг холбох зорилго бүхий call center байгуулан Цахилгаан холбоо ХХК-тай хамтран үр дүнтэй ажилласан. Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран иргэдэд И-Бизнес дээр шинээр нэвтэрч буй үйлчилгээний сургалт, Цахим хөгжлийг дэмжих хуулиудын танилцуулга сургалт зохион байгуулсан. Төрийн байгууллагуудаас давхардсан тоогоор 15000 гаруй иргэнд төрийн цахим үйлчилгээг үзүүлсэн байна. 2023 онд нутгийн захиргааны байгууллагууд нийт 1113 иргэдийн өргөдлийг хүлээн авснаас 1028 хүсэлт, 41 гомдол, 44 саналыг хүлээн авч хуулийн хугацаанд хариу өгч шийдвэрлэн нийт 40,0 сая төгрөгийн тусламжийг үзүүлэн ажилласан байна. | 100 |
| 4.2.2.1 | Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ,СЗДТГ | ОНТ | 0 | 10 | 45 | | Төрийн зарим үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэхээр 6 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан 117.2 сая төгрөгийг Нийгмийн халамжийн сангаас зарцуулсан. Үүнд “Завхан аймгийн Ахмадын хороо, “Хөтөч анд” бие даан амьдрах төв, зэрэг төрийн бус байгууллагууд өдрийн үйлчилгээг явуулж 110 иргэнд 5.3 сая төгрөг, Улаан загалмайн нийгэмлэг нь сургалт явуулж 50 иргэнд 2.0 сая төгрөг, Протез ортопед тусгай хэрэгсэл бэлтгэн нийлүүлдэг 11 байгууллага 7 сумын 774 иргэнд үйлчилгээ үзүүлж 109.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй Халуун сэтгэл эцэг эхийн холбоо, Амар амьдрал ТББ, Цогт фитнесс, АМКА dance байгууллагуудад орон нутгийн төсвөөс 45,5 сая төгрөгийн санхүүжилт олгож, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлсэн | 100 |
| 4.2.3.1 | Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ | Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ. | 2021-2024 | АЗДТГ,Төрийн байгууллагууд | ОНТ | 280.0 | 45.0 | 70 | 50.0 | Төрийн албан хаагчдыг сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу 2023 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулж хэрэгжүүлж ажиллалаа. Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний дагуу улсын төсвийн санхүүжилтээр эрхэлсэн болон ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт, дунд хугацааны давтан сургалт, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалт, богино хугацааны сургалтад нийт 300 гаруй албан хаагч цахим хэлбэрээр хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүллээ. Мөн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төрийн байгууллагуудад цахим сургалтыг салбар бүрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 2700 гаруй албан хаагч хамрагдсан байна. Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагуудад шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн болон сургалтын хэрэгцээний саналыг авч нэгтгэн холбогдох арга хэмжээг ажиллалаа. Түүнчлэн төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч, төсвийн шууд захирагч нарт төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах талаар хөдөлмөрийн дотоод журманд тусгаж, хөтөлбөр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байгаагийн зэрэгцээ холбогдох хууль, журмын дагуу үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг тогтмол олгож байна. Мөн нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар төрийн захиргааны зэрэг дэв авах болзол шаардлагыг хангасан 212 албан хаагчдад зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон. | 90 |
| 4.2.4.1 | Төрийн албан хаагчийн хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулна | Төрийн албаны бүх томилгоонд улс төрийн нөлөөллийг хязгаарлана | 2021-2024 | АЗДТГ, ТАЗСЗ,СЗДТГ | ОНТ | 50.0 | 85% | 91% | 15.0 | Төрийн албан хаагчдыг сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу 2023 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулж хэрэгжүүлж байна. Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний дагуу улсын төсвийн санхүүжилтээр болон байгууллагын зардлаар эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 22, дунд хугацааны давтан сургалтад 16, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтад 6, богино хугацааны сургалтад 118 албан хаагч хамрагдаж байна. Мөн төрийн байгууллагуудын 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу танхимын болон цахим сургалтыг салбар бүрээр зохион байгуулсан. Мөн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 7 хоног бүрийн "Пүрэв" гарагийн сургалтад хэлтэс, агентлагийн дарга нар болон аймаг, сумдын ЗДТГ-ын дарга мэргэжилтнүүдийг хамруулан энэ ажил тогтмолжсон.Түүнчлэн төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч, төсвийн шууд захирагч нарт төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах талаар хөдөлмөрийн дотоод журманд тусгаж, хөтөлбөр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг өгч хяналт тавин ажиллаж байна. Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн сул орон тоог нөхөх захиалгыг үндэслэн 2023 онд тусгай шалгалтыг 6 удаа зохион байгуулж, төрийн захиргааны удирдах 11, төрийн үйлчилгээний удирдах 23, төрийн захиргааны гүйцэтгэх 106, туслах 4 орон тоо нөхөгдсөн байна. | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.5.1 | Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг өндөржүүлж, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ | Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг өндөржүүлж, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ | 2021-2024 | АЗДТГ, ТАЗСЗ,СЗДТГ | ОНТ | 50.0 | 68.0 | 62.0 | 5.0 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Төрийн албан хаагчийн хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулах, төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг өндөржүүлж, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Хөгжлийн жилийн төлөвлөгөө болон төрийн байгууллагуудын, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ тусган, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласны дагуу 5Ш арга хэмжээ болон Төрийн албаны зөвлөлөөс өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудын хүний нөөцийн томилгоонд хяналт шинжилгээ хийж, заавар зөвлөмж өгч ажилласан. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинэчлэн батлагдаж, төрийн байгууллагуудад хуулийн танилцуулга, сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна. Сумдын Засаг даргын Тамгын газрын болон төрийн байгууллагуудын ёс зүйн тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн, дээд шатны байгууллагуудад хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. | 90 |
| 4.2.6.1 | Авлигаас ангид аймаг байна | Авлигаас ангид аймаг байна. | 2021-2024 | АЗДТГ | ОНТ | 80 | 81% | 88.2% | 20.0 | Энэ онд НҮБ-аас Авлигын эсрэг конвенц батлагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан “Дэлхий нийтээрээ авлигын эсрэг нэгдье” уриалгыг дэвшүүлэн, тус конвенцод нэгдсэн улс орон бүр зорилтот үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласны дагуу олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийнхээ хүрээнд "Авлигын эсрэг НЭГДЬЕ" үндэсний хэмжээний нөлөөллийн аяныг эхлүүлж, Завхан аймаг уг аянд нэгдэн Улиастай сумын орох гарах самбар, мөн Улиастай сумын “Чигэстэй голын гүүр”-ний хэсэгт “Нэгдье” аяны сурталчилгааны самбарыг байрлуулсан. 2023 оны авлигын эсрэг төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. "Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомж" сэдэвт сургалтыг сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нар, төрийн захиргааны албан хаагчдад зохион байгуулж, нийт 500 гаруй албан хаагч хамрагдлаа. Аймгийн ЗДТГ шудрага байдлын үнэлгээгээр аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газруудаас 79.5 оноогоор 2 дугаар байрт шалгарсан байна. | 100 |
| 4.2.7.1 | “Аз жаргалтай ажлын байр” арга хэмжээг хэрэгжүүлнэ | “Аз жаргалтай ажлын байр” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | ОНТ, БӨХ | 80 | 0% | 100.0% | 20.0 | "Аз жаргалтай ажлын байр" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар ЗДТГ-ын даргаар ахлуулан ажиллуулж, бүх шатны төрийн байгууллагууд хэрэгжилтийг хангаж, төрийн албан хаагчдыг сургаж дадлагажуулах, ажлын байрны ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн ажлуудыг ээлж дараатайгаар зохион байгуулж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд ажлын орчин нөхцөлийг сайн бүрдүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор зөөврийн болон суурин компьютер, принтерээр хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажлын байрны засвар тохижилтыг хийсэн. 2023 онд төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг томилох эрх бүхий албан хаагчдын саналыг үндэслэн зохих журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар олгож, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу урамшуулал олгон ажиллаж байна. Мөн төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үндэслэн ур чадварын нэмэгдлийг тогтмол олгож байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тайлант онд 6 албан хаагчид орон сууц авахад нь зориулж, тус бүр 6000,0 /зургаан сая/ төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | 100 |
| 4.2.8.1 | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн онцлог үйл явдлыг сурталчлан ард иргэдэд түгээнэ | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн онцлог үйл явдлыг сурталчилж, ард иргэдэд түгээнэ | 2021-2024 | АЗДТГ | ОНТ | 80 | 120 | 150 | 30 | Завхан аймагт болж буй онцлох үйл явдлын мэдээ мэдээллийг орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ард иргэдэд чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэн ажиллаж байна. 2023 онд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр 100 гаруй, Монголын Үндэсний Олон Нийтийн телевизээр 35 удаагийн мэдээлэл нэвтрүүлж, орон даяар үзэгчдэд хүргэлээ. Завхан толь сонин, Монголын үнэн сонин, Мэдээллийн эрин үе зэрэг хэвлэлүүдтэй гэрээ хийж хамтран ажиллахаас гадна орон нутгийн телевизүүд, сошиал сувгуудаар мэдээ, мэдээлэл дамжуулан сурталчилсан. Завхан аймгийн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээнүүдийг төвийн 2, орон нутгийн Air1 телевиз, сонин, сайт, сошиал орчинд шууд ба шууд бус дамжуулалт хийж ажиллав. ДДШТВ-ийн 928, 929 дүгээр сувгаар орон нутгийн мэдээ мэдээллийг 24 сум, бусад аймгуудад нэвтрүүлэх зорилгоор орон нутгийн телевизүүдтэй хамтран ажиллаж, 2023 онд Air1, Шинэ Завхан телевизийн 2 сувгаар нийт 9200 цагийн эфир нэвтрүүлж, төрийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж ажиллав. Аймгийн ЗДТГ-ын пэйж хуудас, вэб сайтаар орон нутгийн мэдээ мэдээллийг сурталчлан иргэдэд тухай бүрт нь хүргэлээ. Мөн аймгийн онцлох бүтээн байгуулалт, танилцуулга, видео контентыг хийж иргэдэд хүргэсэн. | 100 |
| **4.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **96.25** |
| **4.3** | **Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана** | | | | | | | | | | |
| 4.3.1.1 | | Хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ,ЦГ | ОНТ | 0 | 51.4% | 63% | - | Хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Сар шинэ-2023” “Илрүүлэлт-Оргодол Шийдвэрлэлт-2023”, “Мал мах-2023” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж эзэн холбогдогч нь тодорхойгүй гэмт хэргийг илрүүлж ажилласан. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд шаардагдах төсөв хөрөнгийг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас шийдвэрлүүлэн нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд чанар үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2023 онд хулгайлах төрлийн гэмт хэрэг 84 бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үеэс 25 нэгжээр буурсан. Энэ онд хулгайлах төрлийн 55 гэмт хэргийг илрүүлэн илрүүлэлт 63.1 хувьтай тооцогдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.1.2 | Гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ | Хүүхдийг гэр бүлийн хүчирхийлэл,гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ. | 2021-2024 | АЗДТГ,ЦГ | ОНТ | 0 | 0 | 70 | 0 | Хүүхдийг болзошгүй осол хэрэг, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүүхэд хамгаалал”, “Нуугдмал”, “Анзаар”, “Цогц сургалт”, “Хамтдаа хамгаалъя”, “Анзаар”, “Аюулгүй тоглоомын талбай”, “Хичээл эхэллээ”, “Аз жаргалтай хүүхэд”, “Анхаар хүүхэд” “Нууцалъя”, “Модуль сургалт”, Замын хөдөлгөөний цагаан толгой, “Ногоон гэрэл цагаан шугам” зэрэг арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг болон үйлдэж болзошгүй 304, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд уруу татан оруулагч 78, асран хамгаалах үүргээ үл биелүүлсэн, хүүхдийн хүмүүжил сөргөөр нөлөөлж хүүхэдтэй хэрцгий хандсан 20, насанд хүрээгүй хүний эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 43, Хүүхдийн нэгдсэн бүртгэлд 77, цахим орчинд гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй 142 иргэний мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын “Патрол-2” санд бүртгэлд оруулан баяжилт хийж ажилласан. Мөн хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт, Бидний дэм бусдад инээмсэглэл, Нэг тэрбумаараа тэмцье, Хар тамхины хор уршгийн талаар төрийн алба хаагч, эцэг, эхчүүдэд мэдээ мэдээлэл өгөх “Анзаар” хөтөлбөр, Эрсдэл нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, холбон зуучлах чиглэлээр “Хүүхэд хамгаалал хөтөлбөр”, үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг “Бие биедээ анхааръя, дээрэлхэхгүй гэдгээ амлая” хөтөлбөр, Олон улсын “Охид”-н эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан охидын эрх, аюулгүй байдлын талаар зөвлөгөө өгөх “Хүчирхэг охид” өдөрлөг болон сургуулийн багш, нийгмийн ажилтан нарын мэдээлэх үүргийг нэмэгдүүлэх, өсвөр үеийн хүүхэд залуучууд, бага насны хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 116 удаагийн сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан ба сургалтад ерөнхий боловсролын 30 сургуулийн давхардсан тоогоор 15200 орчим хүүхэд, 4500 орчим төрийн болон төрийн бус байгууллагын алба хаагчид хамрагдсан. | 100 |
| 4.3.1.3 | | Мэдээлэл, удирдлагын системийг боловсронгуй болгож, төв суурин газрыг камержуулна. | 2021-2024 | АЗДТГ,ЦГ | ОНТ | 40.0 | 61.4 | 67 | 10.0 | Иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ногоон бүс” арга хэмжээний хүрээнд Завхан аймгийн төвийг “Ногоон бүс” болгох, Аймгийн Засаг даргын А/410 дугаартай захирамжийг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган баталж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, худалдааны газар, төрийн болон төрийн өмчит байгууллагын камерт үзлэг шалгалт хийж “Теле камерын системийн техникийн ерөнхий шаардлага MNS 6423:2019” хангаж байгааг шалгаж ажилласан. Завхан аймгийн хэмжээнд 285-н аж ахуйн нэгж, байгууллагын 1969 камер байгаагаас гэмтэлтэй 525-н камер, хэвийн ажиллагаатай 1444, олон нийтийн эзэмшил бүхий газарлуу харсан 123 цэгийн 155-н ширхэг камер ашиглагдаж байгаа судалгаа гарсан. Мөн Улиастай сум бусад сумдыг ногоон бүс болгох чиглэлээр шинээр тавих камерын цэгийн судалгааг гаргаж, заавар зөвлөгөө авах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн дүн шинжилгээний шуурхай албатай хамтран Улиастай сумын 6-н багийн камер байршуулах цэг, тэнцүүг гаргаж аймгийн төвийн хэмжээнд 3 тэрбум 275 сая төгрөгөөр 415 цэгт 1000 камер байршуулах техникийн тодорхойлолт болон үнийн судалгааг гаргасан. | 100 |
| 4.3.2.1 | Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана | Улсын чанартай автозамын дагуух хяналтын постуудыг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана | 2021-2024 | АЗДТГ,ЦГ | ОНТ | 140.0 | | | 35.0 | Улиастай сумаас Улаанбаатар хот руу гарах чиглэлд буюу Мөрөн Улиастай чиглэлийн А1102 дугаартай хатуу хучилттай авто замд улсын дугаар илрүүлэгч дундаж хурдны LPR маркийн хяналтын камер суурилуулах тендерийг 5 дугаар сард зарлан “Оргил дельта трейд” ХХК шалгарч, камерын угсралт хийж гүйцэтгэн энэ оны 7 дугаар сард Их-Уул, Улиастай сумдын хяналтын цэгт зөрчил илрүүлэгч бүхий хяналтын камер суурилуулан хүлээлгэн өгсөн. Ингэснээр аймгийн хэмжээнд техникийн улсын үзлэгт ороогүй болон жолоочийн хариуцлагын даатгалын зөрчилтэй нийт 9134 зөрчил бүртгэгдсэнээс 115 зөрчилд 3,5 сая төгрөгөөр арга хэмжээ тооцсон. | 100 |
| 4.3.2.2 | | Улсын чанартай авто зам дагуух сумдад олон нийтийн цагдаа ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ,ЦГ | ОНТ | 40.0 | | 30.0 | 10.0 | Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, аймаг, сумдын засаг дарга нарт 2022 оны эрүү, хэв журмын нөхцөл байдал, цагдаагийн газраас авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайланг танилцуулж, 2023 онд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, аймгийн болон сумдын төвийг камержуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээ, алба хаагчдыг ажиллах нөхцөл боломжоог сайжруулах чиглэлээр шаардлагатай техник, тоног төхөөрөмж, төсөв хөрөнгийг шийдвэрлэж, 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд 180.0 сая, сумдын жилийн төлөвлөгөөнд 473.3 сая, аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2023 оны төлөвлөгөөнд 52,5 сая, 13 сумын ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөнд 77,4 сая нийт 783.2 сая төгрөгийн төсөвт ажил арга хэмжээг тусгуулж шийдвэрлүүлсэн. Үүнээс аймгийн Засаг даргын Тамгын газар болон ИТХ-д Цагдаагийн газарт хариуцсан сум орон нутагт олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулах нэн шаардлагатай төсөл, төлөвлөгөө танилцуулан 33 сая төгрөгийг олон нийтийн цагдаагийн ажилтанд олгох урамшуулал байдлаар төсөв санхүүг шийдвэрлэсэн. | 100 |
| 4.3.3.1 | Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ | Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим сан e-khutuch.mn сайтыг өргөжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | ОНТ | 4.0 | 0% | 6% | | Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн эрх зүйн хөтөч буланг Цахим хөгжлийн хэлтсийн байранд шилжүүлэн байрлуулж иргэдийн хууль зүйн мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. | 100 |
| 4.3.3.2 | | Эрх зүйн хөтчийг бэлтгэнэ. | 2021-2024 | АЗДТГ | ОНТ | 10.0 | 3 | 48 | 3.0 | Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 2020 оны 12 дугаар сард аймгийн хэмжээнд 53 эрх зүйн хөтчийг бэлтгэсэн бөгөөд уг хөтөч нартай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, гэрээний хэрэгжилтийг 12 дугаар сард дүгнэн ажиллана. | 100 |
| **4.3 ДУГААР ЗОРИЛТЫНЫ ДҮН** | | | | | | | | | | | **100** |
| **4.4** | **Хараат бус шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.1.1 | | Шүүхийн шинжилгээний албаны гэмт хэргийн илрүүлэлт, нотлох ажиллагаанд орчин үеийн техник, тоног төхөөрөмж ашиглалтыг нэмэгдүүлнэ | 2021-2024 | АЗДТГ,ШША | ОНТ, БӨХ | 21.0 | 0 | 4 | 0 | Дүрс дуу бичлэгийн шинжилгээ хийх, хүний гадаад дүр төрх адилтгах, аман зураг гаргах, программ бүхий өндөр хурдны багтаамжтай цахим системтэй болоход дэмжлэг үзүүлсэн. Шүүхийн шинжилгээний албаны гэмт хэргийн илрүүлэлт, нотлох ажиллагаанд орчин үеийн техник, тоног төхөөрөмж ашиглалтыг нэмэгдүүлэхэд зориулан жилийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын дагуу техник, тоног төхөөрөмж худалдан авахыг хориглож олгогдох боломжгүй болсон. 2022-2023 онд шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагаанд зориулж жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд ямар нэгэн арга хэмжээ нэмж тусгагдаагүй байна. | 0 |
| 4.4.1.2 | | Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна | 2021-2024 | АЗДТГ,Архивын тасаг | ОНТ | 8 | 0 | 2 | 2 | Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд баримтын хамгаалалтын 420 ширхэг хайрцаг авч 1600 гаруй хадгаламжийн нэгж баримтыг хийж хадгалалтыг сайжруулсан, 36 хөмрөгийн 505 хадгаламжийн нэгж баримтыг цахим хэлбэрт оруулж мэдээлэл лавлагаанд ашиглаж байна. Мөн “Хантайшир уулын аймгийн Сэцэн сартуулын хошууны 1924 оны хүн амын данс, тайж нарын бүртгэл” хосгүй үнэт баримтыг крилл бичигт хөрвүүлэн, нөөц хувь үүсгэн хадгаламжийн нэгж бүрдүүлж архивласан. | 100 |
| 4.4.1.3 | Орон нутагт хууль сахиулах байгууллагын чадавхыг бэхжүүлнэ | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангаж, ажиллах орчныг сайжруулна. | 2021-2024 | АЗДТГ,ШША | ОНТ, БӨХ | 190 | 6 | 8 | 50 | Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв нь энэ онд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч 51 хүн ( насанд хүрсэн 26, хүүхэд 25)-ийг 1-10 хоногийн хугацаатайгаар 184 хоног хамгаалах байранд байрлуулан, аюулгүй байдлыг хангаж, хохирогчдод шаардлагатай багц үйлчилгээнүүдийг төлөвлөн үзүүлсэн. Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хохирогчдод сэтгэлзүйн зөвлөгөө өгөх орчинг бүрдүүлэн, амьдрах ухааны сургалтад хамруулж, 4 улирлын хүлэмж байгуулан өргөст хэмх, улаан лооль тариалж, хүлэмжний дотор хэсэгт сэтгэл зүйн булан байгуулж, утсаар 12 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан. Нэг цэгийн үйлчилгээний төвийн эрх зүйчийг "И тусламжийн арга зүй", "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, насанд хүрэгчидтэй ажиллах кейс үйлчилгээ" зэрэг 10 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт хамруулж чадавхжуулсан байна. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй "Гүүд нэйборс" олон улсын төрийн бус байгууллагаас зохион байгуулсан "Сэтгэл зүйн зөвлөгөөний цогц сургалт"-нд Нэг цэгийн үйлчилгээний төвийг хамруулан 2,1 сая төгрөгийн сэтгэл зүйн үйлчилгээний цогц хөтөлбөрийн багц хэрэглэгдэхүүнээр хангасан. | 100 |
| 4.4.1.4 | | Хууль зүйн туслалцааны төвөөс төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөллийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ. | 2021-2024 | АЗДТГ,ШШГГ | ОНТ | 20.0 | 253 | 300 | 2.5 | Хууль зүйн туслалцааны төвийн аймаг дахь нэгжийн үйл ажиллагааг дэмжиж шаардлагатай ажлын өрөө тасалгааг аймгийн Нутгийн удирдлагын ордны дөрвөн давхарт гарган ажиллах нөхцөлөөр хангаад байна. Улсын өмгөөлөгчийн интернетийн зардал болон үйл ажиллагааны холбогдох бусад зардлыг аймгаас хариуцан дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | 100 |
| 4.4.1.5 | | Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна. | 2021-2024 | АЗДТГ,0277 цэргийн анги | ОНТ | 20.0 | 0 | 2 | 5 | 0277 дугаар анги нь усан хилийн эргүүл хийдэг тул усан хил хамгаалалтын техникийг сайжруулах, хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс торон саадыг сайжруулах ажлыг Хууль зүйн сайдтай хамтран зохион байгууллаа. Хууль зүйн сайдад хүсэлт өгсөний дагуу 0277 дугаар ангийн цогцолбор барилгын төсвийг 2023 оны төсөвт тусгуулсан. Арц суурь авто замын шалган нэвтрүүлэх боомтод байрлалын хамгаалалтад ашиглах гадна зориулалтын камер 5 ширхэг, дотор камер 4 ширхэг, PTZ 360 камер 1 ширхэг, бусад дагалдах хэрэгсэл, гэрэлтүүлгийн шон, гэрэл тус бүр 10 ширхэгийг авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. | 100 |
| 4.4.2 | Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас | Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлнэ | 2021-2024 | ТЕГ-ын харьяа Завхан аймаг дахь хэлтэс | ОНТ | 26 | 90% | 98% | 8 | Завхан аймаг дахь Салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн даргаар батлуулан ажиллаж байна. /нууц/ Аймгийн Засаг даргын захирамжаар кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан. | 100 |
| **4.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН** | | | | | | | | | | | **83.33** |
| **4.5** | **Гадаад бодлого, харилцаа хамтын ажиллагааг тогтвортой хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | |
